Abstract: The article is devoted to the analysis of the problems of constitutionalism from the position of criminal law; it also presents a brief excursion into the history of this state-legal phenomenon, which, as a phenomenon/concept, is considered from the position of protecting and ensuring individual rights in modern conditions using the example of the Russian Federation. The author examines the essential characteristics of constitutionalism, which are contained in criminal law.

Ключевые слова: права личности, конституционализм, уголовное право, охрана прав, права человека.

Keywords: individual rights, constitutionalism, criminal law, protection of rights, human rights.

Охрана и обеспечение прав личности в современном мире – это, пожалуй, один из постулатов современного законодательства любой страны, независимо от того, насколько реально он «работает» и каково его формальное закрепление. Отправной точкой для закрепления прав человека в международном праве стала Всеобщая декларация прав человека (1948 г.), представляющая собой систему международных стандартов в этой сфере, но вместе с тем, в рамках национальных правовых систем каждое государство по своему усмотрению и с учетом своих традиций, включая религиозные, реализует потенциал этих правовых норм. Поэтому сложно давать объективную правовую оценку этому процессу.

Тем не менее, в международной правовой практике есть одно уникальное явление, понятие, концепция, теория – характеристик много, однако единого понимания которого до сих пор нет – позволяющее институт прав и свобод человека, личности рассматривать с позиции практикоориентированности, некой «приближенности» к реальному живому человеку. Речь идет о «конституционализме».

Конституционализм рассматривается традиционно как форма закрепления, наличия Основного закона страны – Конституции, то есть самого как такового документа. Это, прежде всего, формальное закрепление верховенства этого документа над иными законодательными национальными актами государства. Поэтому конституционализм, как правовое явление ассоциируется с понятием «правовое государство», где основными ценностями признаются личность, ее права и свободы, сила закона, суверенитет во всех своих видах [1], народовластие, разделение властей, политический плюрализм и парламентаризм. Таким образом, исторически считается, что конституционализм призван защищать человека от тирании государства, закрепляя правовой характер государственности. Подчеркнем, что общепринятого определения конституционализма так и не сложилось в научной литературе.

Известно, что генезис и эволюция института прав и свобод человека имеют давние корни и, собственно говоря, сущностно серьезного изменения не претерпели, расширились только сферы их применения. Вместе с тем, общепризнанным положением является тезис о том, что соблюдение и защита прав и свобод человека/личности является обязанностью государства.

Однако совершенно очевидно, что сущностные характеристики конституционализма, как основы охраны и обеспечения прав личности, приобретают иные очертания в такой специфически-государственной деятельности, как охрана общественного правопорядка и защиты от преступных посягательств, привлечения к уголовной ответственности в рамках реализации норм уголовного права, а значит, мер государственного принуждения.

При этом уголовное законодательство РФ, согласно ст. 1 Уголовного кодекса РФ [2], состоит из Уголовного кодекса и новых законов, предусматривающих уголовную ответственность и подлежащих включению в Уголовный кодекс. И основывается уголовное законодательство на Конституции РФ, что само по себе является проявлением конституционализма, в широком понимании этого термина, а также общепризнанных принципах и нормах международного права.

Анализируя принципы уголовного законодательства РФ, мы в первую очередь говорим об охране и обеспечении прав личности, поэтому принципы законности, справедливости, гуманизма и равенства граждан перед законом, на наш взгляд, представляют собой своеобразный механизм реализации конституционализма на практике.

Обеспечение прав человека возможно только при их формальном, то есть законодательном закреплении в соответствующих нормативных правовых актах [См.: 3, С. 109 – 114]. Соответственно, закрепленные принципы уголовного права фактически отражают сущностную характеристику конституционализма с позиции практики применения законодательных норм, более того, если сам конституционализм рассматривать как принцип, основополагающие начала построения современного государства, то положения ст. 1 Уголовного кодекса РФ [2] представляют собой те условия, которые необходимо учитывать в правоприменительной, судебной практике, практике судопроизводства.

Другими словами, конституционализм, как институт, в уголовном праве позволяет охранять и обеспечивать права личности, фактически реализуя положения ст. 2 Конституции РФ, которая гласит: «Человек, его права и свободы являются высшей ценностью. Признание, соблюдение и защита прав и свобод человека и гражданина – обязанность государства» [4]. Важно отметить также, что несмотря на реализацию идеи виновности в уголовном праве, судопроизводство осуществляется на законных основаниях и с учетом прав человека и гражданина.

Таким образом, можно сделать вывод о том, что конституционализм как принцип построения государства является реальной основой охраны и обеспечения прав личности в уголовном праве.

Список литературы

1. Журавлева И.А. Вопросы теории суверенитета как теоретической основы федерализма // Экономика, образование и право: вопросы теории и практики: сборник материалов Международной научно-практической конференции, сентябрь 2011 г. / под науч. ред. доктора экономических наук А.И. Барановского. – Омск: Изд-во АНО ВПО «Омский экономический институт», 2011.
2. «Уголовный кодекс Российской Федерации» от 13.06.1996 № 63-ФЗ (ред. от 04.08.2023) // https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/e8ecf933c52a85d9223094e0e7fbf52f0128d399/
3. Журавлева И.А. Принцип конституционализма в теории уголовного права // Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2022. №3 (82). 20 дахь жилдээ.

4. «Конституция Российской Федерации» (принята всенародным голосованием 12.12.1993 с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01.07.2020) //

https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_28399/ec8354bcf00aac2d2899fbf033c3ef963e91411e/

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, НИЙГМИЙН АЮУЛЫН ШИНЖ

CRIME AGAINST LAW ENFORCEMENT CASE PERCEPTION, SIGNS OF SOCIAL DANGER

В.Амарсанаа

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D),
цагдаагийн хошууч*

Товч агуулга: Өгүүлэлд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлохоос гадна “хууль сахиулагч” гэх ойлголтыг хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан байдал, тэдгээрийн хоорондын ялгааг гаргаж, энэ ойлголтыг нэг мөр хэрэглэх боломжийг эрэлхийллээ.

Abstract: In addition to describing the nature of the social danger of anti-law enforcement crimes, the article also discusses the concept of “law enforcement” in law and legal documents, makes a distinction between them, and seeks to apply this concept one line at a time.

Түлхүүр үгс: Засгийн төлөөлөгч, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, хууль сахиулагч, төрийн албан хаагч, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа.

Keywords: Government representative, public order, public safety, law enforcement officer, civil servant, normal functioning of public institutions.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”¹³ гэж тодорхойлон заасан үйл ажиллагаа нь хууль сахиулагчдын нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг онцлог тогтолцоотой. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг үр дүнтэй явуулах үндсэн нөхцөл нь хууль сахиулах байгууллагын алба хаагчид албан үүргээ үр ашигтай гүйцэтгэх явдал юм. Энэ утгаараа Ч.Беккариан тэмдэглэсэн “Аюулгүй байдлын эрх хэдий чинээ сайн хангагдана, төрөөс иргэдийн эрх чөлөө хэдий чинээ найдвартай баталгаажна, төдий чинээ ял, хариуцлага шударга байна”¹⁴ гэх үзэл баримтлалтай санал нэгдэж байна.

Гэмт хэргийн халдлагын зүйл, халдлагад өртөгч нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын нэмэгдэл шинж бөгөөд, Эрүүгийн хуулийн тусгай ангид хууль тогтоогчоос тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон урьдчилан заасан тохиолдолд, тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх, заавал тогтоох үндсэн шинж болно. Эрүүгийн хуулийн тусгай ангид халдлагын зүйл, халдлагад өртөгчийг хуульчилсан байдлыг судалж үзэхэд, хууль тогтоогч халдагын зүйл, халдагад өртөгч нь тодорхой нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцох Эрүүгийн эрх зүйн гол шинж болох, тухайн хэргийн нийгмийн хор аюулыг ихэсгэх нөхцөл байдал, шинж болох, төсөөтэй гэмт хэргийг ялган зүйлчлэх гол шалгуур нь болж байгаа тохиолдолд л хуульчилдаг ба үүгээр түүний Эрүүгийн эрх зүйн учир холбогдол тодорхойлогдоно¹⁵.

Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн халдлагад өртөгч нь хууль сахиулагч байна¹⁶. Хууль тогтоогч уг гэмт хэргийн халдлагад

¹³ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1992. №1.

¹⁴ Антология мировой правовой мысли : в 5 т. М., 1999. Т. 3. С. 155.

¹⁵ Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ. 2011. 57 дахь тал.

¹⁶ Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018. 411 дэх тал.

өртөгчийг хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон урьдчилан заасан учир, энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг задлан шинжлэхийн өмнө түүний халдлагад өртөгчийн талаар судлах шаардлагатай. 2002 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 230 дугаар зүйлд “Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх” гэх нэр томъёоны өргөн хүрээг хамарч, уг гэмт хэргийн хохирогч нь төрийн албан хаагч, олон нийтийн байцаагч байхаар хуульчилснаас гадна, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь тодотгох зорилгоор “...хэв журам хамгаалах” гэж тодотгосон бол одоо хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагч” гэх нэршлээр хязгаарласан. Уг хуулийн 4.2 дугаар зүйлд “Хууль сахиулагч гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно”¹⁷ гэж заасан. Уг тодорхойлолтоос үзэхэд, хууль сахиулагчийг цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдаас гадна хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээдүүдээр хязгаарлаж, Дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдаагийн алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн алба хаагч, Батлан хамгаалах яамны харъяа Зэвсэгт хүчний анги байгууллагын алба хаагчдыг орхигдуулжээ. Гэтэл нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийг тодорхойлолтод дурдсан байгууллагын албан хаагчдаас гадна, онцгой тохиолдолд цэргийн албан хаагч хүртэл гүйцэтгэдэг онцлогтой.

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцын 23 дугаар зүйл буюу “Шударга ёсыг тогтооход саад хийх үйлдлийг гэмт хэрэг болгох” гэх хэсэгт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалт орсон. Монгол Улс уг Конвенцод 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон бөгөөд, Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тус Конвенц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ёстой. Уг Конвенцын зорилго нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлыг үр өгөөжтэй шийдвэрлэх чиглэлээр талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Харин олон улсын бусад гэрээнд тухайн гэмт хэрэг агуулгаараа тусаагүй байна. Дээрх конвенцын дагуу оролцогч улс нь конвенцод туссан гэмт хэргийг шүүн таслахад саад учруулсан дараах үйлдүүдийг гэмт хэрэгт тооцохыг үүрэг болгосон. Үүнд: (a) бие махбодын хүч хэрэглэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх, амлалт өгөх, давуу эрх олгох байдлаар хуурамч мэдүүлэг өгүүлэх, мэдүүлэг өгөх, нотлох баримт гаргаж өгөхөд хөндлөнгөөс оролцох, (b) энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан бие махбодын хүч хэрэглэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх байдлаар шүүх, хууль сахиулагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, саад хийх гэмт хэргүүд хамаарна¹⁸. Ийнхүү тус конвенцын (b) хэсэгт тус гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчлах талаарх шаардлага тавьжээ.

Онц байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйл (Цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагчийн хүлээх хариуцлага)-д “Онц байдлын үед хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хууль зөрчсөн, бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөний баталгааг зөрчсөн цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагч нь хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ”¹⁹ гэж зааснаас онц байдлын үед цагдаагийн байгууллагын алба хаагчаас гадна цэргийн алба хаагч, төрийн албан хаагчид бүгд үүрэг гүйцэтгэдэг болохыг харж болохоор байна. Онц байдлын үед

¹⁷ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7. 4.2 дугаар зүйл.

¹⁸ United Nations Convention against Transnational Organized Crime. New York, 15 November 2000, https://treaties.un.org/doc/Treaties/2000/11/20001115%2011-11%20AM/Ch_XVIII.p.12.pdf.

¹⁹ Онц байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1996. №2. 21 дүгээр зүйл.

хэрэгжүүлэх онцгой арга хэмжээнд хэрэгжүүлэх ёстой үндсэн арга хэмжээнээс гадна дараах арга хэмжээг хуулийн дагуу гүйцэтгэх эрх үүсдэг. Үүнд:

1. Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа байгууллагыг тараах, бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах,

2. Хөл хорих, өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллагаас тусгайлан олгосон зөвшөөрлийн болон иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүйгээр гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хоногийн тодорхой цаг хугацаанд зорчихыг хориглох. Энэ заалтыг зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах, шаардлагатай гэж үзвэл албадан саатуулагдсан хүний бие, авч яваа эд зүйлд үзлэг хийх;

3. Шаардлагатай гэж үзвэл иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг шалгах, галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох бусад зүйлийг хууль бусаар авч явах буюу хадгалж байгаа, эсхүл хэрэглэж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа бол иргэдийн бие, орон сууц, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх;

4. Олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох;

5. Холбооны хэрэгсэл ашиглах тусгай журам тогтоох;

6. Нийтийн эмх замбараагүй байдлыг арилгахад саад учруулж буй улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох;

7. Онц байдал зарласан нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй оршин сууж байгаа бөгөөд онцгой дэглэм сахиулахад саад учруулсан этгээдийг байнга оршин суух газарт нь, эсхүл онц байдал тогтоогоогүй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж рүү албадан гаргах;

8. Зэвсэг, галт хэрэгсэл, хүчтэй үйлчлэх химийн хорт бодис, согтууруулах ундааны зүйл худалдах, тараахыг хориглох;

9. Иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг тээвэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох, шаардлагатай гэж үзвэл ашиглалтыг зогсоох буюу тэдгээрийг түр хураан авах зэрэг хамаарна. Эдгээр үүргийг гүйцэтгэх явцад цагдаагийн байгууллагын алба хаагчдаас гадна цэргийн алба хаагч, төрийн алба хаагчдыг үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан эсэргүүцэх, заналхийлэх, бие махбодид нь халдаж, гэмтэл учруулсан тохиолдолд, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасны дагуу, тусгай бүрэлдэхүүнтэй гэмт хэргээр зүйлчилж, хариуцлага хүлээлгэх ёстой. Гэтэл “хууль сахиулагч” гэх ойлголтод “цэргийн албан хаагч, төрийн албан хаагч” гэх нэршил хамаарахгүй байгаагаас шалтгаалан, зүйлчлэлийн асуудал өөрчлөгдөж, гэмт этгээд ял завших тохиолдол гарахыг үгүйсгэх аргагүй байна.

Хэдийгээр “хууль сахиулагч” гэх ойлголтыг Эрүүгийн хуульд тодорхойлсон боловч, үүнд хамаарах этгээдүүд нь “хууль сахиулах чиг үүрэг” гэх ойлголтод заагдсан зарим байгууллагын албан хаагчдыг хамааруулаагүй болох нь дараах тодорхойлолтоос харагдаж байна. Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “хууль сахиулах чиг үүрэг гэж цагдаа, дотоодын цэрэг, тагнуул, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын

алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно”²⁰ гэж өргөн хүрээний ойлголт болохыг харуулжээ. Тэгвэл төрийн албан хаагч гэдэгт “...төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг”²¹ ойлгохоор заасан. Тэгэхээр “төрийн албан хаагч” гэх ойлголт нь “хууль сахиулагч” гэх ойлголтоос хавьгүй өргөн хүрээг хамарсан төдийгүй, нийтлэг үйл ажиллагааны чиглэлийг багцалсан шинжтэй байна. “Хууль сахиулагч” гэх ойлголт нь “хууль сахиулах чиг үүрэг” гэх ойлголтын, тодруулбал, хууль сахиулах үйл ажиллагаа явуулах албан байгууллагуудын хамрах хүрээг өөртөө багтаасан ойлголт болж чадаагүй гэж үзэх үндэслэлтэй байна. Уг учир дутагдалтай байдал нь дотоодын цэрэг, гааль, авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчдыг тодорхойлолт (хууль сахиулагч гэх)-д огт дурдаагүйгээс үүдэлтэй юм. Хэрэв уг нэр дурдагдаагүй байгууллагуудын албан хаагчдыг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудал Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд зааснаар яригдахгүй байх эрсдэлтэйгээс гадна, шударга ёсны зарчим алдагдаж байна.

Тэгэхээр “хууль сахиулагч” гэх ойлголт нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдыг бүхэлд нь бус, зөвхөн тодорхой хэсгийг хамааруулсан шинжээрээ учир дутагдалтай байна. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийг практикт хэрэглэхэд хүндрэл учрахаас сэргийлэх, илүү тодорхой хүрээний албан хаагчдыг хамгаалах боломжийг нээх, хууль хэрэглээний асуудлыг хоёрдмол, салаа утгагүй тодорхойлох зорилгоор нэг бол “Хууль сахиулагч” гэх ойлголтыг илүү өргөн хүрээнд өөрчилж тодорхойлох, эсхүл Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд хамаарах этгээдийг “төрийн албан хаагч” гэж тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна.

Гэмт хэргийг зөвхөн үйлдэл, эс үйлдэхүй гэж тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд, түүний заавал байх нэг шинж бол нийгэмд аюултай байх шинж юм. Аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох гол шаардлага бол тэдгээр нь нийгэмд аюултай, өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан иргэн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд хохирол учруулсан, эсхүл тийм хор уршиг учрах бодит боломж бий болгосон байх явдал юм²².

Аль ч орны төрийн хэвийн үйл ажиллагааны чухал нөхцөл нь төрийн удирдлагын тусгай байгууллагын албан тушаалтны зохион байгуулалтын ажил байна. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт халдлага нь ард түмний нүдэн дээр, засаг, төрийг төлөөлөгчийн эрхэд халдах замаар гутаан доромжилж, хүчийг сулруулдаг. Энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж нь хууль сахиулагчдын өдөр тутмын үүрэг гүйцэтгэхэд нь саад учруулах замаар нөлөөлж, хэвийн үйл ажиллагааг нь алдагдуулах явдал юм. Үүнийг задлан тайлбарлавал, хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдгын хувьд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Тэд өдөр тутмын үүрэг гүйцэтгэхдээ нийгмийн ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдтэй шууд харилцаанд орж, хууль зөрчих явдлыг таслан зогсоох ажлынхаа явцад, зөрчил гаргасан болон гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн зүгээс гаргах эсэргүүцэлтэй нүүр тулж, хэл амаар доромжлуулах, халдлагад өртөх, гэмтэж, бэртэх асуудал түгээмэл тохиолдохоос гадна, бүр цаашлаад амь насаа алдах явдал гардаг нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлж байна. Уг урьдчилсан таамаглалыг үндэслэн, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлохын тулд нийгмийн аюулын шинж гэж чухам юу болохыг тодруулах шаардлагатай.

²⁰ Зөрчлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 15.2 дугаар зүйл.

²¹ Төрийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2018. №1. 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

²² Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018. 154 дэх тал.

Нийгмийн аюулын шинж нь хууль тогтоогч түүнийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөхөөс үл хамааран оршдог, объектив хүчин зүйл юм. Хэрэв хүнийг алах үйлдэлд Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхгүй боллоо гэхэд, нийгэмд хүнийг алах явдал энгийн үзэгдэл болж, хүч хэрэглэх явдал дээд цэгтээ хүрнэ. Нийгмийн аюулын шинж нь аливаа үйлдэл, эс үйлдэхүүд эрүүгийн хариуцлага хүлээлгэх цорын ганц, найдвартай хэмжүүр юм. Профессор С.Жанцан “Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар гэдэг нь гэмт үйлдэл, эс үйлдэхүүд эрүүгийн хуулийн хамгаалалтад авагдсан эрх, ашиг сонирхлын мөн чанар, үнэ цэнийг илэрхийлэх, хууль цаазын үнэлэмж юм”²³ гэж, харин профессор Г.Совд “Гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ гэдэг нь гэмт хэргийн объектив тал буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгэмд хор аюул учруулсны эрчим ямар хэмжээнд байсан үр дагавар, хор уршиг, шалтгаант холбоо зэргээр тодорхойлогдоно. Үүнд: үйлдлээ хэрэгжүүлсэн арга, хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, орчин, цаг хугацаа, учруулсан хохирлын хэмжээ, түүнээс уламжлах үр дагавар зэрэг олон асуудлыг хамааруулж судалсны үндсэн дээр дүгнэлт хийж болно”²⁴ гэж тус тус тодорхойлсон. Тэгэхээр гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж гэдэг нь прецедент (дараа дараагийн тохиолдлыг шийдвэрлэх туршлага болох анхан, үлгэрчилсэн жишээ) шинжийг агуулдаг, хүн, нийгэм, төрд мэдэгдэхүйц хохирол учруулдаг, шинэ гэмт халдлагын болзошгүй аюулыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авахуулахад хүргэдэг, зөвхөн гэмт хэргийн тухайд яригдах, объектив ба субъектив шинжийг агуулсан ойлголтыг хэлнэ.

Монгол Улсын иргэн төрийн хамгаалалтад оршиж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан. Үндсэн хуулийн заалтыг ягштал дагаж мөрдөх нь ардчилсан нийгэм батжин тогтох суурь болох ёстой. Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах төрийн баталгаа нь төрөөс тэдгээрийг хүлээн зөвшөөрч, мөрдлөг болгон, хамгаалах үүрэгтэй шууд холбоотой. Хамгаалалтын объект нь хувь хүн, нийгэм, төрийн аюулгүй байдал юм. Эдгээрийг Эрүүгийн хуулийг хэрэглэх замаар хэрэгжүүлэх боломжтой. Эрүүгийн хууль нь гэмт явдалтай шууд тэмцэх үүрэг гүйцэтгэдэг, тодруулбал, Эрүүгийн хуулийн үндсэн үүрэг нь хохирол, хор уршиг учруулах үйлдэл, эс үйлдэхүйгээс нийгмийг хамгаалах явдал юм.

Үндсэн хуульд заасан зорилгыг хэрэгжүүлэх гол түлхүүр нь нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нийтлэг үүргийг хэрэгжүүлэхээс гадна гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй хууль сахиулагчдын хэвийн үйл ажиллагааны үр дүн. Хууль сахиулагчид нийгмийн хэв журмыг сахиулах үүргээ үүргээ хэрэгжүүлэхийн тулд төрөөс бодлогын төвшинд хамгаалуулсан байх шаардлага зүй ёсоор тавигдана. Уг шаардлагын дагуу төрөөс хууль сахиулагчийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хамгаалалт тогтоосон нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд тусгалаа олсон. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол” гэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнийг “Галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж; хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол”²⁵ гэж хуульчилсан. Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлд заасны дагуу “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгохоор байна²⁶.

Цагдаагийн албаны тухай хуулийн 23.1 дүгээр зүйлд “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх

²³ Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ. 2009. 192 дахь тал.

²⁴ Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002. 77 дахь тал.

²⁵ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

²⁶ Мөн тэнд. 4.2 дугаар зүйл.

зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно”²⁷ гэж, 23.6 дугаар зүйлд “Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй”, хэрэв эсэргүүцвэл мөн 23.7 дугаар зүйлд “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”²⁸ гэж тодорхой заасан.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гэдэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, нийгэмд аюултай үйлдэл юм²⁹. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүлэгт багтаасан явдал нь уг гэмт хэрэг нь давхар объектойд гэмт хэрэгт хамаарахыг, тодруулбал, хууль сахиулагчийг эсэргүүцэж, эрүүл мэндэд нь халдах үйлдлээр нэгэн зэрэг төрийн хэвийн үйл ажиллагаанд халдаж байгаа болохыг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд, хоёрдугаарт, хууль сахиулагчийн эрүүл мэндийн халдашгүй байдалд халдаж буй нийгэмд аюултай үйлдэл болж байна. Энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийн талаар Ж.Авхиа “Засгийн төлөөлөгчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж нь гэмт этгээд албан тушаалтан болон олон нийтийг төлөөлөгчид хүч хэрэглэх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх замаар төрийн болон олон нийтийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулан, хууль сахиулагчдад хохирол учруулдаг, эсхүл хохирол учирч болзошгүй байдал үүсгэдэг байдлаар илэрнэ”³⁰ гэж оновчтой тодорхойлсон.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд “...хэд хэдэн бүлэг нийгмийн харилцаанд нэгэн зэрэг халдаж байгаа халдлага нь нийгмийн аюулын хэр хэмжээний хувьд бусадтай харьцуулашгүй өндөр” гэх үзэл санаа байдаг. Тэгэхээр хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан, хэд хэдэн нийгмийн харилцаанд халдаж, хохирол, хор уршиг учруулдаг байдлаараа нийгмийн аюулын шинж өндөртэй болох нь батлагдаж байна. Олон объектод нэгэн зэрэг халдах нь бусад бүх төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг үнэлж, тодорхойлох хэмжүүрүүдийн нэг мөн.

Хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн Тусгай анги “Хувь хүний эсрэг гэмт хэргүүд – нийгмийн эсрэг гэмт хэргүүд – төрийн эсрэг гэмт хэргүүд” гэсэн дараалсан тогтолцоотой. Гэмт хэргийг бүлгээр хуваахдаа, халдлагын чиглэлийг тооцож, харьцангуй чухал нийгмийн харилцаанд халдаж байгаа гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулийн Тусгай ангийн эхэн хэсэгт багтааж, чухлаас чухал байдал багатай гэх дарааллаар байршуулдаг. Тухайн нийгмийн үнэ цэнэ, эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсээс шалтгаалан, Эрүүгийн хуулийн тогтолцоо өөрчлөгдөж ирсэн түүхтэй. Жишээлбэл, 1942 оны Эрүүгийн хуулийн Тусгай анги “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд” гэсэн бүлгээр эхэлж, уг бүлэгт эх орноосоо урвахаас авахуулаад, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд багтаж байв. Хууль тогтоогч үндэсний аюулгүй байдлын дараах үнэ цэнийг засаг захиргааны журам гэж үзэн, хоёрдугаар бүлэг (Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсад онц аюул бүхий гэмт хэргүүд)-ийн 70 дугаар зүйлд “Засаг захиргааны журмыг зөрчих гэмт хэргүүд нь ардын хувьсгалт засаг төрийг түлхэн унагаах явдалд шууд зорилагдсан бус боловч засаг захиргаа ба улс, ардын аж ахуйн хэвийн үйл ажиллагааг эвдэх байдалд хүргүүлж, засаг захиргааны байгууллагад эсэргүүцлийг гаргах буюу тэдгээрийн ажиллагаанд саадыг учруулсан, мөн түүнчлэн хууль, тушаалуудыг дагаж үл биелүүлэх зэргээр засгийн алдар нэр ба

²⁷ Цагдаагийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ. 2017. № 8.

²⁸ Мөн тэнд. 23.7 дугаар зүйл.

²⁹ Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018. 410 дахь тал.

³⁰ Авхиа Ж. Уголовное право Монгольской Народной Республики. Особенная часть. М. 1978. С. 293.

хүчийг сулруулсан тийм явдлууд болно”³¹ гэж тухайлан заасан явдал нь төрийн хэвийн үйл ажиллагааг хангахад хууль сахиулагчийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй болохыг тод харуулсан.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь давхар объекттой гэмт хэрэг болохын хувьд нийгмийн аюулын шинж өндөртэйгөөс гадна зөвхөн хууль сахиулагчийн нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эх орны тусгаар тогтнол, үндэсний (гадаад, дотоод) аюулгүй байдлыг хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлийн нөсөр ажил, арга хэмжээг зохион байгуулан, явуулах, төрийн өндөр албан тушаалтнуудын амь бие, эрүүл мэндийг хамгаалах болон бусад төрлийн, нэн тэргүүний үйл ажиллагааны үр дүнд төрийн бүх шатны байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн тогтвортой байдал, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаа хангагдаж байдаг. Энэ утгаараа хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь албан тушаалтны үйл ажиллагаанд саад учруулснаар дээр дурдсан олон төрлийн үйл ажиллагаа хэвийн явагдахад шууд болон шууд бусаар нөлөөлж, улс оронд тогтворгүй байдал үүсгэх аюултай байдгаараа нийгмийн аюулын шинж өндөртэй гэмт хэрэгт зүй ёсоор тооцогдоно.


Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлох зорилгоор нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, цагдаагийн байгууллагын 170 алба хаагчийн дунд судалгаа явуулж, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг хэрхэн үнэлж байна вэ? гэх санал, асуулга явуулахад, судалгаанд оролцогчдын 3 хувь нь “нийгмийн аюулын шинж багатай” гэж хариулсан бол, 19.4 хувь нь “нийгмийн аюулын шинж дунд зэрэг”, 71.8 хувь нь “нийгмийн аюулын шинж өндөртэй” гэж хариулсан бол 5.8 хувь нь “хариулахад хүндрэлтэй байна” гэх хариултыг тус тус сонгосон байна. Үүнээс үзэхэд, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж өндөртэй болохыг судалгааны үр дүн харуулж байна. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийн илрэх хэлбэрийг судлах зорилгоор 170 албан хаагчаас хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж ямар байдлаар илэрдэг вэ? гэх асуултад, судалгаанд оролцогчдын 4.7 хувь нь “Нийтэд айдас төрүүлдэг” гэж хариулсан бол, 26.6 хувь нь “Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг”, 29.6 хувь нь “Төрийн байгууллагын хүчийг сулруулдаг” гэж хариулсан бол 39.1 хувь нь “Нийгмийн хэв журмыг алдагдуулж, олон нийтийн аюулгүй байдалд заналхийлдэг” гэх хариултыг тус тус сонгосон байна. Эндээс хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг үйлдэгдсэнээр төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдаж, төрийн байгууллагын хүч суларч, нийгмийн хэв журмыг алдагдаж, олон нийтийн аюулгүй байдалд заналхийлдэг болохыг харж болохоор байна.

Сүүлийн жилүүдэд хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоо нэмэгдэж, тэдний үйл ажиллагааг нийгэмд буруу үйлдэл хэмээн турхирах явдал өсөх хандлагатай байна. Нийгэм хөгжихийн хэрээр хүмүүсийн сэтгэхүй, мэдлэг, боловсролын төвшин ахиж, техник, технологийн хөгжлийг нэвтрүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах болсон явдал нь сайшаалтай боловч, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хууль сахиулагч, тэр дундаа цагдаагийн байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааг хууль бус мэтээр харагдуулах, тэднийг гутаан доромжлох, нийгэмд эзлэх байр суурийг нь алдагдуулах зорилгоор, бодит байдлыг гуйвуулсан шинжтэй мэдээ мэдээллийг цахим орчинд тараах болсон нь иргэдийн хууль сахиулагчдад итгэх итгэл алдагдахад тодорхой хэмжээгээр нөлөөлж, улмаар тэдний зүгээс тавьсан, хууль ёсны шаардлагыг нь үл биелүүлэх, цаашлаад эсэргүүцэл үзүүлэн, эрүүл мэндэд нь халдах нөхцөл үүсгэж байна. Тодруулбал, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 2013 онд 102

³¹ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 118 дахь тал.

бүртгэгдсэн бол, 2014 онд 115, 2015 онд 122, 2016 онд 74, 2017 онд 105, 2018 онд 157, 2019 онд 188, 2020 онд 197, 2021 онд 239³² бүртгэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх тусам нэмэгдэж байгааг дээрх тоон үзүүлэлт харуулж байх бөгөөд, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн гаралт цаашид улам өсөж, хууль тогтоогч болон хууль хэрэгжүүлэгчдийн анхаарлыг татсан, хүндрэлтэй асуудал болж хувирах урьдчилсан нөхцөл болох хандлага ажиглагдаж байна. Эдгээр статистикаас гадна уг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангасан олон үйлдэл нь цагдаагийн байгууллагад бүртгэгдэлгүй үлдсэн байх боломжтойг анхаарах нь зүйтэй.

График 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн тоон мэдээ (2013-2021 он)




Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг дээрх судалгаанаас харж болохоор байна. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллага 2018 онд хууль сахиулагчийг эсэргүүцэх 80 хэрэгт, 2019 онд 87 хэрэгт, 2020 онд 99 хэрэгт, 2021 оныд 127 хэрэгт, 2022 оны эхний 10 сарын байдлаар 101 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан статистик судалгаа гарсан байна³³.

График 2. Нийслэл болон орон нутагт хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг шалгасан байдал


Цагдаагийн Ерөнхий Газар. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн 2013-2021 оны тоон мэдээ.

³³ Улсын Ерөнхий Прокурорын Газар. 2018-2022 оны эхний 10 сарын байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээ.



Энэ төрлийн гэмт хэрэг нийслэл болон орон нутагт үйлдэгдсэн байдлыг харахад хоорондын харьцаа тийм ч их ялгаагүй харагдаж байгаа хэдий ч, хүн амын нягтаршил ихтэй, сууршлын бүс болох Нийслэлээс, харьцангуй цөөхөн хүн амтай, сийрэг, нягтаршил багатай орон нутгуудад энэ төрлийн гэмт хэрэг мөн адил ихээр үйлдэгдэж байна гэсэн дүгнэлт хийж болох юм. Энэ нь орон нутгийн иргэд хуулийн мэдлэг, мэдээлэл дутмаг, хууль сахиулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хэтэрхий эмзэгээр хүлээж авдаг, архидан согтуурах, ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой гэж үзэж байна. Орон нутагт ажлын байр хомс байдаг учраас иргэд хийх ажилгүй тул бүлэг бөөгнөрөл үүсгэн, архидан согтуурч, нийтийн хэв журам алдагдуулах явдал нэлээдгүй гардаг бөгөөд, үүнийг нь хууль сахиулах чиг үүрэг бүхий алба хаагчид таслан зогсоохоор хууль ёсны шаардлага тавихад тухайн шаардлагыг нь эсэргүүцэх, улмаар хууль сахиулагчийн бие, эрх чөлөөнд халдах асуудал гарсаар байна.

График 3. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн байдал



Дээрх тоон мэдээнээс, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхээр хэргийг шийдвэрлэж байгаа байдал алгуур өсөх хандлагатай болохыг харж байна. Мэдээж хэрэг, энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэх явдал ихсэхийг дагаад шийдвэрлэх хэргийн тоо өсөх нь ойлгомжтой юм.

Дүгнэлт

1. “Хууль сахиулагч” гэх ойлголтын талаар суурь судалгаа хийгдээгүй, судлаачдын зүгээс нэгдмэл байр сууринд хүрээгүй, Эрүүгийн хуульд заасан тодорхойлолт нь онол, арга зүйн үндэсгүй, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны чиглэлд хамаарах үүргээс улбаалан гаргаагүй гэх зэрэг олон алдаа, дутагдалтай байна. Эдгээр учир дутагдалтай байдлаас шалтгаалан, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийг практикт хэрэглэхэд хүндрэл учрахаас сэргийлэх, “хууль сахиулагч” гэх ойлголтыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх шалгуур шинжүүдийг судалж, тогтоох, хууль, түүний тайлбарыг олон салаа утгагүй тодорхойлох шаардлага тулгарч байна.

2. 2015 оны Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлийн аутентик тайлбарын “Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг хууль сахиулагч” гэсэн тодорхойлолт нь зарим талаар оновчтой боловч “хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд” гэж хэнийг ойлгох талаар нэгдсэн ойлголтгүй, тодорхойгүй байдлыг тодотгох хэрэгтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалахад (нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх) чиглэсэн ажил үүргийнхээ хүрээнд, хууль сахиулагчид гэмт хэрэг, зөрчил гаргагчдын зүгээс гаргах эсэргүүцэл, ширүүн тэмцэл, халдлагатай байнга нүүр тулж, үр дүнд нь төрийн хэвийн үйл ажиллагаа алдагдахаас гадна, хууль сахиулагчид амь нас, эрүүл мэндээрээ хохирох эрсдэлтэй байнга нүүр тулдаг учир энэ төрлийн гэмт хэрэг нь нийгмийн аюулын шинж өндөртөйд тооцогдоно.

4. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж гэдэг нь хүн, нийгэм, төрд мэдэгдэхүйц хохирол учруулдаг, шинэ гэмт халдлагын болзошгүй аюулыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авахуулахад хүргэдэг, зөвхөн гэмт хэргийн тухайд яригдах, объектив ба субьектив шинжийг агуулсан ойлголт гэж тайлбарлагдах бол хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гэдэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцсэн, нийгэмд аюултай үйлдэл гэж ерөнхий байдлаар тайлбарлаж болно.

5. Энэ төрлийн гэмт хэргийн үед гэмт этгээд хууль сахиулагчийн нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахаас гадна хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулдаг, хоёр харилцаанд нэгэн зэрэг халддаг, давхар объекттой гэмт хэрэг юм. Хэдий чинээ олон харилцаанд халдана, төдий чинээ нийгэмд аюултай гэмт хэрэг гэх жишгийн дагуу хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн нийгэмд учруулах хор аюул давхар объекттой байдлаар шууд тодорхойлогдоно.

Санал

1. “Хууль сахиулагч” гэх ойлголт нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдыг бүхэлд нь бус, зөвхөн тодорхой хэсгийг хамааруулсан шинжээрээ учир дутагдалтай болохыг дээр дурдсан. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийг практикт хэрэглэхэд хүндрэл учрахаас сэргийлэх, илүү тодорхой хүрээний албан хаагчдыг хамгаалах боломжийг нээх, хууль хэрэглээний асуудлыг хоёрдмол, салаа утгагүй тодорхойлох

зорилгоор нэг бол “Хууль сахиулагч” гэх ойлголтыг илүү өргөн хүрээг хамрах байдлаар өөрчлөх саналтай.

Ашигласан материал

1. Авхиа Ж. Уголовное право Монгольской Народной Республики. Особенная часть. М. 1978.
 2. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998.
 3. Антология мировой правовой мысли : в 5 т. М., 1999. Т. 3.
 4. Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ. 2011.
 5. Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Сурах бичиг. УБ. 2018.
 6. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ. 2009.
 7. Зөрчлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24.
 8. Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1992. №1.
 9. Онц байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 1996. №2.
 10. Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002.
 11. Төрийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2018. №1.
 12. Улсын Ерөнхий Прокурорын Газар. 2018-2022 оны эхний 10 сарын байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн тоон мэдээ.
 13. Цагдаагийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ. 2017. № 8.
 14. Цагдаагийн Ерөнхий Газар. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн 2013-2021 оны тоон мэдээ.
 15. Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.
- Цахим эх сурвалж:
16. United Nations Convention against Transnational Organized Crime. New York, 15 November 2000, https://treaties.un.org/doc/Treaties/2000/11/20001115%2011-11%20AM/Ch_XVIII, p.12.pdf.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

THE CRIME OF ILLEGAL MINING OF MINERALS PROBLEMS IN THE INVESTIGATION, SOLUTIONS

*Б.Цогтбаатар
ДХИС-н Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын
эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа*

Товч агуулга: Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийн мөрдөн шалгах, нотлох ажиллагаанд тулгамдаж буй гадаад, дотоод хүчин зүйлүүдийг тодорхойлж, цаашид шийдвэрлэх арга замын талаар өөрийн санал дэвшүүлсэн болно.

Abstract: The external and internal risk factors faced in the investigation and proof of the illegal mining of minerals have been determined, and suggestions have been put forward for further solutions.

Түлхүүр үгс. Хууль бус олборлолт, ашигт малтмал, гар аргаар олборлогч, экологи эдийн засгийн хохирол тогтоох, шинжээч, шинжээчийн дүгнэлт, мөрдөгч, бохирдол, үзлэг.

Keywords. Minerals, illegal mining, artisanal miners, ecological economic damage assessment, expert, expert opinion, detective, pollution, inspection.

Оршил

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, иргэдийн амьжиргаанаас хамааран, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралт 2016 онд 165, 2017 онд 330, 2018 онд 366, 2019 онд 489, 2020 онд 626, 2021 онд 601, 2022 онд 559 гэмт хэрэг үйлдэгдэн³⁴, түүний улмаас учирч буй хохирол нь жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Үүний дотор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг өсөж, учруулах хохирол, хор уршиг нь тухайн нутаг дэвсгэрээс хальж бүс нутаг болон улсын хэмжээнд нөлөөлөх болсон нь дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72 хувь, экспортын 90 хувийг дангаар эзэлдэг³⁵ манай улсын хөгжлийн үндэс болсон ашигт малтмал олборлох салбарт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилд эрчимтэй үйлдэгдэх болсон ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн хамгаалал талаас нь анхаар байгаа хэдий ч дотоод эрсдэлийн хүчин зүйлийн бодлоготой уялдуулан авч үзэх талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, дүн шинжилгээ хангалтгүй байна.

Ашигт малтмал хууль бусаар олборлох үйлдлийн онцлогийг дурдвал, зохион байгуулалттай, “нуугдмал, далд”³⁶ хэлбэрээр хэрэгждэг бөгөөд түүнийг нотлоход

³⁴ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2023. Уб., 2023. 216 дахь тал.

³⁵ Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2019 он. Уб., 15 дахь тал.

³⁶ Асуулгад оролцсон 172 ажилтны 150 буюу 85 хувь нь энэ гэмт хэрэг “нуугдмал, далд буюу төвөөс алсмагдал, сууршилын бүсээс хол, хөдөө хээр, очиход бэхшээлтэй газарт үйлдэгддэг ба ихэвчлэн бүртгэгдээгүй хэргийн шинжтэй” гэж хариулсан болно.

бэрхшээлтэй байдаг нь судалгаагаар тогтоогдсон. Тиймээс ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн мөрдөн шалгах болон нотлох ажиллагаанд тулгарч буй эрсдэлд хүчин зүйл, хүндрэл бэрхшээлийг судлан тэдгээрийг шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох, нотолгооны үр нөлөөг дээшлүүлэх нь энэхүү сэдвийг хөндөх үндэслэл боолсон.

Энэхүү сэдвийн хүрээнд хамруулан хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, нотлох ажиллагааны талаар доктор Б.Одонгэрэл³⁷, Я.Цэлмэн, эрүүгийн тагнуулын аргаар илрүүлэх талаар доктор П.Очбадрах³⁸, хохирол тогтоох ажиллагааны талаар биологийн доктор Г.Эрдэнэбаясгалан³⁹, эрүүгийн эрх зүйн талаар доктор Ж.Нямдулам⁴⁰, С.Гантулга, Б.Энхболд⁴¹, үндсэн хуулийн эрх зүйн талаас Д.Батболд⁴² нар өөрсдийн бүтээлийн зарим хэсэгт судалж иржээ.

Улс орнуудын хил дамнасан, ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Үндэстэн дамнасан зохион байгууллагатай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага нь энэ төрлөөр дагнасан судалгаа явуулдаг⁴³.

“Ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох” үйлдлээс “олборлох” гэж ялган оруулсан нь уг үйлдэл нийгмийн хор аюулаар хамгийн их, сүүлийн 10 жилд шүүхээр шийдвэрлэгдсэн 98 шийтгэх тогтоолд хийсэн судалгаагаар 92% нь “олборлох” үйлдэлд ял шийтгэгдсэнээс дүгнэхэд голчлон үйлдэгдсэн байх тул судалгааны сэдвийн нэршилд сонгон оруулсан. Мөн эрэн хайх ажиллагаа явуулсны дүнд олборлолт хийгддэг, олборлосны эцэст ашиглалт боловсруулалт хийгддэг тул дундын гол холбоос болгон авч үзэж “олборлох” үйлдлээр хайх, ашиглахыг төлөөлүүлсэн болно.

Үндсэн хэсэг

Дэлхийн зарим улс дахь ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэг

Латин Америкийн улс орнуудыг жишиг болгон сонгож, нарийвчлан судлах нь хожим Монгол Улсад ямархуу хэмжээний хохирол сүйрэл, эрсдэлт хүчин зүйл учирч болох таамаглалыг дэвшүүлэх, урьдчилан харах, үүсэх нөхцөл байдлаас гарах гарцыг эрэлхийлэх нэг чиглэл болох юм.

XXI зууны эхний арван жилд дэлхийн хамгийн том кокайн үйлдвэрлэгчид хууль бус алтны экспортын үнэ кокайны экспортын үнээс илүү болсныг анхаарах болжээ⁴⁴. АНУ болон бусад оронд ялангуяа Колумб, Мексиктэй “хар тамхины эсрэг дайн” зарлаж, Латин Америкаас АНУ-руу мансууруулах бодис худалдаалах гэмт хэргийн ашиг орлого огцом буурч байсан үед алтны үнэ өссөнөөр алтны уурхайн ашиг орлого ихээхэн нэмэгдсэн. Үүний үр дүнд, гэмт хэргийн бүлэглэлүүд мансууруулах бодисын худалдаанаас алт олборлолт руу шилжих явц ажиглагдаж байна.

Бүс нутгийн хувьд авч үзвэл, алт олборлолтын нэлээд хувийг хууль бус олборлолт эзэлж байна. Тухайлбал; Перугийн алт олборлолтын 28 хувь, Боливийн 30 хувь, Эквадорын 77 хувь, Колумбын 80 хувь, Венесуэлийн 80-90 хувь нь тус тус хууль бусаар олборлож байна.

³⁷ Одонгэрэл, Б. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.

³⁸ Очбадрах, П. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2021.

³⁹ Эрдэнэбаясгалан, Г. Амьдрах орчны үнэлгээнд тулгуурлан байгаль орчны хохирлыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох нь. Биологийн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2019.

⁴⁰ Нямдулам, Ж. Уголовно-правовая охрана отношений в сфере добычи полезных ископаемых по законодательству Монголии и Российской Федерации. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015.

⁴¹ Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. Уб., 2018.

⁴² Батболд, Д. Ашигт малтмал өмчлөл, ашиглалтын Үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.

⁴³ 2016 global initiative against transnational organized crime. All rights reserved

⁴⁴ www.GlobalInitiative.net (Хандалт: 2019 оны 5 сар)

Колумбын засгийн газрын эрх баригчдын үзэж байгаагаар Колумбын хувьсгалт цэргийн хүчний гэмт бүлэглэл⁴⁵ нь хууль бусаар алт олборлож улсын хил зөрчиж нэвтрүүлэн борлуулах замаар санхүүжилтийнхээ 20 хувийг бүрдүүлдэг, энэхүү бүлэглэлийн нэг “34 дүгээр фронт” дангаараа хууль бус олборлолтоос сар бүр 1 тэрбум ам.долларын ашиг олдог гэж тооцсон байна⁴⁶.

Перу улсаас 2014 онд тэрбум гаруй ам.долларын үнэтэй 35 тонн алтны контрабандын хэрэг үйлдэгдэж, Лима улсаар дамжуулан АНУ, Швейцар луу усан онгоцоор тээвэрлэгдсэн бол, Болив улсаас хууль бусаар олборлосон 68 тонн орчим алтыг Амазон болон хойд хилийн нутгаар гаргасан зэрэг нь манай улстай харьцуулахад 15-30 дахин өндөр хэмжээнд байна.

Судалгаанаас үзэхэд, Колумб улс 4.9 сая хүн амыг нүүлгэн шилжүүлснээс (10 колумб хүн тутмын нэг) 87 хувь нь ашигт малтмалын хууль бус олборлолт явагддаг Амазоны хилийн бүс нутгаас нүүлгэсэн болохыг харуулж байна. “Карнеги Амазон Мөнгөн ус” төслийн гар аргаар алт олборлогчид жил бүр Амазоны бүс нутагт байгаа гол мөрөн, нууруудад 30 гаруй тонн мөнгөн усыг хаядгаас нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувьд аюулгүйн хязгаараас 34 дахин өндөр түвшинд хүрч, тархины гэмтэлтэй хүүхэд төрж байна. Мөн Амазоны ширэнгэн ой их хэмжээгээр сүйрч ойролцоогоор 1680 км² ой устсан байна. Ихэнх ой чийглэг ойн эко бүс нутагт байгаа бөгөөд Гайана, Перугийн баруун урд хил, Амазоны сав, Бразилын Тапажос-Хингугийн чийглэг ой, Колумбын Магдалена хөндийн Урабагийн чийглэг ой устаж үгүй болж байна.

Гэмт хэргийн бүлэглэлүүд хүрэхэд хэцүү, хил орчмыг хязгаар бүс, газар нутгийг олж авч, хууль бус алт олборлолтыг харьцангуй бага эрсдэлтэй, өндөр ашигтай хийх, ашгаа хадгалах зуураа орон нутгийн газар нутаг, хүн амын дунд өөрийн эзэмшлээ хадгалахыг чармайдаг байна.

Монгол улсад үйлдэгдэж буй ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэг

Судалгаанаас үзэхэд, цагдаагийн байгууллагын бүртгэсэн хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн 12-15 хувийг “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэг эзэлж байна.

Хууль бус олборлолтын гэмт хэргийн үйлдлийн арга сүүлийн жилүүдэд улам нарийсаж, бүлэг зохион байгуулалттай, нууц далд хэлбэрт шилжсэн, хүн очиход бэрх хөдөө хээрийн нөхцөлд, хилийн бүс зурваст хяналтгүй үйл ажиллагаа явуулах, орон нутгийн төр, захиргааны алба хаагч нарыг ашиглан тэдний туслалцааг авах байдлаар ял шийтгэлгүй өнгөрч байгаа нь бүртгэсэн нэг хэргийн ард нуугдмал 2-3 хэрэг байна гэж дүгнэх үндэслэлтэй бөгөөд сүүлийн 5 жилд 624 гэмт хэрэг бүртгэсэн бол үүний цаана бүртгээгүй 1200 гаруй хэрэг үйлдэгдсэн гэж үзэхээр байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн 26-38 хувийг (624) хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг эзэлжээ. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг он дарааллаар авч үзвэл: 2016 онд 35, 2017 онд 104, 2018 онд 126, 2019 онд 136, 2020 онд 223, 2021 онд 175, 2022 онд 155 гэмт хэрэг үйлдэгдсэн⁴⁷ нь энэ төрлийн гэмт хэрэг төдийлөн буурахгүй байх хандлагатай илрэл.

Монгол Улсын хилийн бүс, зурваст нийт 246 аж ахуйн нэгж уул уурхай, ашигт малтмал хайх, ашиглах олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 195 нь хилийн зурваст байрлаж байна. Эдгээрийн үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэр нь хилийн 19 анги нэгтгэлийн хариуцсан зурваст ихэвчлэн говь, цөлийн бүсэд хамаарч байх ба 9618 хүн ажиллаж байгаа мэдээ⁴⁸ байна.

⁴⁵ FARC-Revolutionary Armed Forces of Colombia https://en.wikipedia.org/wiki/Revolutionary_Armed_Forces_of_Colombia (Хандалт: 2019 оны 6 сар)

⁴⁶ www.GlobalInitiative.net (Хандалт: 2019 оны 7 сар)

⁴⁷ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2023. УБ., 2023. 252 дахь тал.

⁴⁸ Хил судлал. (Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, сургалт, арга зүй, танин мэдэхүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2019. №01. 21 дэх тал.

Ашигт малтмал олборлох, ашиглахтай холбоотой хилийн дэглэмийн зөрчил 2010 оноос хойш хилийн зурваст 44, хилийн бүсэд 48 удаа үйлдэгдсэн⁴⁹.

Монголбанкинд (Төв банкны тухай хуульд “Монголбанк” гэж оноосон нэр заасан) тушаах алтны хэмжээ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 2016 оны 11 дүгээр сарын байдлаар худалдан авсан алтны хэмжээ түүхэн дээд хэмжээ буюу 17.6 тоннд хүрсэн байна. Үүнд иргэдийн Монголбанкинд тушаах алтны хэмжээ өссөн нь голлон нөлөөлж байгаа бөгөөд мөн оны эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 2,973 иргэн Монголбанкинд 10.6 тонн алт тушаасан⁵⁰. Хэдий тийм боловч нөөц тогтоосон газрын алтны тусгай зөвшөөрлийн эзэмшигч нь хуулийн этгээд байдаг бөгөөд бичил уурхайгаар дээрх хэмжээний алтыг олборлох боломжгүй зэргээс харьцуулж үзэхэд, 40 гаруй хувь нь эх сурвалж тодорхойгүй буюу хууль бус олборлолтой холбогдож байна.

2017 онд Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас орон нутагт явуулсан судалгаагаар хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлгүй 12 аж ахуйн нэгж 112.1 кг алтыг стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монголбанкинд тушаасан, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй гэх 19 аж ахуйн нэгж 597.9 кг алтыг стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монголбанкинд тушаасан, мөн стандарт хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын хэлтсээр 5603.9 кг алтанд сорьц тогтоолгосноос 55.5 хувь (3039.6кг) нь л Монголбанкинд тушаажээ⁵¹.

Өнөөгийн байдлаар 20 аймгийн 78 суманд 214 газарт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж байна.

Үндэсний статистикийн хороо, Мянганы сорилын сантай хамтран хийсэн судалгаагаар улсын хэмжээнд 60.0 мянга орчим хүн гар аргаар ашигт малтмалын төрөл болох алтыг олборлож байгаа ба тэдгээрийн 38.0-39.0 мянга нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг бол, 20.0 мянга орчим нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж. Тогтмол үйл ажиллагаа явуулдаг иргэд нь ихэвчлэн малчид байх бөгөөд цаг агаарын тааламжтай нөхцөлд мал өссөн үед тэдгээрийн тоо буурч эхэлсэн бол, улирлын чанартай ажиллагсад нь эмч, багш, оюутан голчлон ажилладаг ба мөн хятад улсын иргэд ч гар аргаар олборлолт явуулж байна. Тухайлбал, Ховд аймгийн Алтай сумын Мянган угалзтайн нуруу, Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон голын дээд эх, Сэлэнгэ аймгийн Ерөө сум Ялбагийн хөндий, Говь-Алтай аймгийн Чандмань, Дарви, Бигэр зэрэг сумдад олон тооны иргэн хууль бусаар улирлын чанартай алт олборлож байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг үйлдэж буй гэмт хэрэг тасралтгүй нэмэгдэх болсонтой холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/09 дүгээр тушаалаар цагдаагийн төв байгууллагын бүтцэд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Экологийн цагдаагийн албыг шинээр байгуулан ажиллаж байна. Үүний өмнө мөн сайдын 2020 оны А/126 дугаар тушаалаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газарт Экологийн шинжилгээний лабораторийг 5 орон тоотой байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эвдрэлд орж орхигдсон газар нутгийн ихэнх хувийг уул уурхайн хууль бус олборлолтын улмаас эвдэгдсэн газар эзэлж байна. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт ашигт малтмал хууль бусаар олборлож буй нөхцөл байдлын судалгааг⁵² 2019 оны байдлаар нэгтгэж үзэхэд, нийт 17 аймгийн 44 сумын нутагт 140 нэр бүхий байршилтай газарт, 6.524 иргэн оролцсон хууль бус олборлолт

⁴⁹ Хууль сахиулахуй. (Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл) Уб., 2020. №02 (24). 229 дэх тал.

⁵⁰ <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1319&tid=2>

⁵¹ Очбадрах, П. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2021.

⁵² Мөрдөн байцаах албаны тайлан 2019.

явагдсан байна. Уг үйл ажиллагаанд ашиглагдаж буй нийт техник хэрэгслийн хувьд экскаваторын тоо 321 ширхэг ба хүчин чадлын хувьд моторын эргэлт цагт D-300-аас D-3500, усан буу (скруббер-алт угаан цэвэрлэгч машин)-ны тоо 169 ширхэг, хүчин чадлын хувьд цагт 25-100 метр куб шороо угаах чадалтай, шороо зөөх машины тоо 379, хүчин чадлын хувьд 10-20 тонн даацтай байна.

Сүүлийн 10 жилийн (2010-2020 он) хугацаанд “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” 98 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Энэхүү 98 хэргийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд нийт эрүүгийн 43 хэрэгт, 102 тээврийн хэрэгслийг битүүмжлэн, улсын орлого болгох саналтай шүүхэд шилжүүлснийг 21 шийтгэх тогтоолоор 409.264.480 төгрөгийн үнэлгээ бүхий 43 тээврийн хэрэгслийг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн ашигт малтмал хууль бусаар олборлох 98 гэмт хэргийн 79.6%-д буюу 5 хэрэг тутмын 4-т нь гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийг хураан авах ажиллагаа явуулж, шийдвэрлүүлээгүй байна. Шүүхийн өмнөх шатны ажиллагаагаар 43 хэрэгт 102 тээврийн хэрэгслийг битүүмжилсэн байтал, шүүхээс 58 хувийг прокурорын санал, мөрдөгчийн битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгож өмчлөгчид буцаан олгохоор шийдвэрлэсэн нь анхаарал татаж байна. Нөгөө талаар улсын орлого болгон хураан авахаар шийдвэрлэсэн 43 тээврийн хэрэгслийн үнэлгээ 409.264.480 төгрөгөөр үнэлэгдсэн нь тухайн гэмт хэргийг үйлдэхэд ашигладаг өндөр үнэлгээ бүхий техник хэрэгслийг хураан аваагүй гэж үзэх үндэслэлтэй. Тухайлбал, уул уурхайн үйл ажиллагаанд ашигладаг дундаж үнэлгээтэй экскаватор нь 400.000.000 төгрөг⁵³-ийн зах зээлийн ханштай байдаг атал 10 жилийн хугацаанд мөрдөн шалгаж, шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэрэгт хураагдан, улсын орлого болсон тээврийн хэрэгслийн нийт үнэлгээ 1 экскаваторын үнэтэй тэнцэж байгаа нь уг ажиллагаа практикт ямар үр дүнтэй хэрэгжиж байгааг илэрхийлж байна.

Бид дээрх тоо баримтад тулгуурлан энэ төрлийн гэмт хэргийн гаралт болон мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж байна. Тухайлбал,

Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй хүчин зүйл:

1. Орон нутгийн удирдлагын хувийн сонирхол, авлига, хээл хахуулийн асуудлаас үүдэж, байгалийн баялаг ашиглах, олборлох, түрээслэх, газар нутгийн маргаантай асуудал ихээр гарч байгаа нь дотоодоос үүсэх аюулыг ихэсгэж байна⁵⁴. Тухайлбал, Баянхонгор⁵⁵, Дорноговь⁵⁶, Төв⁵⁷, Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, шат шатны засаг даргын захирамж, гэрээний заалтыг судлахад эвдэгдсэн газар нутгийг нөхөн сэргээхийн тулд, тусгай зөвшөөрөлгүйгээр олборлолт явуулахыг зөвшөөрсөн хэм хэмжээг тусгасан шинжтэй акт гаргасан байна.

2. Сүүлийн жилүүдэд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Газрын тухай, Ойн тухай, Усны тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхай ашиглах журам” зэргийг илт зөрчсөн “Нөхөн сэргээлт хийлгэх тухай” олон тооны тогтоол, шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэр нь сөрөг үр дагавар үүсгэсэн байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга, ИТХ-ын дарга нар 2015 онд 82

⁵³ https://www.unegui.mn/adv/5438046_hyundai-eksavator-2010/

⁵⁴ Хил судлал. (Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, сургалт, арга зүй, танин мэдэхүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2019. №01. 20 дахь тал.

⁵⁵ Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 8/4 дугаар тогтоол, мөн аймгийн засаг даргын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн №4 тоот Бөмбөгөр сумын нутагт нөхөн сэргээлт хийх гэрээний 1.4., 1.5-д “өөрөө болон үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүжүүлэх, утгуур ачигч 4, угаах төхөөрөмж 4 ширхэг” ажиллуулах заалт нь олборлолт явуулахыг дэмжсэн.

⁵⁶ Дорноговь аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/626 тоот захирамж. 2017 оны 01 тоот гэрээ.

⁵⁷ Төв аймгийн Заамар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03, 05 дугаар тогтоол, мөн сумын засаг даргын 2014 оны 02 тоот “Заамархаан ХХК-ийн гэрээт талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гурвалсан гэрээ”-ний 2 дахь заалт.

аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлтэй нөхөн сэргээлт хийх, зардлаа эвдэгдсэн газарт байгаа ашигт малтмалыг дахин олборлож олох эрх олгосон шийдвэр гаргасан.

3. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэг нь тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник ашиглан үйлдэгддэг. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техникийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураах зохицуулалт Эрүүгийн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хуульд тусгагдсан боловч Улсын дээд шүүхийн 2006 оны 01 тоот тогтоолоор “гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийнх нь өмчлөлийнх болох нь тогтоогдсон нөхцөлд улсын орлого болгоно” гэж тайлбарласнаар энэ заалтын хэрэгжилт зогсонги байдалд орсон.

Гэмт хэрэг үйлдэгсэд өөрийн өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглахаа больсон, бусдын эзэмшлийн өмч хөрөнгийг түрээслэх, түр хугацаагаар ашиглах болсон байна. Тухайлбал, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг сүүлийн 5 жилд 1976 бүртгэж шүүхээр 48,9 хувь буюу 851 хэрэг шийдвэрлэгдсэн ба эдгээр гэмт хэргийг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, тусгай зориулалтын техник хэрэгсэл 256 ширхгийг улсын орлого болгосон ба эдгээрийн ихэнх нь хууль бус мод бэлтгэл, агнуурын хэрэгт хураагдсаныг шүүхийн шийдвэрээс харагдана.

4. 2017 онд Эрүүгийн цагдаагийн эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаныхан гар аргаар алт олборлодог орон нутгийн харьяалалтай 10768 иргэн, хувиараа алт худалдан авах, борлуулах хэлбэрээр тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 201 ченж байгааг тогтоожээ⁵⁸. Орон нутагт алтыг худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар арилжааны банкаар гүйцэтгүүлэх боломж тэр бүр байхгүй байгаа нь алтны “ченж” нарыг төрүүлэх үндсэн шалтгаан болсон⁵⁹ байна.

5. Судлаачид 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 344 гол, горхи, 760 булаг шанд ширгэж, ундарга багассан⁶⁰ талаар дүгнэсэн нь ашигт малтмалын олборлолт, боловсруулалт явуулдаг аж ахуйн нэгжүүд алтны үндсэн болон шороон ордыг ашиглахдаа гадаргын болон гүний усыг хяналтгүйгээр ашиглаж байгаа явдал нөлөөлдөг байна. Мөн түүнчлэн хориглосон болон хязгаарласан химийн хорт бодисыг (мөнгөн ус, натрийн цианит) үйлдвэрлэлд ашиглахдаа цэвэршүүлэх, саармагжуулах ажлыг хийхгүйгээр хөрсөнд хаядаг нь хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, 2015 оны байдлаар 11 аймгийн 36 сумын нутаг дэвсгэрт 120 гаруй талбайд цианит натри, мөнгөн усаар бохирдсон 200 мянган гаруй тонн шлам хуримтлагдсан, 100 гаруй инженерийн байгууламжтай болон гар худгууд дээр тээрэм ажиллаж 54,3 га талбай бохирдсон⁶¹ гэсэн баримт байна.

6. Монголбанк 2017-2018 онуудад 20-22 тонн алт худалдан авч валютын нөөцийг нэмэгдүүлэхдээ алтны гаралт үүслийн талаар ямар нэг асуулгагүйгээр худалдан авсан нь банканд ч, алт тушаагчид ч ашигтай, үр дүнд нь гадаад валютын нөөц 750 сая ам.доллар, 2018 онд 830 сая ам.доллараар нэмэгджээ⁶². Алт олборлолт явуулснаар валютын нөөц нэмэгдэх сайн талтай ч, байгаль экологид учруулсан хохирол, нөхөн сэргээх зардал нь олсон ашгаас илүү өндөр байна. Монголбанк нь зөвхөн ашгийг бодож иргэд, аж ахуйн нэгжийн олборлосон алтны эх сурвалжийг шалгахгүйгээр шууд худалдан авч, алт тушаасан иргэд, аж ахуйн нэгжийн мэдээллийг нууцын зэрэглэлд оруулсан нь ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох, татвараас зайлсхийх, мөнгө угаах гэмт хэргүүдийг өөгшүүлсэн, гэмт хэрэг давтан үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ байдал одоог хүртэл засагдаагүй байна.

7. Манай улс эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон явдал олон улсын анхаарал, их гүрнүүд, үндэстэн дамнасан

⁵⁸ Эрүүгийн цагдаагийн газрын тайлан. 2018.

⁵⁹ Тогтвортой бичил уурхай төсөл. Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээ, түүний макро эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, бодлогын санал, зөвлөмж. УБ., 2021. 36 дахь тал.

⁶⁰ Хууль сахиулахуй. (Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2020. №02 (24). 230 дахь тал.

⁶¹ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын судалгааны тайлан. 2015.

⁶² Мөн тэнд

бизнесийн бүлэглэлийн сонирхлыг татах болжээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт “дэлхийн 23 улс, 687 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас гадна манай улсын хуулийн этгээдийн нэр дээр гадаадын 11 улсын хуулийн этгээд 1000 орчим ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг⁶³” нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд шинэ боломжийг олгох болсон ч түүний хажуугаар шинэ эрсдэлийг дагуулах болсон. Тухайлбал, судлаачид “манай улсын хилийн бүс, зурваст гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал, газрын тос олборлох явдал эрс нэмэгдэж, гадаадын ажиллах хүч олноор байрлаж ажиллах болсон нь орон нутгийн ард иргэдийн дургүйцлийг төрүүлж гадны иргэд, байгууллагын үйл ажиллагааг саатуулах, зогсоох, нутгаасаа хөөхийн зэрэгцээ ард иргэдийн үзэл бодол, үйл ажиллагааг дэмждэг зохион байгуулалттай бүлэг, эвсэл, холбоо байгуулагдсан⁶⁴” талаар дүгнэлт хийсэнтэй санал нэг байна.

Мөрдөн шалгах, нотлох ажиллагаанд тулгамдаж буй асуудал:

1. Ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд зайлшгүй хийгдэх байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг тогтоолгох шинжилгээний зардал цагдаагийн байгууллагын төсөвт байхгүйгээс хэргийн шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар 2019 оны 3 дугаар улиралд хууль бус олборлолттой холбоотой 25 гомдол мэдээлэл шалгаснаас гуравд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байна. Энэ нь байгаль экологид учирсан хохирлыг бодитой тогтоож чадахгүй байгаагаас шалтгаалсан.

2. Гар аргаар ашигт малтмал олборлогчид, техникумсын жижиг аж ахуйн нэгжүүд ашигт малтмал агуулсан газарт болон уурхайн үйл ажиллагаа явагдаад нөхөн сэргээлт хийлгүй орхигдсон талбай дээр тусгай зөвшөөрөлгүйгээр олборлолт, ашиглалт явуулах, нөхөн сэргээлт хийх нэрийдлээр эфель, галь дахин ашиглаж байгаа гэм буруугаа халхавчилсан шинжтэй үйлдлийг хууль ёсны үйлдлээс ялган тогтооход мөрдөгчийг сургах нь чухал байна. Тухайлбал 2017 онд явуулсан судалгаанд⁶⁵ 130 хүн хамрагдсанаас цагдаагийн албан хаагчийн хууль, дүрэм журмын мэдлэгийг хангалттай гэж үзсэн 14 хүн буюу 3.6 хувь нь үнэлсэн байдлаас харагдана.

3. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг шалгах, нотлох баримт илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх явцад эсхүл хэрэг прокурорын шатанд хянагдаж байх хугацаанд гэм буруутай этгээдүүд олборлолт хийсэн газраа техникийн нөхөн сэргээлт хийсэн тохиолдолд прокурор байгаль экологид учруулсан хохирлоо арилгасан гэж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй байна. Нөхөн сэргээлт хийх нь гэм буруутай этгээдийн үүрэг ба байгаль экологид учруулсан хохирлын тодорхой хувийг арилгаж байгаа асуудал болохоос хохирлыг бүрэн арилгасан асуудал биш. Гэхдээ техникийн нөхөн сэргээлт хийж ухсан шороогоо булж тэгшилснийг, биологийн нөхөн сэргээлт хийсэнтэй адилтгаж үзэх боломжгүй.

4. Ашигт малтмалыг хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа нь нотлох ажиллагааны онолд суурилсан, хуулиар тогтоосон хэм хэмжээний дагуу байгалийн элементэд учирсан хохирол, хор уршгийг нотолгооны зүйл болгон тогтоодог онцлогтой, тусгай мэдлэг шаардсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цогц юм. Гэтэл өнөөгийн мөрдөгч нар энэ шаардлагыг хангасан мөрдөн шалгах технологи ажиллагаа, мэдлэг хангалтгүй байна.

Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэг нь өөр бусад гэмт хэргийг дагуулдаг онцлогтой. Тухайлбал, хууль хяналтын байгууллагынхан, гааль, хил, банкны ажилтнууд ашигт малтмал хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, хахууль авах,⁶⁶ гэмт

⁶³ Хууль сахиулахуй. (Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2020. №02 (24). 230 дахь тал.

⁶⁴ Дашдаваа, Д., Ганболд, Ц. Муратхан, А. Хилийн аюулгүй байдал. Нэг сэдэвт бүтээл. УБ., 2021. 92 дахь тал.

⁶⁵ Энхболд, Б., Мөнхтуяа, П., Золзаяа, Г. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017. судалгааны тайлан. УБ., 2018. 106 дахь тал.

⁶⁶ Эрүүгийн 1802002720210 дугаартай хэрэг

хэрэг шалгах явцад нөлөөлөх оролдлого хийх⁶⁷ нь цөөнгүйн дээр хууль бусаар уурхай ажиллуулсан⁶⁸ талаарх хэргүүд шалгагдсан байна.

Дэлхий нийтэд “баялгийн хараал⁶⁹”, “холланд өвчин” гэсэн нэршил тодорхойлогдох болсон нь нийгмийн материаллаг баялгийн хуваарилалтад шударга ёс зөрчигдөх, эдийн засгийн өсөлт саарах, улмаар нийгэм улс төр, эдийн засгийн тогтвортой байдал алдагдах, авлига газар авах зэргээр илэрдэг⁷⁰ өргөн хүрээтэй ойлголт хэдий ч бидний судалж буй ашигт малтмалын хууль бус олборлолтын гэмт хэрэг нь “баялгийн хараал”-ыг бүрдүүлэгч хүчин зүйлийн нэг хэсэг гэж үзэх талтай.

Дүгнэлт

1. Эрүүгийн хуулиар “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалыг багтааж, түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг зөрчлийн хуулиар зохицуулжээ. Энэ нь байгалийн элемент, газрын хэвлийд учруулдаг хохирлыг төдийлөн тооцолгүй журамласан нь өмнөх хуулиас ухарсан зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл өмнөх хуулиар газрын хэвлийн хууль тогтоомжийн биелэлтийг бэхжүүлэхэд чиглэсэн, ашигт малтмалын төрөл зүйлээс үл шалтгаалан газрын хэвлийгээ бүхэлд нь хамгаалах мөн чанарыг агуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар зөвхөн ашигт малтмалын төрөл зүйлээр нь ялгаж эрүүгийн эрх зүйн хамгаалалтад авч байгаа нь төдийлөн оновчтой бус гэж дүгнэж байна.

2. Уул уурхайн олборлолт, ашиглалт, үнэт эдлэлийн худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр хариуцлагатай уул уурхайн хангамжийн сүлжээний стандарт тогтоож, мөрдүүлэх хэрэгцээ шаардлага бий болжээ. Өөрөөр хэлбэл, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ашигт малтмалын “нийлүүлэлтийн сүлжээ”, “нийлүүлэлтийн гинжин хэлхээ”-ний жишиг загвар боловсруулж, хэрэгжүүлснээр ашигт малтмалтай холбоотой хууль бус үйлдлийг мөрдөн шалгах, нотлох ажиллагаа тодорхой болно.

3. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн холбогдогчтой нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан “нөхөн сэргээлтийн гэрээ”-ээр халхавчлан хууль бус олборлолт явуулах боломж олгон, шалгалтад хамруулахгүй байх зэргээр дэмжлэг үзүүлж, хандив тусламж авдаг, ашиг хүртдэг хандлага тогтох талтай байна. Энэ гэмт хэргийг нотлох ажиллагаанд хамтран оролцсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийн гүйцэтгэсэн үүрэг, учирсан хохирлын хэмжээ, ашиг орлогын эх үүсвэрийг нуун далдалсан хэлбэр, эрх олгох болон хяналт шалгалтын чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас дэмжлэг үзүүлэх зэргийг мөрдөн шалгаж тогтоох ажиллагаа хангалтгүй, уг гэмт хэргийн нотолгооны зүйлийн жишиг, онцлог мөрдөн шалгах ажиллагааны практикт нэг мөр тогтоогүй байна.

4. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэгт шинжээч томилох, шинжилгээ хийлгэх ажиллагааны зардлыг эрх бүхий байгууллагаас тусгайлан төсөвлөж, олгодоггүйгээс нотолбол зохих байдлыг бүрэн хангаж чаддаггүй, гэмт этгээд ял завших боломжийг бүрдүүлж байна. Нөгөө талаар тусгай мэргэшлийн шинжилгээ хийх эрх бүхий төрийн байгууллага, нэгж байгуулагдсан нь дэвшилттэй ч эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг хэвшүүлэх, нарийн мэргэжлийн шинжээчээр бэхжүүлэх шаардлага бий болжээ.

5. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг үйлдэхэд ашигладаг өндөр үнэтэй тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техникийг битүүмжлэх, хураах,

⁶⁷ Эрүүгийн 1802002970163, 1802003770266 дугаартай хэрэг

⁶⁸ Эрүүгийн 1818005340348 дугаартай хэрэг

⁶⁹ “Баялагийн хараал”-ын талаар гадаадын зарим судлаачид тодорхойлсон. (Ацуши Ими: Баялгийн хараалаас зайлсхийх нь: Бостван ба бусад орнуудын туршлага, ОУВС. ...№054 (2007); Теодор Моран. Монгол Улсад баялгийн хараалаас зайлсхийх нь. ОУ-н эдийн засгийн Петерсоны хүрээлэн, Бодлогын судалгааны тайлан, РВ12-18 (2013) горилоч)

⁷⁰ Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. Үндэсний аюулгүй байдал ба уул уурхай. (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл) УБ., 2018. 13 дахь тал.

улсын орлого болгон шийдвэрлэх ажиллагаа бүрэн хийгддэггүй, мөрдөгчийн туршлага, мэргэшил хангалтгүй, алба хаагчийг тогтвортой ажиллуулах бодлого сул, техник хэрэгслийн хангамж дутмаг, мэргэшүүлэх, чиглэсэн сургалт хангалтгүй, Экологийн цагдаагийн алба шинээр байгуулагдан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тусгайлсан чиг үүрэгтэй ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай ч, тухайн албанд мэргэшсэн удирдлага, алба хаагч байхгүй, нийт алба хаагчийн 93% нь экологийн мэргэжилгүй байгаа нь анхаарал татаж байна.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах олборлох гэмт хэргийн талаарх онол, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр:

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...тээврийн хэрэгсэл ...тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд..." гэсэн заалтыг: "...гэм буруутай этгээдийн өмчлөлд байгаа эсэхээс үл хамааран хураан авах" гэж өөрчлөх;

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан "Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэрэгт ердийн болон цацраг идэвхт ашигт малтмал дээр түгээмэл тархацтай ашигт малтмалыг нэмж эрүүгийн эрх зүйн хамгаалалтад авах. Үүний тулд Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйл (Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих)-ийн 1 дэх хэсгийг хүчингүй болгох, үүнтэй уялдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дүгээр зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан зөрчил шалгах харьяаллаас "7.12" гэснийг хасах;

- Монгол Улсын Байгаль хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор: "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж, уг заалтыг практикт хэрэгжүүлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд нэг мөр хэвшүүлэх арга хэмжээ авах;

- "Европын холбооны зөрчилтэй ашигт малтмалын тухай хууль" (EU Conflict Minerals Legislation), АНУ-ын "Додд Франкийн тухай хууль" (Dodd-Frank Wall Street Reform And Consumer Protection Act), "Калифорний хангамжийн сүлжээ дэх ил тод байдлын тухай хууль" (CA Supply Chain Transparency Act) зэрэгт заасан ашигт малтмалын гарал үүслийг цэвэр болохыг тодорхойлох, ашигт малтмалын сайн туршлага болох "нийлүүлэлтийн сүлжээ", "нийлүүлэлтийн гинжин хэлхээ"-ний хүрээнд ашигт малтмал хууль ёсоор олборлосон болохыг нотолсон үндэсний стандарт боловсруулж, гэрчилгээжүүлэн, практикт нэвтрүүлэх;

- Ашигт малтмал хууль бусаар олборлосон хэргийн газарт үзлэг хийх ажиллагааг явуулах дараалал, зураглал үйлдэх аргачлалыг агуулсан хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийн хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, үзлэгийн явцад хураагдсан болон битүүмжлэгдсэн техник хэрэгсэл, эд зүйл, эд мөрийн баримтуудыг түр хамгаалах тухай дотоод журам батлах

Хоёр. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг мөрдөн шалгах, нотлох ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр:

- Мөрдөгчийг энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, нотлох ажиллагаанд орчин үеийн арга, техник, технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг хээрийн болон ажлын байрны нөхцөлд ашиглах талаарх мэргэшүүлэх сургалтад хамруулах. Тухайлбал, химийн аюултай болон онцгой хорт бодис илрүүлэх, элементийн анализ хийх хүчин чадалтай шинжилгээний явуулын лаборатори, нисэгчгүй нисэх хэрэгсэл буюу өндрөөс зураглал үйлдэх, бичлэг хийх, нуугдсан этгээд, техник хэрэгсэл илрүүлэх зориулалттай төхөөрөмж (дрон), цахим хянагч буюу зураг зүйн өндөр хурдны программ, орон зайн байрлал тогтоогч буюу GPS-ийн өндөр үзүүлэлт бүхий сүүлийн үеийн хувилбар, Comp.

stat, Crime mapping, CCTV зэрэг орчин үеийн smart систем, яриаг текст хэлбэрт хувирган шилжүүлдэг “Чимэгээ” программыг нэвтрүүлэх;

- Энэ төрлийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, тэр дундаа экологи-эдийн засгийн хохирол тогтоох тусгай мэдлэг бүхий шинжээч томилох зардлын тооцооллыг ЦЕГ-ын төсөвт суулгах, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий нэгжид маркшейдер, уул уурхай, ашигт малтмал, геоэкологи, ус, хөрс, газар зүй зэрэг нарийн мэргэжлийн шинжээчдийг сонгон, сургаж ажиллуулах, шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур, судалгаагаар тогтоогдсон эрдэм шинжилгээний хүрээлэн, лабораторийн шинжилгээ хийгддэг төрийн болон хувийн байгууллагуудын нөөц, бололцоог ашиглах, шинжээчийн бүрэлдэхүүнд ШШЕГ-ын эрх бүхий шинжээчийг оролцуулан, явуулдаг болох;

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх нэгжид тухайн салбарын, тодруулбал, уул уурхайн ашиглалтын, технологийн, баяжуулалтын инженерүүд, газар зүйч, геологич, хөрс судлаач, ургамал судлаач, химич мэргэжилтэй иргэдийг “Цагдаагийн ажил-Эрх зүй” (D103201) хөтөлбөрийн “Экологийн мөрдөгч” мэргэшүүлэх хөтөлбөрт сурган, цаашид тогтвортой ажиллуулах;

Ашигласан материал

1. Ар Монгол дахь хятадын худалдаа-мөнгө хүүлэл (1751-1911). Баримт бичгүүд.
 2. Одонгэрэл, Б. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -Уб., 2020.
 3. Эрдэнэбаясгалан, Г. Амьдрах орчны үнэлгээнд тулгуурлан байгаль орчны хохирлыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох нь. Диссертаци. -Уб., 2019.
 4. Батболд, Д. Ашигт малтмал өмчлөл, ашиглалтын Үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -Уб., 2020.
 5. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 1206-1910. I. -Уб.
 6. Очбадрах, П. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Диссертаци. -Уб., 2021.
 7. Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. Сурах бичиг. -Уб., 2018.
 8. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2023. -Уб.
 9. Авирмэд, Э., Дашцэдэн, Д., Совд, Г. Монгол хууль. -Уб., 1997.
 10. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. -Уб. 2019.
- Гадаад хэл дээрх эх сурвал:
11. 2016 global initiative against transnational organized crime. All rights reserved.

ЗАРИМ АЙМАГТ ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

ILLEGAL MINERAL EXPLORATION IN SOME AIMAGS, EXPLOITATION AND EXTRACTION OFFENCES AT THE PRE-TRIAL STAGE RESOLUTION

Г.Болор-Эрдэнэ

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн ахлах багш,
доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг шүүхийн өмнөх шатанд шалгаж шийдвэрлэхэд учирч байгаа хүндрэл бэрхшээл, энэ төрлийн гэмт хэргийг шалган шийдвэрлэх эрх бүхий төрийн байгууллагын хамтран ажиллах уяалдаа холбооны талаар үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тайлбарласан.

Abstract: In this article, the difficulties encountered in investigating and solving the crime of illegal mineral exploration, use, and extraction at the level of the police and prosecutor's organizations, as well as the cooperation between the government organizations authorized to investigate and solve this type of crime, were evaluated and the reasons were explained.

Түлхүүр үгс: Хууль бус уул уурхай, гомдол мэдээлэл гаргагч, гэмт хэрэг, авлига, байршил.


Keywords: Illegal mining, whistleblowers, crime, corruption, location.

Оршил

Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэргийн хөдөлгөөнийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд тогтмол өсөлттэй ажиглагдаж байна. энэ төрлийн гэмт хэрэг хамгийн ихээр бүртгэгдсэн Баянхонгор, Төв, Сэлэнгэ, аймагт энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, яллагдагчаар татсан прокурорын тогтоолд тус тус дүн шинжилгээ хийж гомдол мэдээлэл, хэрэг хянана шийдвэрлэхэд учирч байгаа хүндрэл бэрхшээл, талаар үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тодорхойлохыг зорьсон.


Үндсэн хэсэг

График 1. Хэрэг бүртгэлтийн хаасан хэрэгт гомдол, мэдээлэл гаргагчийн тоон үзүүлэлт



Баянхонгор, Төв, Сэлэнгэ аймгуудын хэмжээнд 2018.01.01 ний өдрөөс 2022.07-р сард (4.5 жилийн хугацаанд) хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах хэрэг бүртгэлтийн хаасан хэргийн тогтоолд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг гаргасан субъектүүдээр нь харьцуулж, дундаж үзүүлэлтийг гаргахад: **64%**-ийг цагдаагийн байгууллагын цагдаагийн алба хаагчаас; **23%**-ийг орон нутгийн иргэдээс; **13%**-ийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагаас цагдаагийн байгууллагад шалгуулахаар ирүүлсэн байна. Дээрх 3 аймагт энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн байгууллага гомдол мэдээлэл гаргаж байгаа орон нутгийн иргэдээс 10 хувь, цагдаагийн алба хаагчаас 51 хувиар бага гомдол мэдээлэл гаргасан байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагын алба хаагчид хамтран ажиллах талаар идэвх санаачилга гаргадаггүй. энэ төрлийн гэмт хэрэг зөрчил үйлдэгчид нь ихэвчлэн шөнийн цагаар, төв суурин газраас алслагдсан, газарт гэмт хэрэг үйлддэг. төрийн болон олон нийтийн байгууллагад ажилладаг ажилчид Зөвхөн ажлын цагаар л ажиллахыг эрмэлздэг нь энэ гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл маш бага гаргаж байгаа шалтгааныг харж болохоор байна.

График 2. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрийн гомдол, мэдээлэл гаргагчийн тоон үзүүлэлт




Дээрх 3 аймагт Цагдаагийн алба хаагчаас гаргасан гомдол мэдээллийн 36.3%-ийг, орон нутгийн иргэдээс гаргасан гомдол мэдээллийн 30.6%-ийг, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагаас гаргасан гомдол мэдээллийн 33%-ийг гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэгдээгүй, зөрчлийн шинжтэй гэсэн үндэслэлээр хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж хаасан.⁷¹

График 3. Хохирогчоор тогтоосон албан тушаалтнуудын тоон үзүүлэлт

⁷¹ Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 10 дахь тал).

ХОХИРОГЧООР ТОГТООСОН АЛБАН ТУШААЛТАН



Төв аймагт хаасан хэрэг бүртгэлтийн хэрэг дээр 66%-д “Байгаль орчны байцаагч”-ийг хохирогчоор, 34%-д “Засаг дарга”-ийг хохирогчоор; Сэлэнгэ аймагт 58%-д сумын “Засаг дарга” хохирогчоор, 34%-д “Байгаль орчны байцаагч” хохирогчоор, Баянхонгор аймагт 55%-д “Байгаль орчны байцаагч”, 36%-д “Засаг дарга”-ийг хохирогчоор тус тус тогтоон оролцуулсан байна. Дээрх 3 аймгуудад хохирогчоор тогтоож байгаа албан тушаалтнуудын дундаж үзүүлэлтийг гаргаж үзэхэд 51,6 хувьд нь Байгаль орчны байцаагчийг, 42 хувьд нь тухайн сумын засаг даргыг, 6,4 хувьд нь засаг даргын тамгын газрын мэргэжилтэн оролцуулж байгаа үзүүлэлтээс дүгнэхэд нийт хэрэг бүртгэлтийн хэргийн 51 дээш хувьд нь сумын засаг дарга нар өөрийн шууд удирдлага доор ажилладаг байгаль орчны байцаагч нарыг хохирогчоор томилж байгаа ажиглагдаж байна. Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 51 хувиас дээш хувьд нь хохирогчоор Байгаль орчны байцаагчийг засаг даргыг томилж байгаа нь байдлаас дүгнэж үзэхэд:

1. Байгаль орчны байцаагч гэсэн албан тушаалтан нь тухайн ажиллаж байгаа орон нутгийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийг төлөөлөх бүрэн эрхтэй эсэх, орон нутаг, төрийг төлөөлж энэ төрлийн гэмт хэрэг зөрчил үйлдсэн иргэн хуулийн этгээдээс учруулсан хохирлыг нэхэмжлэх эрхийг хуулиар олгоогүй атал хохирогчоор тогтоож байгаа буруу жишиг тогтоод байна.

2. Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн төрийн байгууллагын албан тушаалтан хамтран оролцсон хэрэгт хохирогчоор хэнийг тогтоох эрх зүйн нарийн зохицуулалт байгаа тул холбогдох хуульд энэ зохицуулалтыг нарийн тусгаж өгөх хэрэгцээ шаардлага байна.

Баянхонгор, Төв, Сэлэнгэ аймгуудын хэмжээнд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны эхний 07 дугаар сард (4.5 жилийн хугацаанд) “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” нийт хаасан хэрэг бүртгэлийн хэргийн 54.3 хувь нь тусгай зөвшөөрөлгүй, 45.7 хувь нь тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулсан байна.

“Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, үйлдлийг гэмт хэрэгт тооцно”⁷² гэж Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1-д тодорхой зааж өгсөн байхад нийт хаасан хэрэг бүртгэлтийн хэргийн 54.3 хувь нь тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан үйлдэл байгаа нь анхаарал татахаар байна.


⁷² Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

Гэмт хэрэгт хамтран оролцогсдын хувьд 3 аймгийг харьцуулан дундаж үзүүлэлтийг гаргаж Анх мэдүүлэхдээ ганцаараа үйлдсэн нь 42%, 2-3 хамтран оролцсон гэж 52% мэдүүлсэн байна.

График 4. Гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцогчдын тоон үзүүлэлт



График 5. Гэмт хэрэгт хамтран оролцогч нараас яллагдагчаар татагдсан хүний тоо харьцуулалт



Судалгааны үзүүлэлтээс дүгнэлт хийхэд, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахаас өмнө гэмт хэрэгт хамтран оролцогчдын 50 хувь нь ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэж мэдүүлсэн, 32.3 хувь нь 2-3 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон, 12.6 хувь нь 4-6 хүн хамтран оролцсон, 2.3 хувь 7 дээш хүн гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэж мэдүүлсэн байна.

Эдгээр гэмт хэрэгт хамтран оролцогч нараас Прокурор Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан тоон үзүүлэлтийг авч үзвэл 57.3 хувь нь ганцаараа гэмт хэрэг үйлдсэн, 18 хувь нь 2 хүн хамтран гэмт хэрэг үйлдсэн, 3.6 хувь нь 3 хүн хамтарч гэмт хэрэг үйлдсэн, 2.6 хувь нь 4 хүн хамтран гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн хэрэгт яллагдагчаар татсан байна.

Дээрх байдлыг тоон мэдээллийг харьцуулан үзэхэд ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдагчаар татагдсан хүний тоо 7.3 хувиар өссөн, 2-3 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон гэж яллагдагчаар татагдсан хүний тоо 14.3 хувиар буурсан, 4-6 хүн гэмт хэрэгт хамтран оролцсоноос яллагдагчаар татагдсан хүний тоо 10 хувиар буурсан байгаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тогтоох, үйлдэл холбогдлыг нотлох ажиллагаа хангалтгүй, мөрдөгч, прокурор нь гадны ямар нэгэн нөлөөлөлд автаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх, Хэргийн бодит байдлыг тогтоох” зарчим⁷³, Эрүүгийн хуулийн “шудрага ёсны зарчим” зөрчигдөж гэмт хэрэгт хамтран оролцогч нарыг хариуцлагаас чөлөөлөх асуудал байна гэж үзэж болохоор байгаа боловч гэмт хэрэгт хамтран оролцогч нарын үйлдэл холбогдолыг нэг бүрчлэн тогтооход гэмт хэрэг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий мөрдөгч улсын байцаагч нарын ур чадвар дутмаг байдаг талаар прокурортой хийсэн ярилцлагын үр дүнгээс харагдаж байгаа бол Мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас энэ төрлийн гэмт хэрэг зөрчилд хамтран оролцогч нарын үйлдэл холбогдолыг нэг бүрчлэн тогтоох, нотлоход шаардлагатай нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, тоног төхөөрөмж дутмаг байдал нь энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шийдвэрлэхэд сөрөгөөр нөлөөлж байна гэж дүгнэж байна.

Прокурортой хийсэн ярилцлагын хэсгээс: Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдаас анхны хэргийн газрын үзлэгийг маш дутуу хийдэг, хөндөгдсөн газрын хэмжээг зөрүүтэй, буруу хэмжиж тэмдэглэлд тусгадаг, мэргэжлийн байгууллагыг оролцуулдаггүй, хэргийн газар байсан техник хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийдэггүй, хэрэгт ач холбогдолтой эд зүйлийг хураан авдаггүй.

Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын хэсгээс: Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутмаг байдаг.⁷⁴

График 6. Хэрэг бүртгэлтийн хаасан хэргийн тоон үзүүлэлт



Төв аймгийн хувьд нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 29% хувийг мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдээгүй гэх үндэслэлээр, 68% хувийг зөрчлийн шинжтэй 3% хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн байна. Тухайн хэрэг бүртгэлийн хэргийг хүлээж авсан прокурор 100 хувь хэргийг хааж шийдвэрлэсэн.

⁷³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №23.

⁷⁴ Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 29 дэх тал).

Сэлэнгэ аймгийн хувьд нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 79% хувийг мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдээгүй гэх үндэслэлээр 11% хувийг зөрчлийн шинжтэй 9% хувийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлсэн бол тухайн хэрэг бүртгэлийн хэргийг хүлээж авсан прокурор 93% хувийг нь хааж, 7 хувийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн.


Баянхонгор аймгийн хувьд нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 86% хувийг мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдээгүй гэх үндэслэлээр 12% хувийг зөрчлийн шинжтэй, 2% хувийг яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлсэн бол тухайн хэрэг бүртгэлийн хэргийг хүлээж авсан прокурор 100 хувь хэргийг хааж тус тус шийдвэрлэсэн байна.

Төв аймгийн хувьд нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 68 хувийг зөрчил гэж үзсэн бол Сэлэнгэ аймгийн хувьд нийт хэргийнхээ 79 хувийг гэмт хэрэг үйлдэгдээгүй, Баянхонгор аймгийн хувьд мөн нийт хэргийнхээ 86 хувийг гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж хааж байгаа байдлаас дүгнэхэд Сэлэнгэ, Баянхонгор аймагт гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж үзэж байгаа гомдол мэдээллийг Төв аймагт зөрчил гэж өөр өөр байдлаар шийдвэрлэж байгаа байдлаас практикт хууль хэрэглээний хувьд Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллага нь нэгдсэн нэг ойлголтонд хүрээгүй анх гомдол мэдээлэл хүлээж авахдаа гэмт хэрэг үйлдэгдсэн гэж хэрэг бүртгэлийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусмагц анх гаргасан шийдвэрээ үгүйсгэж гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хааж байгаа нь энэ төрлийн хэрэгт холбогдогч нарыг чирэгдүүлж эрхийн зөрчсөн эсвэл гадны нөлөөлөлд автах, үйлдэл холбогдолыг нь нотлох ур чадвар дутмаг байгаа учир хэрэг бүртгэлийн хэргийг хааж шийдвэрлэж байна.⁷⁵

Ганцаарчилсан ярилцлагын явцад прокуророос тодруулахад, албан тушаалтан оролцсон хэргийг шүүхээр шийдвэрлэж нотлоход маш хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг мөн шүүхээс хэрэг буцах нь прокурорын ажлын үзүүлэлтийн нэг сөрөг үзүүлэлт гэж ажлыг нь үнэлдэг тул нотлогдох боломжтой байдлаар нь хэргийг шүүхэд шилжүүлэх хандлага байгаа гэж ярьж байгаа байдлаас дүгнэхэд авлига, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан үйлдлийг шалгах, нотлох, шүүн таслахад одоо практикт тогтсон мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд бүрэн нотлох боломжгүй энэ төрлийн хэргийг хэрхэн мөрдөж нотлох талаар мөрдөгч, шүүгч, прокуроруудын чадвар сул байгаа мөн ажлын үзүүлэлтийг хэт явцуу байдлаар дүгнэж байгаа байдал нь сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж байна.

⁷⁵ Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 21 дэх тал).

График 7. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл



Төв аймгийн Прокурорын газраас гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрийн 12 хувьд нь авлига, албан тушаал, зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй, Сэлэнгэ аймгийн 39 хувьд нь ажиглагдаж байсныг хойшлуулшгүй ажиллагааг хийж гүйцэтгэн, харьяаллын дагуу шилжүүлэлгүй хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн байна. Баянхонгор аймгийн Прокурорын газрын гомдол, мэдээлэл шийдвэрлэсэн тогтоолд дээрх гэмт хэргийн шинжтэй үйлдэл ажиглагдаагүй болно.

Прокуророос авсан судалгаа хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох" гэмт хэрэг мөрдөн шалгахад гадны нөлөөлөл байдаг эсэх талаар: 26 прокуророос судалгаа авахад хамгийн их 53.8 хувь нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад нутгийн оршин суугчдаас нөлөөлөл их ирдэг гэсэн бол 26.9 хувь нь удирдах албан тушаалтнаас, 11.5 хувь нь шүүгчээс, 11.5 хувь нь хамтран ажилдаг хүмүүсээс, 7.6 хувь нь найз, нөхөдөөс ямар нэгэн байдлаар нөлөөлөл ирдэг гэсэн байна.

Мөрдөгчөөс авсан судалгаа хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох гэмт хэрэг мөрдөн шалгахад гадны нөлөөлөл байдаг эсэх талаар: Мөрдөн шалгах ажиллагааг бусдаас хараат бусаар явуулж чаддаг эсэх талаар асуулгад 62.5 хувь нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад нутгийн оршин суугчдаас нөлөөлөл их ирдэг гэсэн бол 25 хувь нь шууд удирдах албан тушаалтнаас, 12.5 хувь нь шүүх, прокуророос ямар нэгэн байдлаар нөлөөлөл ирдэг гэсэн байна⁷⁶.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршлаар нь авч үзэхэд, Баянхонгор аймагт гэмт хэргийн 39 хувь буюу 14 хэрэг Бөмбөгөр суманд 30 хувь буюу 11 хэрэг Баян-Овоо суманд 16 хувь буюу 6 хэрэг Галуут, Бууцагаан сумын нутагт, Сэлэнгэ аймагт гэмт хэргийн 39,5 хувь буюу 32 хэрэг Ерөө суманд, 22 хувь буюу 18 хэрэг Мандал сумын нутагт, 18,5 хувь буюу 15 хэрэг Орхонтуул сумын нутагт, 12,4 хувь буюу 10 хэрэг Баянгол сумын нутагт, 5 хувь буюу 4 хэрэг Хүдэр сумын нутагт, 2,6 хувь буюу 2 хэрэг Бугант тосгонд, Төв аймагт гэмт хэргийн 41 хувь нь заамар суманд 20 хувь нь сүмбэр суманд 18 хувь нь Баянцогт сумын нутагт тус тус бүртгэгдсэн.

График 8. Гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж буй багаж, хэрэгсэл

⁷⁶ Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 29 дэх тал)



Дээрх 3 аймгагт гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байгаа багаж хэрэгслээр нь авч үзэхэд нийт гэмт хэргийн 11,9 хувь нь гар аргаар, 29,8 хувь нь эксковатор, 16,5 хувь нь скруббер, 15 хувь нь гитаран буу, 26,8 хувь нь том оврын ачааны машин ашиглан гэмт хэрэг үйлдэж байна.

Дүгнэлт

1. Баянхонгор, Төв, Сэлэнгэ аймагт энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн байгууллага гомдол мэдээлэл гаргаж байгаа орон нутгийн иргэдээс 10 хувь, цагдаагийн алба хаагчдаас 51 хувиар бага гомдол мэдээлэл гаргасан байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагын алба хаагчид хамтран ажиллах талаар идэвх санаачилга гаргадаггүй. энэ төрлийн гэмт хэрэг зөрчил үйлдэгчид нь ихэвчлэн шөнийн цагаар, төв суурин газраас алслагдсан газарт гэмт хэрэг үйлддэг. Гэтэл төрийн болон олон нийтийн байгууллагад ажилладаг ажилчид Зөвхөн ажлын цагаар л ажиллахыг эрмэлздэг нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар хамтын ажиллагаа маш хангалтгүй түвшин байгааг харж болохоор байна.

2. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 51 хувиас дээш хувьд нь хохирогчоор Байгаль орчны байцаагчийг засаг даргыг томилж байгаа нь байдлаас дүгнэж үзэхэд:

- Байгаль орчны байцаагч гэсэн албан тушаалтан нь тухайн ажиллаж байгаа орон нутгийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийг төлөөлөх бүрэн эрхтэй эсэх, орон нутаг, төрийг төлөөлж энэ төрлийн гэмт хэрэг зөрчил үйлдсэн иргэн хуулийн этгээдээс учруулсан хохирлыг нэхэмжлэх эрхийг хуулиар олгоогүй атал хохирогчоор тогтоож байгаа буруу жишиг тогтоод байна.

- Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн төрийн байгууллагын албан тушаалтан хамтран оролцсон хэрэгт хохирогчоор хэнийг тогтоох эрх зүйн нарийн зохицуулалт байхгүй тул холбогдох хуульд энэ зохицуулалтыг нарийн тусгаж өгөх хэрэгцээ шаардлага үүсэн бий болоод байна.

3. “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” нийт хаасан хэрэг бүртгэлийн хэргийн 54.3 хувь нь тусгай зөвшөөрөлгүй, ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулсан байна. Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1-д “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт,

боловсруулалт, ашиглалт явуулсан, үйлдлийг гэмт хэрэгт тооцно”⁷⁷ гэж хууль тогтоох байгууллагаас зааж өгсөн байхад бүртгэлтийн хэргийн хааж шийдвэрлэж байгаа нь Эрүүгийн хуулийн буруу хэрэглээг бий болгоод байна.

4. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахаас өмнө гэмт хэрэгт хамтран оролцогчдын 50 хувь нь ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэж мэдүүлсэн, Прокурор Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахад ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэсэн мэдүүлэг 7.3 хувиар нэмэгдэж 57.3 хувь болж хэрэгт яллагдагчаар татсан байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тогтоох, үйлдэл холбогдлыг нотлох ажиллагаа хангалтгүй, мөрдөгч, прокурор нь гадны ямар нэгэн нөлөөлөлд автаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх, Хэргийн бодит байдлыг тогтоох” зарчим, Эрүүгийн хуулийн “шудрага ёсны зарчим” зөрчигдөж гэмт хэрэгт хамтран оролцогч нарыг хариуцлагаас чөлөөлөх асуудал байна гэж үзэж болохоор байна.

Санал

1. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх тодорхой асуудлаар хамтран хяналт шалгалтыг тодорхой газар орон, бүс нутаг, үйлдвэр, аж ахуйн нэгжид шалгалт явуулж, түүний үр дүнг хэлэлцэж, хамтран хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах гадны орны сайн туршлагыг судлан хэрэгжүүлэх;

2. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, алба хаагч нарыг сургах, мэргэшүүлэх замаар “Хууль бусаар ашигт хайх, малтмал, олборлох” гэмт хэрэг дээр ажиллаж буй мөрдөгч, прокурорын мэдлэг, чадвар, чадамжийг дээшлүүлэх, чадваржуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах тактик, арга зүйгээр мэргэшүүлэх чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулах. Мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай ихэнх баримт нотолгоог мэдүүлгээр цуглуулж буй тул мэдүүлэг авах чиглэлээр тусгайлсан сургалтаар дамжуулан мөрдөгчдийн ур чадварыг энэ чиглэлээр сайжруулах;

3. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд тухайн орон нутагт шаардлагатай техник, хэрэгслийн судалгаа үүнд шаардлагатай боловсон хүчний тоог орон нутаг тус бүрээр гаргаж эрх бүхий байгууллагад уламжлах, олон улсын донор байгууллагын туслалцаа авах боломжийг судлах;

4. Энэ төрлийн гэмт хэргийг голлон үйлддэг газарт хүний хүчнээс илүү дэвшилт технологи ашигласан хяналтын цэгийг ажиллуулах, үүнд шаардагдах зардлыг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс гаргуулах саналыг эрх бүхий байгууллагад уламжлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжлүүлснээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг саармагжуулах, бууруулахад чухал нөлөө үзүүлнэ.

Ашигласан материал

1. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 10 дахь тал).

2. Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №23.

4. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан (2022 он 29 дэх тал).

⁷⁷ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙХ НЬ МӨРДӨН ТОГТООХ ЧИГ ҮҮРГИЙН ҮНДСЭН ШИНЖ МӨН

INDEPENDENCE IS ESSENTIAL CHARACTERISTICS OF THE INVESTIGATE

Н.Сайнбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

Товч агуулга: Нийгэмд шударга ёс тогтоох үйл явц өөрөө асар их зохион байгуулалттай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг шаарддаг. Үүнтэй ижил шүүх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн тогтолцоог боловсруулахад үе шат бүрийг тодорхой болгож, ингэхдээ тэдгээр үе шатын эрх зүйн философи үндэс, онцлогийг харгалзан үзэх нь зайлшгүй. Сүүлийн жилүүдэд нийгэмд шүүх эрх мэдлийн бүхий л байгууллагын нэр хүнд сайн биш байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн чиг үүргийн философийн мөн чанарыг харгалзалгүйгээр эрх зүйн байдлыг нь хуульчлах болсонтой шууд холбоотой.

Өгүүлэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд мөрдөгчийн багагүй эрх хэмжээтэй гэх агуулгаар хуульчилсан боловч практикт мөрдөгчийн үйл ажиллагаа прокуророос бүрэн хараат байгаа нь сэдвийг судлах үндэслэлийг тодорхойлно. Энэхүү илтгэлээр өмнө нь огтхон ч судлагдаж байгаагүй гэж хэлж болохоор мөрдөгчийн хараат бус байх шинжийг түүний гүйцэтгэх үүргийн мөн чанарыг судлах замаар тодорхойлохыг зорьсон.

Abstract: The process of establishing social justice itself requires high organization, transparency and openness. In the same way, in the development of judicial institutions and their systems, it is necessary to clarify each stage and at the same time take into account the philosophy of law and the features of these stages. In recent years, the reputation of all judicial authorities in society is not very good, which is directly related to the fact that the legal status of bailiffs is legitimized without taking into account the philosophical nature of their duties.

This report legislates for Article 6.2 of the Code of Criminal Procedure, the content of which states that the detective has significant powers, but in practice the activities of the detective are completely dependent on the prosecutor. The purpose of this report is to determine the nature of the detective's independence, which has never been previously studied, by examining the nature of the detective's role.

Түлхүүр үгс: Мөрдөгч, мөрдөгчийн эрх зүйн байдал, мөрдөн тогтоох, мөрдөн тогтоох чиг үүрэг.

Keywords: Investigator, legal status of investigator, investigate, investigation.

Хүн төрөлхтөн бий болсон цагаас эхлэн өөр хооронд үүссэн аливаа харилцааг зохицуулах гэж оролдлого хийсээр ирсэн нь өнөөгийн эрх зүйн тогтолцоог бий болгожээ. Газар нутаг, амьдралын хэв маяг, нийгмийн ахуйн онцлогоос хамаарч эрх зүйн хэм хэмжээний шинж чанар бий болсон. Тодруулбал, аливаа улсын хувьд эрх зүй бүтэх үйл явц, шүүх эрх мэдлийн эзлэх байр суурь, эрх зүйн эх сурвалж хэрэглэх, харилцаа хамаарал зэргээс шалтгаалж эрх зүйн тогтолцоо тодорхойлогдоно.

Эрх зүйн тогтолцоо (бүл)-ны талаар Германы эрдэмтэн Готфрид Лейбниц “Nova Methodus Discendae Docendaeque Iurisprudentiae”⁷⁸ (1667) бүтээлдээ анх удаа: “Улс орнуудын нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйг ижил төстэй байдлаар нь нэгтгэн авч үзэж болох юм” гэсэн санааг дэвшүүлснээр хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун болжээ. Харин хожим Францын эрдэмтэн Рене Давид, Лейбницийн эрх зүйн тогтолцооны талаарх санааг өргөжүүлэн өнөө үед түгээмэл хэрэглэгдэх болсон

⁷⁸ “Эрх зүйд суралцах, заах шинэ арга” (Латин).

ангиллыг бий болгожээ. Рене Давид: “Улс орнуудын эрх зүйн тогтолцооны хэв маягийг харгалзан дараах байдлаар ангилж болох юм гээд Ром-Германы (эх газрын), Англосаксоны, Шашны, Социалист, Уламжлалт эрх зүйн бүл”⁷⁹ гэжээ.

Манай улсын хувьд эх газрын буюу Ром-Германы эрх зүйн аймагт хамаардаг. Эх газрын эрх зүйн аймгийн анхдагч суурь үндэслэл нь Ромын эрх зүйгээс эхлэлтэйг нэгэнт хүлээн зөвшөөрсөн. Ромын сонгодог эрх зүйн хөгжлийн оргил үед гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн гэм бурууг шүүх шалган тогтоохын тулд нотлох ажиллагааны бүхий л процессыг шүүхийн эрх бүхий субъект гардан хийж, хөндлөнгийн нотлох баримтыг шүүх дээр гарган илтгэх журмыг тогтоож байв⁸⁰. Хэдийгээр тухайн үед мөрдөн байцаалт ба шүүхийн үе шат гэсэн нарийн зааг байгаагүй боловч дээрх хоёр ажиллагааны чиг үүрэг ялгагдаж байсан⁸¹.

Дэлхийн улсуудад аль эрх зүйн бүлд хамаарахаас үл шалтгаалж эрүүгийн процессын гурван загвар бий болжээ. Үүнд:

- 1) Аккусацн систем (Accusatory process);
- 2) Инквизици систем (Inquisitorial process);
- 3) Хосолсон систем⁸² (Mixed process).

Аккусацийн систем нь мэтгэлцэх тогтолцоо бөгөөд шүүгдэгчийг буруутгасны дараа түүний мэдэгдлийг эсрэг талын процессоор нотлох ёстой гэсэн үг юм. Онцлог нь тал бүр (яллах тал, өмгөөлөх тал) шүүгч эсвэл тангарагтны бүрэлдэхүүнд хамгийн үнэмшилтэй аргументыг гаргаж ирдэг процесс юм. Энэ үед шүүхээс өмнө хэргийг мөрдөхгүй гэсэн үг огтоос биш бөгөөд шаардлагатай гэж үзвэл, эрх бүхий байгууллагаас мөрдөх ажиллагааг явуулж үр дүнг шүүхэд хүргүүлдэг. Нотлох баримтыг хэн ч урьдаар үнэлдэггүй бөгөөд зөвхөн шүүгч эсвэл тангарагтны шүүх ирүүлсэн нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэнэ. Яллах систем нь өрсөлдөгчийн системтэй адил юм. Хэн хамгийн оновчтой логик, зүй тогтлыг тайлбарлаж чадна тэр тал ялалтыг авах боломжтой.

Аккусацн процесс нь олон улс оронд хэрэглэгдэж байгаа бөгөөд гэм буруугүй гэсэн таамаглал дээр үндэслэх бөгөөд хүнийг гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцдог, нотлох үүрэг нь яллах тал (прокурор) дээр ирдэг. Яллах үйл явц нь яллагдагчийг улсын яллагч, хохирогчоос албан ёсоор буруутгаж, яллах, улмаар яллагдагчийг шүүхэд өөрийгөө хамгаалах боломжийг олгоно. Шударга шүүхээр шийдвэрлүүлэхэд чиглэгдсэн хүний эрхийг хангахад энэ тогтолцоо олон чухал баталгааг хангаж өгдөг.

*Зураг 1. Аккусацн процессын үе шат*⁸³.

⁷⁹ Rene David. Les grands systèmes de droit contemporains. Основные правовые системы современности. Перевод с французского языка д.ю.н. Туманов, В.А. - М.,1988. С.8.

⁸⁰ Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага //Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхтгэл. -Уб.,2019. 6 дахь тал.

⁸¹ Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. Ерөнхий анги. -Уб.,2014. 16-17 дахь тал.

⁸² “Эрх зүй” сэтгүүл. -Уб.,2014. №3.(39). 76 дахь тал., Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. - Уб.,2020.13 дахь тал.

⁸³ Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. -Уб.,2020. 213-214 дэх тал.

Үндэслэл: Прокурор яллагдагчийг буруутгаж, буруутгаж байгаа зүйл, нотлох баримтуудыг тоймлон өгүүлдэг.

Урьдчилсан хэлэлцүүлэг: Яллагдагчид ямар хэрэгт яллагдаж буйг мэдэгдэж, өмгөөллийн мэдүүлэг гаргах боломжийг олгоно.

Шүүх хурал: Шүүх хурал шүүгч эсвэл тангарагтны өмнө явагддаг бөгөөд яллагч болон өмгөөлөгч нар нотлох баримт, аргументуудыг гаргаж тавина.

Шийдвэр: Шүүгч эсвэл тангарагтны шүүх яллагдагчийг гэм буруутай эсвэл буруугүй гэж үзсэн шийдвэр гаргана.

Ял: Яллагдагч гэм буруутай нь тогтоогдвол шүүх ял оногдуулна

Аккусацийн тогтолцоо нь шүүхийн прецедент жишгийн хэм хэмжээг эрх зүйн голлох эх сурвалж болгон авч үздэгээс үүдэн эрүүгийн процессын ажиллагаа нь үе шатны болон тодорхой хугацаагаар хязгаарлагддаггүй бөгөөд тухайн процесст оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, тэдний хоорондоо харилцах нээлттэй, нөхцөлийг тогтооход чиглэсэн уян хатан зохицуулалтыг төлөвшүүлсэн байдаг. Энэ тогтолцооны давуу тал нь хувь хүнийг үндэслэлгүйгээр баривчлах, ял шийтгэл оногдуулахгүй байхыг баталгаажуулдаг тул хууль дээдлэх, шударга шүүхээр шүүлгэх, хүний халдашгүй байх эрхийг баталгаатай хангахад оршдог.

Инквизици нь "Inquisition adhere process"⁸⁴ буюу шүүхээр шийдэх хэргийг заавал урьдаар мөрдөж, тодорхой нөхцөл байдлыг тогтоох гэсэн чиг хандлага юм. Инквизици процесс нь нэг талаас хэргийг бүх талаас бүрэн бодиттойгоор тогтоох нөхцөлийг хангах зорилготой бөгөөд гэм бурууг зөвхөн шүүх тогтоох шаардлагад нийцүүлэн төрийн хуульд захирагдах зарчимтай салшгүй холбоотой⁸⁵. Инквизицийн хэв загвар нь мөрдөн шалгах ажиллагааг ямар ч хэргийн хувьд заавал явуулах гэсэн уламжлалт хандлага өөрчлөгдөж, хүнд биш зарим хэргийн хувьд гэм буруугаа хүлээсэн, хохирлоо төлсөн тохиолдолд шүүхэд шилжүүлэхгүй буюу түргэвчилсэн, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийг шинээр хуульчлах болжээ⁸⁶. Энэ процесс нь шүүхийн чөлөөт мэтгэлцээн, ял тохиролцох зэрэг процедурыг үгүйсгэдэг. Хэргийн хувь заяа мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслан ажиллагаа явагддаг нь уг процессын гол онцлог юм⁸⁷.

Хосолсон хэв маягийн процесс ажиллагаанд инквизиц, аккусацийн шинжүүд харилцан бий болж буй байдлыг ойлгоно. Хосолсон эрүүгийн процессын онцлогийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд: Шүүхээс өмнөх мөрдөн байцаалтын шатанд яллагдагч, түүний өмгөөлөгчийн эрхийг зарим талаар хязгаарладаг; Бодит үнэнийг тогтоох зарчмыг оролцогчийн эрхийг хангах, шударга ёсны зарчимтай уялдуулж, яллах болон цагаатгах нотолгоонд харьцангуй тэнцвэртэй байдлыг шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд хэрэгжүүлэхийг зорьдог; Сэжигтэн, яллагдагч,

⁸⁴ Мөрдөн байцаалт гарцаагүй байх.

⁸⁵ Criminal procedure. A worldwide study. Carolina. 2007. P.21.

⁸⁶ Головки, Л.В. Альтернативы уголовному преследованию в современном праве. -СПб., 2008. С.23.

⁸⁷ Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага // Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхтгэл. -УБ.,2019. 10 дахь тал.

шүүгдэгчийг урьдаас гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэхээс зайлсхийж, зөвхөн нотолгоог шинээр авч үзэж шийдвэрлэхийг зорьдог; Прокурор хэргийн зарим баримтыг зөвхөн шүүх дээр дэлгэн гаргаж ирэх ба шүүх хуралдаан эрх тэгш талуудын мэтгэлцэх зарчмын дагуу явагдана; Шүүх хуралдаанд өмгөөлөгч нь нотлох баримтыг шүүхэд үнэлүүлэх, шинжлэх судлуулах эрхтэй; Шүүх дээр нотолгооны агуулгыг талууд болон шүүгч нар хамтарч тодорхойлно⁸⁸ зэргийг дурдаж болно.

Монгол Улсын хувьд хосолсон эрүүгийн процессын загвар бүхий тогтолцоотой гэж тодорхойлж болохоор байна. Энэ талаар ч зарим судлаачид⁸⁹ санал нэгдсэн байдаг. Учир нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бүхий л гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа гарцаагүй явагдаж, түүний үр дүнд бий болсон нотлох баримтыг үндэслэн прокурор, шүүх шийдвэр гаргана. Зарим төрлийн хэрэгт яллагдагч учруулсан хохирлоо нөхөн төлсөн тохиолдолд өөрт холбогдох хэргийг хялбаршуулан шийдвэрлүүлэх эрхтэй байдаг зэрэг нь аккусаци болон инквизицийн аль алиных нь шинжийг агуулдаг.

Монгол Улсын ЭХХШТХ-д гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулсны үр дүнд цугласан нотлох баримтыг үндэслэн прокурор, шүүх эцсийн шийдвэрийг гаргадгаараа инквизицийн шинжийг агуулж байгаа бол хэргийг хялбаршуулан журмаар шийдвэрлэх процессын хуульчлагдсан зохицуулалт, прокурор хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр, талууд шүүхийн шатанд тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх эрхтэй байдаг зэрэг аккусаци шинжийг давхар агуулж байгаа нь манай улсын эрүүгийн процессын хэв маяг хосолсон шинжтэй болохыг тодорхой харуулж байна.

Эрүүгийн мөрдөх ажиллагаа нь яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх гол тулгуур чиг үүргүүдийн эхлэл үндсийг тавигч хэмээн нэрлэгдэж улам бүр шийдвэрлэх ач холбогдолтой болжээ. Ер нь эрүүгийн процессын чиг үүргүүд, түүний дотор “мөрдөх” нь нотлох баримт бүрийг бодит шинжээр нь илрүүлэхийг зорилгоо болгосоор ирсэн. Тиймдээ ч яллаж зэмлэхээс гадна өмгөөлөн хамгаалах процесс ажиллагаа мөрдөн мөшгөлтийн үед явагдсаар байдаг нь эргэлзээгүй үнэн⁹⁰ гэдэгтэй санал нийлэхийн аргагүй.

Эрх зүйн аймгийн онцлогоос үл хамаарч дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрүүгийн процессын суурь зарчмууд хэдийн бий болжээ. Эдгээрт:

1. Шүүхээр нотлогдоогүй үед ямар ч нөхцөлд гэм буруугүйд тооцох (Produce innocence);

2. Нотолгооны цогц шинжийг хангах, тэнцвэртэй бөгөөд харилцан шалгах зарчим (Cross-examination);

3. Хэргийг зөвхөн шүүх шийдвэрлэх (Ratione temporis);

4. Мөрдөн тогтоох ба яллах чиг үүргийг ялган зааглах зарчим;

5. Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хангах;

6. Шүүх хэргийг хараат бусаар, бие даан шийдвэрлэх зарчим;

7. Баривчлах, цагдан хорих арга хэмжээг шүүхийн хэлэлцүүлгийн үндсэн дээр шүүгчийн тогтоолоор онцгой тохиолдолд хэрэглэх зарчим;

8. Гэмт хэргийн талаарх баримт сэлтийг шүүх хуралдаанаас өмнө урьдчилан үнэлэхгүй байх зарчим⁹¹ зэргийг дурдаж болно. Эдгээр зарчмууд нь НҮБ-ын гэрээ, конвенцод шууд тусгагдсан байхаас гадна ихэнх улс, орнуудын Үндсэн хуулиудаар хамгаалагдсан байдаг. Мөн эдгээр нь улс орны нийгмийн онцлог, эрх зүйн ухамсар, соёлоос үл хамаарч, хүний эрх эрх чөлөөг заяагдмал шинжтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнийг гарцаагүй хамгаалах, хэрэгжилтийг нь хангахад чиглэсэн байна. Иймд бусад улс орнууд энэхүү олон улсын хүний эрхийг дээдэлсэн салбарын зарчимд

⁸⁸ Баярсайхан, Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. -Уб.,2015. 39-40 дэх тал.

⁸⁹ Цогтбаатар, Б. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл.- Уб.,2021. 15 дахь тал., Эрхэсхулан, Ж. Шүүхийн мэтгэлцээн ба шүүмжлэлт рационализм.// Эрх зүй сэтгүүл. -Уб.,2011. №1. 120 дахь тал.

⁹⁰ Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. -Уб.,2018. 206-207 дахь тал.

⁹¹ Kamisar.,LaFave, I king. Modern criminal procedure. -W.,2005. P.118.

тэмүүлэх ёстой, ингэж байж сая утгаараа хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг бүтээх болно.

Мөрдөн тогтоох ба яллах чиг үүргийг ялган зааглах зарчим нь мөрдөгч, прокурор тусдаа чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой гэдгийг олон улсын түвшинд эрүүгийн процессын чиг хандлага аль хэдийн хүлээн зөвшөөрч тодорхойлсон байхад манай улсын хувьд мөрдөн тогтоох чиг үүргийг яллах талын бүрэлдэхүүн хэсэг мэтээр хуульчилсан нь олон улсын жишгийн эсрэг зохицуулалт болжээ. Үндэсний Эрүүгийн процессын хуульд мөрдөгчийн эрх, үүргийг тодорхойлсон боловч хэрэгжилт нь прокуророос хараат байгаа нь хуулийг өөрчлөх хэрэгцээ шаардлагыг харуулна. Ингэхдээ ЭХХША-г дагнан хэрэгжүүлэгчдийн төлөөллөөс оролцуулах замаар оновчтой зохицуулалтыг бий болгох боломжтой.

Өмнөх процесс хуультай харьцуулахад, ЭХХШТХ-д прокурорын эрх хэмжээ нэмэгдсэн нь хууль бүтээх үйл явцад оролцсон хүмүүсийн ажил мэргэжлийн онцлогтой холбоотой байж болох юм. Тодруулбал, 2015 оны 01 сарын 06-ны өдрийн А/01 дугаартай Хууль зүйн сайдын тушаалаар Монгол Улсын ЭХХШТХ-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбар бүрийн төлөөлөл болох нийт 36 гишүүн байснаас, 1 хүн МША явуулах байгууллагын удирдлагын түвшинд хамаарах хүн байв. Ажлын хэсгийн 31 гишүүнээс МША ажиллагаа явуулж байсан туршлагын талаар судалгаа хийхэд нийт 7 гишүүн байсан ба тухайн үедээ бүгд сүүлийн 7-с дээш жилийн хугацаанд МША гардан гүйцэтгээгүй нийтлэг байдал ажиглагдлаа⁹². Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний онцлогоос хамаарч, “эрх зүйн хэм хэмжээг бүтээхэд ёс суртахуун, улс төр, ёс зүйн зарчмаас бусад өөр хүчин зүйл, жишээлбэл тухайн эрх зүйг дагаж мөрдөгчдийн тодорхой бүлэглэлийн ашиг сонирхол нөлөөлдөг”⁹³ гэсэнтэй нийцэж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөн тогтоох чиг үүргийн онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг мөрдөгчийн оролцоогүйгээр боловсруулах боломжгүй юм.

ЭХХШТХ-д хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт гэж ялгаж заагласан боловч прокурорын эрх хэмжээг нэмэгдүүлсний улмаас хангалттай түвшинд зааглаж чадаагүй. Прокурор, мөрдөгчийн чиг үүргийн заагийг ЭХХША-г үечлэн хуваасантай уялдуулах байдлаар хуваах бүрэн боломжтой. Гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож, хэрэгт ач холбогдол бүхий баримт, сэлт, мэдээллийг цуглуулахын тулд мөрдөгчөөс явуулж буй мөрдөн шалгах болон бусад ажиллагааг ерөнхийд нь “шүүхийн өмнөх” үе шат хэмээн нэрлэдэг⁹⁴. Мөн эрүүгийн процессын эрх зүйг шүүхийн өмнөх үе шат, шүүхийн шат гэдэгтэй доктор, профессор Д.Баярсайхан санал нийлж, улмаар “шүүхийн өмнөх үе шат” гэдэг нь эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхээс өмнө хуулийн дагуу зайлшгүй хийгдэх ёстой хэргийг илрүүлэх, мөрдөх ажиллагаа бөгөөд нотолгооны үйл явцыг бүх талаас бүрэн дүүрэн, бодитойгоор хангахад чиглэгдсэн эрүүгийн процесс мөн. Шүүхийн өмнөх үе шатад эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хамаарна⁹⁵ гэжээ. Өөрөөр хэлбэл, мөрдөн тогтоох чиг үүргийг шууд бусаар судлаач, эрдэмтэд шүүхийн өмнөх үе шатад хамаарах талаар өөр өөрийн байр суурийг илэрхийлжээ.

ЭХХША-ны үе шат нь өөр хоорондоо харилцан хамааралтай, тодруулбал, нэг үе шатын үйл ажиллагааны үр дүн нь нөгөөгийн үйл ажиллагааг эхлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах нийтлэг журам, дарааллыг тогтоож байдаг. Эдгээр үе шатны нийлбэр цогц нь ЭХХША-ны тогтолцоог бүрдүүлнэ. Шүүхийн өмнөх үе шат нь дотроо хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэргийг шүүхэд шилжүүлэх гэсэн хэсгүүдээс бүрдэх аж⁹⁶. Мөн “зөвхөн хэрэг

⁹² Сайнбаяр, Н. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онол, практикийн асуудал// Докторын зэрэг горилсон бүтээл. -Уб.,2023. 116-117 дахь тал.

⁹³ Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. Орч. Хатанбаатар, М., ред. Амарсанаа, Ж.-Уб.,2013. 120 дахь тал.

⁹⁴ Быков, В.М., Александров, А.С. и др. Уголовный процесс. -М.,2015. С.26-32.

⁹⁵ Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. -Уб.,2014. 70 дахь тал.

⁹⁶ Амарбаясгалан, Б., Мөнхбат, М. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. -Уб.,2018. 7-8 дахь тал.

бүртгэлт, мөрдөн байцаалтын үе шатыг шүүхийн өмнөх үе шатад хамааруулна”⁹⁷ гэж зарим судлаачид санал нийлсэн байдаг.

Эдгээрээс үзэхэд, ЭХХША-г тогтолцооны хувьд шүүхийн өмнөх болон шүүхийн шат гэсэн үндсэн хоёр хэсэгт авч үзэж болохоор байна. Шүүхийн өмнөх шатанд хэргийн бодит байдлыг тогтооход чиглэж буй үйл ажиллагаа хамаарах бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт гэсэн хэсгүүдээс бүтдэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд үндэслэл болох нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлдэг. Мөрдөгчийн ЭХХША-д гүйцэтгэж буй үүргийн эрх зүйн зохицуулалт, олон улсын эрүүгийн процессын зарчим зэргийг үндэслэн гэмт хэрэг илрүүлэх, нотлох баримт бэхжүүлэх, цуглуулах үйл ажиллагааг “мөрдөн тогтоох” чиг үүрэг гэж тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчийн хэргийн бодит байдлыг тогтооход чиглэсэн бүхий л арга хэмжээг мөрдөн тогтоох чиг үүргийн хүрээнд мөрдөгч хэрэгжүүлдэг гэсэн үг юм.

ЭХХША-г хэрэгжүүлэгч шүүх, прокурор, мөрдөгч нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд Эрүүгийн процессын хуулийн зорилтод хамаарах үйл ажиллагааг явуулах ба тэдгээр нь тус тусдаа өөрсдийн онцлог чиг үүргээр тодорхойлогдоно. Тухайлбал, шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу хэргийг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй, прокурор хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бол, мөрдөгч “мөрдөн тогтоох” чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөрдөн тогтоох чиг үүрэг, нэр томьёоны талаар судлах нь энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох ач холбогдолтой. Монгол Улсын Үндсэн хуульд хэнийг ч хууль бусаар мөрдөн мөшгөхийг хориглоно гэсэн агуулга бүхий хэм хэмжээг тунхагласан бөгөөд хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн мөшгөх боломжтой юм.

Доктор, профессор Ж.Бямбаа: “мөрдөн мөшгөх” нь мөрдөн шалгах, эрүүгийн эрэн сурвалжлах ажлын уялдааг агуулдаг бөгөөд гэмт хэрэг нэг бүрийг илрүүлэх, өдүүлсэн этгээдийг илчлэн, түүний гэм буруутай эсэхийг тогтоож, улмаар хөндлөнгийн хараат бус, шудрага шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлэн өгөхөд чиглэдэг. Тийм учраас мөрдөлт, байцаалт хоёрыг салгаж болдоггүйтэй адил мөрдөн шалгах, эрүүгийн эрэн сурвалжлах ажлыг бие биеэс нь салангид авч үзэх боломжгүй⁹⁸ гэсэн бол доктор, профессор Т.Оюунчимэг: Мөрдөн мөшгөх чиг үүрэг нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох мөрдөгчийн үндсэн үүргээс урган гарах бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэх болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх ажиллагаа явагдах нөхцөлийг бүрдүүлэгч шүүхийн өмнөх шатны цөм ажиллагаа⁹⁹ гэж үзжээ. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд мөрдөгчийн гүйцэтгэж буй ажиллагаануудын мөн чанарыг “мөрдөн мөшгөх” гэсэн ухагдахуун бүрэн илрүүлж чадахгүй байна гэж үзсэн. Учир нь мөрдөгч дан ганц аливаа гэм буруутай этгээдийг мөрдөн мөшгөөд илрүүлээд хангалтгүй, түүний гэмт хэрэг үйлдсэн эсэхийг “тогтоох” шаардагатай болдог. Мөрдөн мөшгөх гэдэг нь аливаа мөрөөр хайх, илрүүлэх, эрэх гэсэн санааг агуулж байна. Тодруулбал, мөр хөөх үйлдлийг илэрхийлэх “эрэн сурвалжлах” гэдэг үгийн үндэс болох “эрэх” гэдэг нь мэдье, олъё гэж хайх сурвалжлах, эрэх сурах, эрж хайх, эрж сурвалжлах гэсэн хоршоо үг¹⁰⁰ хэмээн Монгол хэлний товч тайлбар тольд тайлбарласнаас үзэхэд, аливаа зүйлийг олж мэдэх зорилгоор тодорхой этгээдээс хийх үйлдэл буюу Монгол хэлний тайлбар толиудад мөрдөхийн илэрхийлэл аливаа юмны зам мөрөөр мөшгөн явж шалгах гэсэн тайлбартай агуулга нэг ажээ.

Мөрдөн тогтоох гэсэн нь мөрдөх, тогтоох гэсэн үгсийн нийлбэр бөгөөд “мөрдөх” гэдэг нь аливаа хүн, мал, эд зүйлсийг ул мөрөөр нь илрүүлэх, мөрдөн олох гэсэн санаагаар илэрхийлэгдэх бөгөөд “тогтоох” нь аливаа нөхцөл байдлыг тодорхой

⁹⁷ Нямбаатар, Х., нар. Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. -УБ., 2020. 15 дахь тал.

⁹⁸ Бямбаа, Ж. Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. -УБ., 2018. 206 дахь тал.

⁹⁹ Оюунчимэг, Т. Мөрдөгчийн чиг үүргийн агуулга, мөн чанар. //Хууль сахиулахуй. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. -УБ., 2023. №3. 28 дахь тал.

¹⁰⁰ Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. 30000 орчим үгтэй. -УБ., 1966. 889 дэх тал.

судалгаа /мөрдөх ажиллагаа/ явуулсны үндсэн дээр мөн чанарыг нь нээн харуулж буй үйл явц юм. Өөрөөр хэлбэл, мөрдөөд илрүүлээд зогсохгүй, илрүүлснээ бататгаж тогтоох ажиллагаа хийгдэх гэсэн агуулгатай. Энэ нь ЭХХШТХ-д заасан “хэргийн бодит байдлыг тогтоох” мөрдөгчийн үндсэн үүрэгтэй уялдаж буй юм. Мөрдөн тогтоох гэдэг нь “investigate”¹⁰¹ буюу “үнэнийг тогтоохын тулд (үйл явдал, гомдол гэх мэт) баримтыг олж, шалгахын тулд системчилсэн буюу албан ёсны хэрэг бүртгэлт явуулах” гэсэн утгатай Латин гаралтай үйл үг аж.

Эдгээрээс дүгнэн үзэхэд, “мөрдөн тогтоох” чиг үүрэг нь мөрдөгчөөс явуулж буй МША-гаар хэрэгждэг байна. Энэ нь зөвхөн яллах зорилго чиглэлийг л эрхэмлэнэ гэсэн үг биш бөгөөд эрүүгийн процессын үндсэн зорилтыг биелүүлэх гол суурь юм. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагааны үед яллах, цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх бүхий л баримтат мэдээллийг болж өнгөрсөн гэмт үйлдлийн бодит байдлыг тогтоох зорилгоор, хуульд заасан үндэслэл, журмын дагуу нямбай чанд цуглуулж бэхжүүлнэ гэсэн үг. Мөрдөн шалгах ажиллагааг мөрдөгч л хэрэгжүүлнэ.

Үндэсний эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн процессын ажиллагааны чиг үүргийг процесс ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, зорилго, чиглэл, эрх зүйн байдлын зааг ялгаанаас хамаарч: Эрүүгийн хэргийг мөрдөх чиг үүрэг; Өмгөөлөх чиг үүрэг; Яллах чиг үүрэг; Хэргийг шийдвэрлэх чиг үүрэг¹⁰² гэсэн ангилал тогтсон байна.

Эрүүгийн процессын ажиллагааны явцад хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилсныг “чиг үүрэг” хэмээн томъёолж, харин чиг үүрэг нь тухайн ажиллагаанд оролцогчдын бүрэн эрхээр тодорхойлогддог нь эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанаар нотлогдсон зүйл юм. Судлаач эрдэмтэд эрүүгийн процессын ажиллагааны чиг үүргийн талаар өөрсдийн үзэл бодлыг уралдуулан янз бүрээр ангилан системчилж байсан ямар ч тохиолдолд яллах, өмгөөлөх, шүүн таслах чиг үүргийг эрүүгийн процессын ажиллагааны гол тулгуур чиг үүрэг гэдэгтэй санал нэгдэж, харин мөрдөн тогтоох чиг үүргийг тулгуур чиг үүргүүдийн эхлэл үндсийг тавигч¹⁰³ хэмээн үзэж байна. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт: “Гэмт хэргийн ул мөрийг шинжлэн судалж илрүүлэх, гэмт хэрэгтнийг мөшгөн мөрдөх үүрэг бүхий ажилтныг мөрдөгч гэнэ”¹⁰⁴ гэж тайлбарласнаас үзэхэд, гэмт хэргийг ул мөрийг илрүүлэх, түүнийг мөрдөн мөшгөх ажиллагаа хосолмол шинжтэй болохыг илтгэнэ.

Дээрх тайлбаруудыг эрүүгийн процессын ажиллагааны үндсэн зорилттой уялдуулан авч үзвэл, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг олж тогтоохын тулд мөрдөн тогтоох чиг үүргийг хэрэгжүүлдэг нь ямар ч маргаангүй ба мөрдөн тогтоохгүйгээр хэн нэгнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хариуцлага хүлээлгэх ямар ч боломжгүй юм.

Тэгвэл, мөрдөн тогтоох чиг үүрэг нь мөрдөгчийн явуулж буй МША-аар хэрэгжихээс гадна үндэсний хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээний хүрээнд бусад зайлшгүй шинжийг тодорхойлох боломжтой. Монгол Улсын ЭХХШТХ-ийн хүрээнд дүн шинжилгээ хийж эрүүгийн процессын хэрэгжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг, хянан шийдвэрлэх ажиллагааны оролцоо зэргийг харгалзан үзэж Энтони¹⁰⁵-ий гурвалжингаар дүрслэн харуулав.

¹⁰¹ Кембриджийн толь бичиг. Цахим эх сурвалж. Татаж үзсэн: 2023.09.03 // <https://dictionary.cambridge.org/dictionary/english/investigate.>, Оксфордын толь бичиг. Цахим эх сурвалж: Татаж үзсэн: 2023.09.03 // <https://languages.oup.com/google-dictionary-en/>.

¹⁰² Бямбаа, Ж. Мөрдөх чиг үүргийн агуулгыг шинээр тодорхойлох нь. Хууль дээдлэх ёс. Хууль зүйн эрдэм шинжилгээ, практикийн улирал тутмын сэтгүүл. -Уб., 2018, Цуврал 68. №3. 36 дахь тал., Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. МУИС. ХЗС. -Уб., 2018. 205 дахь тал.

¹⁰³ Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Дурдсан бүтээл. 206 дахь тал.

¹⁰⁴ Дамбажав, И. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. I боть. -Уб., 2010. 983 дахь тал.

¹⁰⁵ Энтоний гурвалжин- менежментийн шинжлэх ухаан дахь зохион байгуулалтын загвар. 1965 онд Харвардын бизнесийн сургуулийн профессор Роберт Энтони АНУ-ын удирдлага, зохион байгуулалтын онолд анх удаа дэвшүүлсэн. Гурвалжингийн доод хэсэгт олон тооны шийдвэрлэх үйл ажиллагаа хамаарч дээшлэх тусам улам нарийвчлан шийдвэрлэж, энэ нь тухайн тогтолцооны оршин тогтнох ерөнхий загвар юм

Зураг 2. Эрүүгийн процессын хэрэгжүүлэгчдийн ЭХХША дахь оролцоо, гүйцэтгэх үүргийн процессын загвар



Дээрх зургаас үзэхэд, мөрдөн шалгах үйл ажиллагаа өргөн цар хүрээг хамарч, түүнээс тодорхой төрлийн хэргийг прокурорын хяналтад шилжүүлж, мөн шилжүүлснээс цөөн тооны хэргийг шүүхэд шилжүүлдэг статистик¹⁰⁶ тоон мэдээллийн агуулгатай тохирч байна. МША-г хэрэгжүүлэгч мөрдөгчийн хуульд заасан үүргээ хэрхэн гүйцэтгэхээс шалтгаалж пирамидын суурь бат бөх байх эсэх нь тодорхойлогдох нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, мөрдөн тогтоох чиг үүрэг хэлбэрэлтгүй хэрэгжснээр хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахаас гадна, ЭХХША бүрэн бодитой, зорилтоо хангах эсэх нь шууд хамаарах аж.

Үндэсний хууль тогтоомжид тусгасан шүүх болон прокурорын байгууллагын үйл ажиллагааны зарчмын хүрээнд хийсэн судалгаанаас үзэхэд, шүүх, прокурорын байгууллагад “хууль дээдлэх”, “хараат бус бие даасан”, “үйл ажиллагаагаа ил тод явуулах” зэрэг зарчмууд нийтлэг байна. Эдгээрийг ЭХХША-г хэрэгжүүлэгчдийн нийтлэг зарчим гэж үзэж болох ба шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, гарцаагүй шинж болох нь тодорхой. Өөрөөр хэлбэл, “хууль дээдлэх”, “бие даасан, хараат бус”, “ил тод байх” нь шүүх эрх мэдлийн байгууллагуудад зайлшгүй байх үндсэн шинж бөгөөд дээрх гурван субъектэд эдгээр шинж агуулагдаж байж сая шүүх эрх мэдэл бодитой хэрэгжиж, нийгэмд шударга ёс тогтох зүй тогтолтой аж. Гэвч эрүүгийн процессын хэрэгжүүлэгчийн нэг болох мөрдөгч “бие даасан, хараат бус” байх шинжийг хуульчлан хамгаалаагүй өдий хүрчээ. Эдгээрээс үзэхэд, манай улсын шүүх эрх мэдлийн байгууллагын хамгийн эмзэг, эрсдэлтэй цэг нь мөрдөн тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэгч мөрдөгчийн хараат бус байдлын асуудал болжээ.

Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, хараат бус байдалд нь халдсан аливаа дарамт, шахалт, нөлөөллийн талаар дээд шатны прокурорт мэдүүлэх үүрэгтэй гэж хуульчилсан нь шүүгчийн эрх зүйн байдлынхтай ижил зохицуулалт байгаагаас үзэхэд, эрүүгийн процесс хэрэгжүүлэгчид хөндлөнгөөс нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах чухал зохицуулалт болжээ. Гэвч нөлөөллийн талаарх зохицуулалт мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой салбарын хууль тогтоомжид тусгалаа олоогүй нь мөрдөгчийн бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулаагүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

ЭХХШТХ-д МША-ны явцад гаргах процессын шийдвэрийн ихэнхийг прокурорт хариуцуулсан, мөрдөгчийн нотлох баримт цуглуулах үйл ажиллагаа бүрд прокурорын зөвшөөрлийг өргөтгөсөн нь нэг талаас мөрдөн шалгах ажиллагааны явцад гарах алдаа

гэдэг агуулгаар тайлбарладаг. Үе болгоны шийдвэр нэг нэгэнтэйгээ уялдсан байдаг бөгөөд хэрэв доод түвшний шийдвэр үйл ажиллагаа алдагдвал дээд түвшний шийдвэр үйл ажиллагаа бүрэн, бодитой бус болно гэж үздэг. Үүнээс мөрдөгчийн гүйцэтгэх үүрэг ЭХХША-д чухал байр суурь эзлэдгийг харж болно.

¹⁰⁶ Гэмт хэргийн цагаан ном-2017; 2018; 2019; 2020; 2021 оны тайлан.

багасах, хүний эрхийг зөрчихгүй байх баталгааг сайжруулсан мэт боловч, нөгөө талаасаа мөрдөгчийн бие даасан, хараат бус байдлыг алдагдуулах болжээ. Тухайлбал, мөрдөгч хуульд заасан хэргийн бодит байдлыг тогтоох үүргээ хэрэгжүүлэх явцдаа гэрч, сэжигтэн, яллагдагч, хохирогчийг дуудан ирүүлж мэдүүлэг авах шаардлага үүсдэг. Гэтэл мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь процессын оролцогчид ямар нэгэн хууль зүйн үр дагавар үүсгэдэггүй хуулийн зохицуулалт нь мөрдөгчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл дагуулсаар байна. Гэмт хэргийг шалгаж тогтоох үүрэг хүлээсэн этгээдийн байр сууринаас авч үзэхэд нэг этгээдийн эрх нь өөр нэг этгээдийн хувьд үүргийг бий болгоно¹⁰⁷ гэсэнтэй зөрчилдсөн зохицуулалт болжээ. Мөн Эрүүгийн процессын хуульд мөрдөгчийн 14 эрх хэмжээтэй байхаар заасан боловч дан ганц мөрдөгчийн хүсэл сонирхлоос хамаарах, өөрөөр хэлбэл, тухайн фактын эцсийн үр дагаварыг үүсгэж чаддаггүй бүгд прокурорын оролцоо, хамаарлаас шалтгаалж байгаа нь мөрдөгч хараат бусаар мөрдөн тогтоох чиг үүрэг хэрэгжүүлэх боломжгүйг харуулна. Мөрдөгчийн хараат бус бие даасан байдал нь нийгэмд шударга ёс тогтоох үйл ажиллагааны үр дүнтэй шууд хамааралтай болох нь судалгааны явцад тодорхойлогдож байна.

Дүгнэлт

Гэмт хэрэг илрүүлэх, шүүхээр шийдвэрлэх үйл явцыг дэлхий нийтээр эрх зүйн аймгаас хамаарч харилцан адилгүй зохицуулж буй боловч хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрүүгийн процессын зарчим хэдийн бий болжээ. Эдгээр зарчмыг үндэсний хууль тогтоомжид нутагшуулснаар хүний эрхийг хангах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн тогтолцоог бий болгох боломжтой аж.

Мөрдөгч нь ЭХХША дахь “мөрдөн тогтоох” чиг үүргийг хэрэгжүүлдэг болох нь үндэсний хууль тогтоомж, мөрдөгчийн гүйцэтгэх үүргийн мөн чанарын хүрээнд хийсэн судалгаагаар тодорхойлогдож байна. Мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг танин мэдснээр мөрдөгчийн ахуй /эрх зүйн байдал/-г тодорхойлох боломжтой. Өөрөөр хэлбэл, хуульд мөрдөгч хэргийг илрүүлж, нотлох баримт цуглуулах үүрэгтэй гэж заасан боловч энэхүү үүргээ хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзээгүй орхигдуулсан. Энэ нь мөрдөгч хэргийн бодит байдлыг тогтоох чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүй болгожээ.

Манай улсын хувьд, ЭХХША хэрэгжүүлэгчдийн эрх зүйн байдал харилцан адилгүй хуульчилсан боловч хууль дээдлэх, үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан, ил тод явуулах гэсэн үндсэн нийтлэг шинжийг агуулсан байх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, ЭХХША хэрэгжүүлэгчдийн дээрх үндсэн зарчим нь чиг үүргийнх нь мөн чанараас урган гарсан бөгөөд “мөрдөн тогтоох” чиг үүрэг мөн дээрх шинжийг агуулсан байх нь зүйн хэрэг. Мөрдөн тогтоох чиг үүрэг хэрэгжих шинж нь түүнийг хэрэгжүүлэгч мөрдөгчид мөн давхар агуулагдаж байх учиртай. Энэ утгаараа мөрдөгч ЭХХША-г хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх ёстой болохыг харуулна.

Монгол Улсад ЭХХША-г шүүх, прокурор, мөрдөгч хэрэгжүүлдэг хуулийн зохицуулалттай. Шүүгч, прокурорын эрх зүйн байдал өндөр түвшинд хангагдсан байна. Шүүх эрх мэдлийн хэрэгжилт шүүх, прокурорын байгууллагын хараат бус, бие даасан байдалтай салшгүй холбоотой. Энэ утгаараа шүүх, прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлого тасралтгүй хэрэгжсээр байдаг. Харин мөрдөгчийн хараат бус, бие даасан байдлыг өнөөдрийг хүртэл хугацаанд хуульчлан бэхжүүлээгүй нь мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанар, онцлогийг танин мэдээгүйтэй холбоотой юм. Энэ нь зохион байгуулалтын Энтони гурвалжингийн онолоор “шүүх эрх мэдэл” хэмээх тогтолцооны оршин тогтнох фундамент, үндсэн суурь нь эрсдэлтэй тохиолдолд тухайн тогтолцоо тэр чигтээ эрсдэлтэй нөхцөлд байгааг илэрхийлнэ.

¹⁰⁷ Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. Орч. Хатанбаатар, М., ред. Амарсанаа, Ж. -УБ., 2013. 138 дахь тал.

Мөрдөгчийн хараат бус, бие даасан шинж алдагдах нь гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус, бие даасан байдал алдагдах эрсдлийг дагуулна. Тодруулбал, эрүүгийн хэргийг зөвхөн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд хянан шийдвэрлэдэг. Энэхүү нотлох баримтыг мөрдөгч илрүүлж, бэхжүүлэн авдаг. Тэгэхээр мөрдөгчийн юуг, хэрхэн бэхжүүлж авсан, аваагүйгээс тухайн хэргийн хувь заяа шийдвэрлэгдэж буй бөгөөд мөрдөгчийн хэргийн бодит байдлыг тогтоох эрмэлзэл нь хөндлөнгийн нөлөөлөлд авташгүй, бусдаас хамааралгүй бие даасан шинжтэй байж сая жинхэнэ утгаараа хэргийн бодит байдлыг тогтоох боломж бүрдэнэ. Иймд мөрдөгчийн хараат бус байх шинж нь хэрэгжүүлж буй мөрдөн тогтоох чиг үүргийнх нь шаардлага бөгөөд зайлшгүй хангах үндсэн шинж нь болно.

Мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилтэд прокурор давамгайл оролцож байгаа нь “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно¹⁰⁸” гэсэнтэй зөрчилдсөн гэж үзэхээр байна. Учир нь прокурор тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэх, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гаргах зэрэг эрх хэмжээ нь хяналт тавих бус харин “мөрдөн тогтоох” чиг үүргийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх шинжтэй болох нь тодорхой байна. Нөгөөтэйгүүр прокурор өөрийн олгосон зөвшөөрөл, гаргасан шийдвэрийг хянах нь логикийн хувьд боломжгүй юм.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992.
2. Эрүүгийн хууль 2015.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017.
4. Шүүхийн тухай хууль 2021.
5. Прокурорын тухай хууль 2017.

Ном, сурах бичиг:

6. Амарбаясгалан, Б., Мөнхбат, М. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. -Уб.,2018.
7. Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага //Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхтгэл. -Уб.,2019.
8. Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. Ерөнхий анги. -Уб.,2014.
9. Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. -Уб.,2020.
- 10.Баярсайхан, Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. -Уб.,2015.
- 11.Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. -Уб.,2018.
- 12.Бямбаа, Ж. Мөрдөх чиг үүргийн агуулгыг шинээр тодорхойлох нь// Хууль дээдлэх ёс. Хууль зүйн эрдэм шинжилгээ, практикийн улирал тутмын сэтгүүл. - Уб.,2018.
- 13.Гэмт хэргийн цагаан ном-2017; 2018; 2019; 2020; 2021 оны тайлан.
- 14.Дамбажав, И. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. I боть. -Уб., 2010.
- 15.Нямбаатар, Х., нар. Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. -Уб., 2020.
- 16.Оюунчимэг, Т. Мөрдөгчийн чиг үүргийн агуулга, мөн чанар. //Хууль сахиулахуй. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. -Уб.,2023. №3.
- 17.Сайнбаяр, Н. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онол, практикийн асуудал// Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -Уб.,2023.

¹⁰⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

18. Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. Орч. Хатанбаатар, М., ред. Амарсанаа, Ж.-Уб., 2013.
19. Цогтбаатар, Б. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл.- Уб., 2021.
20. Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. 30000 орчим үгтэй. -Уб., 1966.
21. “Эрх зүй” сэтгүүл. -Уб., 2014. №3.(39).
22. Эрхэсхулан, Ж. Шүүхийн мэтгэлцээн ба шүүмжлэлт рационализм.// Эрх зүй сэтгүүл. -Уб., 2011. №1.
- Гадаад хэл дээрх эх сурвалж:
23. Быков, В.М., Александров, А.С. и др. Уголовный процесс. -М., 2015.
24. Головкин, Л.В. Альтернативы уголовному преследованию в современном праве. -СПб., 2008.
25. Rene David. Les grands systemes de droit contemporains. Основные правовые системы современности. Перевод с французского языка д.ю.н. Туманов, В.А. - М., 1988.
26. Criminal procedure. A worldwide study. Carolina. 2007. P.21.
27. Kamisar, LaFare, I king. Modern criminal procedure. -W., 2005. P.118.
- Цахим эх сурвалж:
28. Хууль зүйн нэгдсэн сайт. //legalinfo.mn.
29. Кембрижийн толь бичиг. // <https://dictionary.cambridge.org/dictionary/english/investigate>.
30. Оксфордын толь бичиг. // <https://languages.oup.com/google-dictionary-en/>.

**ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ
/БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС/**

**COMPARISON OF RESTRAINT MEASURES
/CZECH REPUBLIC, UNITED STATES OF AMERICA/**

Б.Мөнхзул

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

*Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн ахмад*

Товч агуулга: Таслан сэргийлэх арга хэмжээний нэг болох цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг Бүгд Найрамдах Чех Улс болон Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн процессын хуульд тусгасан байдлын судалж, Монгол Улсын Эрүүгийн хэрэг шийдвэрлэх тухай хуультай харьцуулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлын талаар санал дэвшүүлсэн болно.

Abstract: One of the deterrent measures, custodial deterrent measures, is analyzed in the criminal procedure law of the Czech Republic and the United States of America and compared with the provisions of the Criminal Procedure Law of Mongolia, and proposals for future attention are made.

Түлхүүр үгс: Таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, Эрүүгийн процессын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

Keywords: Preventive measures, custodial restraining order, Criminal Procedure Code, Criminal Procedure Code.

Бүгд найрамдах Чех Улсын эрүүгийн процессын хуульд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг тусгасан байдал

Бүгд Найрамдах Чех Улс (Цаашид – БНЧУ гэх)-ын Эрүүгийн процессын хууль 1961 онд батлагдсан. Хэдийгээр өөрийн улсын түүхэн уламжлалыг хадгалсан боловч ЗСБНХУ-ын 1960 оны Эрүүгийн процессын хуулийг санагдуулахаар хууль болсон гэж судлаачид¹⁰⁹ үздэг. ЗСБНХУ-ын нөлөө БНЧУ-ын эрх зүйн тогтолцоонд шингэх болсон нь түүхэн учир холбогдолтой. Тодруулбал, Чехословак Улс нь 1918 оны 10 дугаар сарын 28-ны өдөр барууны улсуудын жишгээр шинэ нийслэл Прагт эрх чөлөөт-ардчилсан ба нийгмийн эрх зүйт улс болон тусгаар тогтнов.

Мюнхений хэлэлцээрийн дараа болон Венийн Анхдугаар шүүхийн шийдвэрийн дагуу 1938 онд тус улс Судетенландыг Германы эзэнт гүрэнд, Словакийн өмнөд хэсгээс заримыг нь Унгарт өгөх ёстой болов. 1939 оны 3 дугаар сард Словакийн Бүгд Найрамдах Улс нь Чехо-Словакийн Бүгд Найрамдах Улсаас салан тусгаарласан ба үлдсэн «Үлдэгдэл Чех» хэмээн нэрлэгдэх улсыг нь тун удалгүй Вермахт эзлэн, Бохеми ба Моравийн ивээлт улсыг байгуулав. Дэлхийн хоёрдугаар дайны дараа дахин байгуулагдсан бүгд найрамдах улс нь 1946 онд Карпатын Украйныг Зөвлөлт Холбоот Улсад өгсөн байна. 1948 оны 2 дугаар сарын бослогын дараа коммунист нам засгийн эрхийг гартаа авсан бөгөөд, удалгүй ЗХУ тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан Зүүн блокт нэгдлээ. Коммунист намын ноёрхол 1989 оны тайван хувьсгал хүртэл үргэлжлэв. 1992 оны 12 дугаар сарын 31-ний өдөр энэ улс задран БНЧУ ба Бүгд Найрамдах Словак Улсууд байгуулагдсан түүхтэй¹¹⁰. 1948 оноос хойш БНЧУ-ын

¹⁰⁹ Тузов А.Г. Введение в Уголовный процесс Чехии. // Вестник Санкт-Петербургского университета. Сер. 14. Вып. 3. 2015., Уголовно-процессуальное законодательство Чешской республики: учеб.-метод. Пособие // сост. Л.В. Майорова. Красноярск. 1999.

¹¹⁰<https://mn.wikipedia.org/wiki/%D0%A7%D0%B5%D1%85%D0%BE%D1%81%D0%BB%D0%BE%D0%B2%D0%B0%D0%BA>.

засгийн эрхийг коммунист нам гартаа авсан нь тухайн улсын эрх зүйн тогтолцоонд ЗХУ-ын үзэл баримтлал гүн шингэх үндсийг тавьсан гэхэд болно. Харин дэлхийн хоёрдугаар дайны үеэс эхлэн, ЗХУ задран унах хүртэл хугацаанд оршин тогтнож байсан Чехословак Улс тусгаар орших нөхцөл бүрдсэнтэй зэрэгцээд, БНЧУ-ын эрх зүйн тогтолцоонд социалист эрх зүйн зохицуулалтын үзэл баримтлалын эзлэх байр суурь багассан. Өөрөөр хэлбэл, БНЧУ нь 1991 онд Европын зөвлөлд гишүүнээр элссэн үеэс эхлээд, тус улсын эрх зүйн тогтолцоонд Европын холбооны үзэл баримтлал давамгайлах нөлөө үзүүлж эхэлсэн байна. БНЧУ нь олон тооны гэрээ, конвенциудад, тэр дундаа хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцод нэгдэн орсны хувьд эрүүгийн процессын ажиллагааг шударга явуулахаас гадна хүний эрхийг зөрчихгүй байх тал дээр голчлон анхаардаг. Энэ нь шүүхийн шатанд хэргийг шийдвэрлэхийн тулд олон улсын эрх зүйн хэм хэмжээг эш үндэс болгох байдлаар илэрнэ.

БНЧУ-ын Эрүүгийн процессын хуулийн 4 дүгээр бүлгийн 1 дэх хэсэгт цагдан хорих арга хэмжээ авах үндэслэл, шийдвэрлэлт, баривчлах тушаалын тухай, цагдан хорьсон талаарх мэдэгдэл, цагдан хорих хугацааг үргэлжлүүлэх болон бусад процессын талаар тодорхой тусгасан байдаг. Тодруулбал, БНЧУ-ын ЭПХ-ийн 67 дугаар зүйлд заасан дараах нөхцөл байдал, үндэслэл байгаа тохиолдолд яллагдагчид цагдан хорих ТСАХ авч болно. Үүнд:

1. Яллагдагч ЭБША болон ялаас зайлсхийхийн тулд оргон зайлсан, эсхүл оргон зайлж болзошгүй, хэрэв тухайн цаг хугацаанд яллагдагчийн хувийн байдлыг тогтоох боломжгүй, хэрэв яллагдагч байнгын оршин суух хаяггүй, эсхүл түүнд хүнд ял оногдуулахаар бол;

2. Яллагдагч шүүхийн өмнө мэдүүлэг өгөөгүй гэрчид болон тухайн хэргийн өөр бусад яллагдагчид нөлөөлж болзошгүй, эсхүл ЭБША-нд чухал нөлөө үзүүлэхүйц баримтыг тайлбарлахад саад учруулж болзошгүй;

3. Яллагдагч үйлдсэн гэмт хэргээ үргэлжүүлэн үйлдэж болзошгүй, өөрийн үйлдэхээр завдсан гэмт хэргийг төгсгөж болзошгүй, эсхүл өөрийн бэлтгэсэн болон үйлдэхээр заналхийлсэн гэмт хэргийг үргэлжлүүлэн үйлдэж болзошгүй¹¹¹. Эдгээр тохиолдол, үндэслэлийг харгалзан, яллагдагчид цагдан хорих ТСАХ авах боломжтой ажээ.

Эдгээр үндэслэлүүд нь манай улсын ЭПХ-д заасан цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүдтэй дараах байдлаар тохирч байна.

Хүснэгт 1. Монгол Улс ба БНЧУ-ын ЭПХ дахь цагдан хорих ТСАХ авах үндэслэлийн харьцуулалт

№	БНЧУ-ын ЭПХ дахь цагдан хорих ТСАХ авах үндэслэл	Монгол Улсын ЭХХШТХ дахь цагдан хорих ТСАХ авах үндэслэл
1	67 дугаар зүйлийн а) Яллагдагч ЭБША болон ялаас зайлсхийхийн тулд оргон зайлсан, эсхүл оргон зайлж болзошгүй	14.9 дүгээр зүйлийн 1.1. ЭХХША-аас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан
2	Яллагдагч шүүхийн өмнө мэдүүлэг өгөөгүй гэрчид болон тухайн хэргийн өөр бусад яллагдагчид нөлөөлж болзошгүй, эсхүл ЭБША-нд чухал нөлөө үзүүлэхүйц баримтыг тайлбарлахад саад учруулж болзошгүй	14.9 дүгээр зүйлийн 1.2. Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа

¹¹¹ Уголовно-процессуальное законодательство Чешской республики: учебно-методическое пособие // Краснояр. Гос. Ун-т; Сост. Л.В. Майорова. Красноярск. 1999. С. 49.

Хүснэгтэд харьцуулсан хоёр үндэслэл нь өөр хоорондоо яв цав тохирохгүй боловч, утга санааны хувьд төстэй байна. Хүснэгтийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл нь хоорондоо “хэргийн оролцогчдод нөлөөлж болзошгүй” байдлаараа төстэй байна. Харин бусад байдлаараа БНЧУ-ын цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд манай улсын цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүдээс утга санаа, үзэл баримтлалын хувьд ялгаатай гэж үзэж болохоор байна.

БНЧУ-ын ЭПХ-ийн 67 дугаар зүйлд заасан цагдан хорих үндэслэлүүд нь дотроо 3 хэсэгт хуваагдах боловч, эдгээрийг ангилан ялгавал, тухайн үндэслэлүүд хавьгүй олон болох боломжтой юм. Үүнд:

1. яллагдагч ЭБША болон ялаас зайлсхийхийн тулд оргон зайлсан, эсхүл оргон зайлж болзошгүй;

2. хэрэв тухайн цаг хугацаанд яллагдагчийн хувийн байдлыг тогтоох боломжгүй;

3. хэрэв яллагдагч байнгын оршин суух хаяггүй;

4. эсхүл түүнд хүнд ял оногдуулахаар бол;

5. яллагдагч шүүхийн өмнө мэдүүлэг өгөөгүй гэрчид болон тухайн хэргийн өөр бусад яллагдагчид нөлөөлж болзошгүй;

6. ЭБША-нд чухал нөлөө үзүүлэхүйц баримтыг тайлбарлахад саад учруулж болзошгүй;

7. яллагдагч үйлдсэн гэмт хэргээ үргэлжүүлэн үйлдэж болзошгүй;

8. өөрийн үйлдэхээр завдсан гэмт хэргийг төгсгөж болзошгүй;

9. эсхүл өөрийн бэлтгэсэн болон үйлдэхээр заналхийлсэн гэмт хэргийг үргэлжлүүлэн үйлдэж болзошгүй. Энэ мэтээр нийт 9 төрлийн үндэслэлээр цагдан хорих ТСАХ авах боломжтой болох нь харагдаж байна.

Манай улсын ЭХХШТХ-ийн 14.9 дүгээр зүйлд заасан цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд дундаас дээрхтэй утга санаа, үзэл баримтлалын хувьд тохирох 2 төрлийн үндэслэл байгааг дээр хүснэгтэд харуулсан билээ. Тэгэхээр Монгол Улсын ЭХХШТХ-д заасан цагдан хорих ТСАХ авах үндэслэлтэй харьцуулахад БНЧУ-ын ЭПХ-д цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд илүү өргөн хүрээтэй хуульчлагдсан байна.

БНЧУ-ын ЭПХ-ийн 68 дугаар зүйлд “Зөвхөн яллагдагчаар татагдсан этгээдэд цагдан хорих ТСАХ авах боломжтой. Хэргийн баримтад үндэслэн цагдан хорих ТСАХ авах тухай шийдвэр гаргана. Цагдан хорих ТСАХ авах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд төрийн төлөөлөгчийн хүсэлтээр шүүгч шийдвэрлэнэ”¹¹² гэж заасан. Эндээс БНЧУ-ын ЭПХ-ийн дагуу зөвхөн яллагдагчид цагдан хорих ТСАХ авагддаг, цагдан хорих ТСАХ авах шийдвэрийг мөрдөгч, прокурор бус гагцхүү шүүгч гаргадаг байдлаараа манай улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй ЭХХШТХ-тай адил байна.

БНЧУ-ын ЭПХ-ийн 69 дүгээр зүйл (Баривчлах тухай тушаал)-ийн 1 дэх хэсэгт “Хэрэв цагдан хорих үндэслэл байгаа бол яллагдагчаас мэдүүлэг авахдаа түүнийг дуудан ирүүлэх, саатуулах байдлаар ирцийг хангаж болохгүй. Урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд төрийн төлөөлөгчийн хүсэлтээр шүүгч, шүүх хуралдааны үед шүүх хуралдааныг даргалагч баривчлах тухай тушаал гаргана” гэж заасан. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүгч яллагдагчаас даруй мэдүүлэг авч цагдан хорих ТСАХ авах эсэх асуудлыг шийдвэрлэнэ...” гэж зааснаас үзэхэд, яллагдагчаас мэдүүлэг авах ажиллагааг зөвхөн цагдаагийн байгууллага бус шүүгч өөрийн биеэр явуулан, үргэлжлүүлэн цагдан хорих ТСАХ авах ажлыг зохион байгуулдаг нь онцлогтой байна.

БНЧУ-ын ЭПХ-ийн 70 дугаар зүйл (Цагдан хорих тухай мэдэгдэх)-д “Цагдан хорих тухай яллагдагчийн гэр бүлийн гишүүдийн аль нэгэнд болон түүний ажлын байрны удирдлагад түргэн мэдэгдэнэ. Зэвсэгт хүчин болон зэвсэгт нэгдэлд

¹¹² Мөн тэнд. 49 дэх тал.

харьяалагддаг яллагдагчийн дарга, захирагчид мэдэгдэнэ”¹¹³ гэж заасан нь манай улсын ЭХХШТХ-д заасантай тохирч байна.

Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн процессын хуульд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг тусгасан байдал

АНУ нь Эрүүгийн процессын тогтолцооны аккумуляцийн загварыг бий болгох, түүнийг хөгжүүлэн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Ялангуяа эрүүгийн хэргийг олон шат дамжлагагүй, түргэн шуурхай шийдвэрлэх, ялын олон сонголттой нөхцөлийг бий болгон, хялбаршуулж шийдвэрлэх талаар нэлээд туршлага хуримтлуулсан орон гэж үздэг. Түүнчлэн эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчмыг бий болгох, төлөвшүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан билээ. Америкийн эрүүгийн процесс нь Английн эрүүгийн шүүхийн нийтлэг жишгийн уламжлалд тулгуурлан, прецедентийн хэв маягт түшиглэж, түүнийг улам баяжуулж, хөгжсөн байдаг.

АНУ-ын эрүүгийн процессын эрх зүйн голлох эх сурвалжуудыг дурдвал:

- Үндсэн хууль (1787);
- Хүний эрхийн билл (1791);
- Холбооны Улсын хуулиудын нэгдсэн эмхэтгэл (1974-1976) 28 дугаар эмхэтгэл;
- Эрүүгийн нотлох баримт, нотолгооны тухай жишиг дүрэм (1972);
- Онц ноцтой гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны тухай Холбооны нэгдсэн дүрэм (1980);
- Мирандагийн жишиг дүрэм (1966) (Warning of Miranda);
- Давж заалдах шүүхийн чиглэмж, дүрэм (1986);
- Дээд шүүхийн тухай хууль (1980);
- Гэмт явдлын тархалт, илрүүлэлтэд хяналт тавих тухай хууль (1984);
- Холбооны Эрүүгийн загвар хууль (1962) гэх мэт.

Эдгээр эх сурвалжаас гадна, Холбоонд нэгдсэн Муж улсуудын Эрүүгийн хууль, Шүүн таслах ажиллагааны зарчим, дүрэм, түүнчлэн, холбооны хэмжээнд дагаж мөрдөхөөр Дээд шүүхээс тогтоосон прецедентүүд нь шууд хамааралтай үйлчилнэ. Эрүүгийн процесст хамааралтай 100 шахам прецедент өнөө хэр хүчин төгөлдөр үйлчилж, эрүүгийн шүүхийн практикт идэвхтэй хэрэглэгдсээр байна. АНУ-ын Холбооны хуулиудын нэгдсэн эмхэтгэлийн 28 дугаар ботийн 2254 дүгээр хэсэгт “Холбооны шүүхийн харьяаллын эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх нийтлэг журам”-ыг хуульчлан тодорхойлсон бол мөн ботийн 2255 дугаар хэсэгт, Холбооны болон Муж улсын хэмжээнд баривчлах, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих журмыг тогтоож өгчээ¹¹⁴. АНУ-ын Эрүүгийн процессын суурь зарчмуудыг тодорхойлоход Үндсэн хууль, Хүний эрхийн билл, Шүүхийн зарим прецедент голлох үүрэгтэйгээс гадна, Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд зонхилох нөлөөтэй юм. АНУ-ын Үндсэн хуулийн 4 дүгээр нэмэлтэд: “...Хүний хувийн орон сууц, өмч хөрөнгө, хувийн бичиг баримтад ямар нэгэн үндэслэлгүйгээр нэвтрэн орж шалгах, эсхүл баримт, шалтгаангүйгээр шууд баривчилж болохгүй. Хүний хувийн халдашгүй эрхийг хөндөх халдах, өмч хөрөнгийг нь хураах, нэгжлэг хийх эрхийг зөвхөн албан ёсны бөгөөд, тангараглаж баталгаажуулсан шүүхийн зөвшөөрлийн бичигт заасан хангалттай үндэслэлгүйгээр олгож, зөвшөөрч болохгүй”¹¹⁵ гэж заажээ. Харин 5 дугаар нэмэлтэд: “...Хэн ч ямар нэгэн эрүүгийн хэрэгт өөрийн эсрэг мэдүүлэг өгөх ёсгүй. Хэнийг ч эрх зүйн нэг хэрэг, зөрчлийн төлөө хоёр удаа яллаж болохгүй. Эрх зүйн зохих ёсны зөвшөөрөгдсөн процесс ажиллагааг явуулахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хасах, өмч хөрөнгийг хураах, амь насыг бусниулахыг хориглоно” гэж дурджээ.

¹¹³ Уголовно-процессуальное законодательство Чешской республики: учебно-методическое пособие // Краснояр. Гос. Ун-т; Сост. Л.В. Майорова. Красноярск. 1999. С. 51.

¹¹⁴ Бернам У. Правовая система США. М. 2006. С. 89-91.

¹¹⁵ Гученко К.Н. Основы уголовного процесса США. М. 1993. С. 15.

Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлтэд: "...Муж улс бүхэн эрх зүйн зохих ёсны процесс ажиллагаагүйгээр хүний амь насыг бусниулж, эрх чөлөөг нь хасаж, өмчийг нь хурааж болохгүй. Муж улсын хуульд хамрагдах ямар ч этгээдэд хуулийн эрх тэгш хамгаалалт үзүүлэхээс татгалзаж үл болно" гэж заасан байдаг. Эдгээр хэм хэмжээ нь хүний амьдрах хувийн халдашгүй эрхээ хамгаалуулах болон хувийн өмчийн эрхэнд төрөөс процессын бус аргаар халдахыг хатуу хориглосон агуулгыг илэрхийлдэг. Ер нь америкийн эрүүгийн процесст гэмт хэрэг үйлдсэн болохыг нь процессын арга хэрэгслээр урьдчилан шалгаж, шүүхийн зөвшөөрлөөр заавал дамжуулж байж, тухайн сэжиглэгдэж буй хүний эрхэнд халдах, эрхийг нь хязгаарлах зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хэрэгтнийг үйлдэл дээр нь баривчилснаас бусад ямар ч тохиолдолд сэжигтнийг таамаг, сэжгээр хорьж, мөрдөхгүй бөгөөд, зөвхөн баттай нотлох баримтад тулгуурлаж, процесс ажиллагааг явуулсны үр дүнд л эрхийг нь хязгаарлах, баривчлах, цагдан хорих арга хэмжээ авдаг¹¹⁶.

Америкийн Эрүүгийн процесст эрх зүйн шалгуур бүхий дор дурдсан агуулгыг шүүн таслах ажиллагаанд заавал хангах нөхцөл болгон тогтоосон байдаг. Үүнд:

1. Нэгэнт ил тодорхой болсон буюу хохирол нь төлөгдөж, ял тохиролцох боломжтой хэргүүдийг түргэвчилсэн журмаар шийдвэрлэх;

2. Эрүүгийн процесс нь шүүхийн урьдчилсан болон шүүн таслах хуралдааны агуулгаар тодорхойлогдох бөгөөд, шууд бус утгаараа шүүхийн өмнөх МША-ны үе шатыг үгүйсгэх;

3. Эрүүгийн процесст оролцогчдын эрх тэгш байдлыг хангах;

4. Шүүх хуралдааныг чөлөөтэй мэтгэлцэх аргаар явуулах;

5. Нотолгооны агуулгыг шүүх дээр мэтгэлцэгч талууд тодорхойлох;

6. Эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн харилцаанд оролцогч бүхэн үүрэг, хариуцлагаа өөрсдөө бие даан хүлээх;

7. Эрүүгийн процессын институт, тогтолцоо, систем нь төвлөрсөн бус, задран хуваарилагдаж, тус тусдаа боловч функциональ түвшинд чиг үүрэг нь хоорондоо харилцан уялдсан байх;

8. Эрүүгийн процессын үйл явц, чиг үүрэг бүхэнд нотолгооны стандарт аргачлал, зарчмуудтайн дээр, албадан гүйцэтгэх, баривчлах ажиллагаанд хүний хувийн эрх чөлөө, халдашгүй чөлөөт байдлыг байнга анхаарч харгалзах;

9. Эрүүгийн хэргийн нотлох ажиллагаанд нээлттэй буюу урьдчилсан хэлэлцүүлгийн аргаар зохистой, уян хатан, шударга ёсны зарчимд нийцсэн харьцангуй үнэлгээний шаардлагыг хангах гэх мэт багтана.

АНУ-д эрүүгийн хэргийг мөрдөн мөшгих, МША-ны явцад процессын албадлагын хэд хэдэн арга хэмжээг авч, хэрэглэсээр ирсэн байдаг. Ихэнхдээ баривчлах, мөнгөн барьцаагаар батлан даалтад гаргах, гэрийн хорионд цагдан харгалзах, торгууль хүлээлгэх зэрэг таслан сэргийлэх болон албадлагын арга хэмжээ авдаг. Нэгжлэг хийх, эд хөрөнгийг захиран зарцуулахыг түр хязгаарлах, гэмт хэрэг гарсан газар орчинд хамгаалалт тогтоох, баталгаа гаргуулах зэрэг арга хэмжээ авах нь бий. Баттай нотлох баримт бүхий гүйцэтгэх ажлын мэдээлэл, нотолгооны эх сурвалжид үндэслэн, сэжигтнээр тооцох ажиллагааг явуулсны үндсэн дээр тухайн сэжигтнийг баривчилна. Цагдаагийн баривчлах арга хэмжээг шүүхийн зөвшөөрөлтэй ба зөвшөөрөлгүй гэсэн хоёр ангилалд авч үздэг. Гэмт хэрэг үйлдэж байгаад цагдаагийн нүдэн дээр илэрч, баригдсан болон гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх илэрхий ул мөр, баримт сэлтүүд байгаа нь газар дээрээ нотлогдсон үед цагдаагийн офицер буюу цагдаагийн эрх бүхий албан тушаалтан шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах арга хэмжээ авч болно.

АНУ-ын Дээд шүүхийн 1991 онд гаргасан удирдамжид зааснаар 48 цаг хүртэл шүүхийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр цагдаа баривчлах арга хэмжээ авч болно. Шүүхийн зөвшөөрөлтэйгөөр баривчлах үед юуны өмнө тухайн сэжигтнийг хохирогч ба гэрч шууд зааж, таньж мэдүүлсэн байхаас гадна, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, яллах болон цагаатгах баримт сэлтийг нотлох баримтыг үнэлэх түвшинд

¹¹⁶ Мөн тэнд. 10-17 дахь тал.

мэтгэлцүүлэн хэлэлцүүлсний эцэст шүүгч мөрдөн шалгах шатанд цагдан хорих эсэхийг шийднэ. Шүүгч баривчлах шийдвэр гаргах үедээ баривчлагдсан этгээдэд Үндсэн хууль, шүүхийн прецедентээр тогтоосон эрхийг нь танилцуулна. Урьдчилан саатуулах буюу цагдан хорих хугацааг АНУ-ын эрүүгийн процессын журам, хууль тогтоомжид нарийвчлан заагаагүй боловч прецедентийн жишиг, дээд шүүхийн удирдамж, зарчмуудыг иш үндэс болговол 100 хоногоос хэтрүүлэхгүй байхаар тогтоосон байдаг. (1974 оны шуурхай шүүхийн хууль)

АНУ-ын Эрүүгийн шүүхийн процессын практикт шүүхийн өмнөх тусгайлсан шат байхгүй, ихэнхдээ түргэвчилсэн буюу ял тохиролцох байдлаар хялбаршуулж шийддэг учраас хүнд буюу ноцтой хэргийн хувьд шүүхэд шилжихээс өмнөх процесс ажиллагаа нь 21 хоногоос 90 хоног хүртэлх хугацаанд үргэлжлэх нь бий. Баривчлах болон цагдан хорьж албадан саатуулах, түүнчлэн эрүүгийн процессын мөрдөн мөшгих болон албадлага хэрэглэх үед хүний эрхийг хангахад чиглэгдсэн дараах голлох прецедент үйлчилдэг.

Хүснэгт 2. Эрүүгийн процессын албадлага хэрэглэх үеийн хүний эрхийг хамгаалах прецедентийн жагсаалт

№	Шүүхийн прецедентийн	Шүүхийн прецедентийн үзэл санаа
1	Miranda v. Arizona 384 US 436 (1966)	Баривчлагдсан буюу албадан саатуулагдсан этгээд цагдаагийн тавьсан асуултад хариулахгүй байх эрхтэй. Энэ нь өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, цагдаагийн тулган хүлээлгэсэн хэргийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрхээр баталгаажсан.
2	Mapp v. Ohio 367US.643 (1961)	Муж улсын хэмжээнд эрүүдэн шүүж, мөрдөн мөшгөж дарамт шахалт үзүүлэх замаар гаргуулж авсан нотлох баримтыг хууль бус гэж үзэх ба цагдаагийн цуглуулсан хууль бус нотлох баримтыг яллагдагч, шүүгдэгчийн эсрэг болон шүүх хуралдаанд нотолгооны эх сурвалж болгон хэрэглэхгүй байхаар тогтоосон.
3	Gideon v. Wainwrigh 372 US 335 (1963)	Эрүүгийн процесст яллагдагч нь өмгөөлөгч авах үнэмлэхүй эрхтэй. Хүнд гэмт хэрэг үйлдсэн, баривчлагдсан яллагдагч, шүүгдэгч өмгөөлөгч хөлслөх эдийн засгийн боломжгүй бол төрийн зүгээс заавал өмгөөлөгчөөр хангана.
4	Terry v. Ohio 392 US 1 (1968):	Цагдаагийн ажилтан ямар нэгэн нотлох баримтгүй, үндэслэл шалтгаангүйгээр, сэжиг таамгаар хүний биед дур мэдэн хүрч, баримтгүйгээр баривчилж болохгүй. Түүнчлэн шүүхийн зөвшөөрөлгүйгээр хүний өмч, хөрөнгөд халдаж, хурааж болохгүй.
5	Furman v. Georgia 408 U.S.238 (1972)	Торгуулиас эхлээд ялын дээд хэмжээ – цаазаар авах ял сонссон ямар ч хүнд тухайн шийтгэлийг нь хэт харгис аргаар буюу удаан хугацаанд гүйцэлдүүлэхээр тамлан зовоож болохгүй. Эрх нь хасагдсан ба хязгаарлагдсан хэн боловч хууль шүүхийн өмнө эрх тэгш хамгаалалт авах эрхтэй.
6	United states v. Salerno, 481 US 739 (1987)	Хүнд ноцтой биш гэмт хэрэгт баривчлагдсан болон саатуулагдсан этгээдийг зохих хэмжээний барьцаагаар суллаж, батлан даалтад гаргаж болох боловч, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, баривчлагдсан,

	цагдан хоригдсон этгээдийг өндөр барьцаа шаардаж суллах буюу давхар шийтгэж болохгүй гэх мэт.
--	---

Тэгэхээр АНУ-ын эрүүгийн процесс нь Английн эрүүгийн шүүхийн нийтлэг жишгийн уламжлалд тулгуурлан, прецедентийн хэв маягт түшиглэсэн болох нь Холбоонд нэгдсэн муж улсуудын Эрүүгийн хууль, Шүүн таслах ажиллагааны зарчим, дүрэм, түүнчлэн, холбооны хэмжээнд дагаж мөрдөхөөр Дээд шүүхээс тогтоосон прецедентүүд нь шууд хамааралтай үйлчилдэг бөгөөд Эрүүгийн процесст хамааралтай 100 шахам прецедент өнөө хэр хүчин төгөлдөр үйлчилж, эрүүгийн шүүхийн практикт идэвхтэй хэрэглэгдсээр ирсэн түүхэн уламжлалаас харагдаж байна.

АНУ-ын Эрүүгийн процессын суурь зарчмуудыг тодорхойлоход Үндсэн хууль, Хүний эрхийн билл, Шүүхийн зарим прецедент голлох үүрэгтэйгээс гадна, Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд зонхилох нөлөөтэй байна. Муж бүхэн өөр өөрийн хууль тогтоомжтой боловч эдгээр хууль тогтоомжийн найруулга нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг агуулсан байхыг шаарддаг байна. Үүний нэг жишээ нь Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлтэд заасан "...Муж улс бүхэн эрх зүйн зохих ёсны процесс ажиллагаагүйгээр хүний амь насыг бусниулж, эрх чөлөөг нь хасаж, өмчийг нь хурааж болохгүй. Муж улсын хуульд хамрагдах ямар ч этгээдэд хуулийн эрх тэгш хамгаалалт үзүүлэхээс татгалзаж үл болно" гэж зааснаас тод харагдаж байна.

АНУ-ын эрүүгийн процесст гэмт хэрэг үйлдсэн болохыг нь процессын арга хэрэгслээр урьдчилан шалгаж, шүүхийн зөвшөөрлөөр заавал дамжуулж байж, тухайн сэжиглэгдэж буй хүний эрхэнд халдах, эрхийг нь хязгаарлах зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хэрэгтнийг үйлдэл дээр нь баривчилснаас бусад ямар ч тохиолдолд сэжигтнийг таамаг, сэжгээр хорьж, мөрдөхгүй бөгөөд, зөвхөн баттай нотлох баримтад тулгуурлаж, процесс ажиллагааг явуулсны үр дүнд л сая нэг эрхийг нь хязгаарлах, баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрддэг байна.

Дүгнэлт

1. БНЧУ-ын ЭПХ-ийн дагуу зөвхөн яллагдагчид цагдан хорих ТСАХ авагддаг, цагдан хорих ТСАХ авах шийдвэрийг мөрдөгч, прокурор бус гагцхүү шүүгч гаргахаас гадна, яллагдагчаас мэдүүлэг авах ажиллагааг зөвхөн цагдаагийн байгууллага бус, шүүгч өөрийн биеэр явуулан, үргэлжлүүлэн цагдан хорих ТСАХ авах эсэхийг шийдвэрлэдгээрээ онцлогтой байна.

2. АНУ-ын эрүүгийн процессын онцлог давуу тал нь тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг урьдчилан шалгаж, шүүхийн зөвшөөрлөөр тухайн сэжиглэгдэж буй хүний эрхэнд халдах, эрхийг нь хязгаарлах зарчим үйлчилдэгт оршино. Мөн гэмт хэрэгтэн үйлдэл дээрээ цагдаагийн албан хаагчид баригдсан болон гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх илэрхий ул мөр, баримт байгаа тохиолдолд, цагдаагийн эрх бүхий албан тушаалтан шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах арга хэмжээ авах боловч, заавал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, яллах болон цагаатгах баримт сэлтийг нотлох баримтыг үнэлэх түвшинд мэтгэлцүүлэн хэлэлцүүлсний эцэст шүүгч мөрдөн шалгах шатанд цагдан хорих эсэхийг шийддэг байдал нь хүний эрхийг хангах, үндэслэлгүйгээр цагдан хорих байдлыг багасгах үндэс болдог ажээ. Хүний эрхийг хамгаалах үзэл баримтлалыг өндөр түвшинд сахидаг болох нь олон улсын гэрээ, конвенциудад үлгэр жишээч байдлаар нэгдэн орохоос гадна дотоодын олон хууль тогтоомж нь хүний эрхийг хангахад чиглэсэн үзэл баримтлалыг дэвшүүлэн, хэрэгжүүлдэг зэргээс харагдаж байна.

3. Мөн хөнгөн гэмт хэрэгт холбогдож баривчлагдсан болон саатуулагдсан этгээдэд цагдан хорих ТСАХ авах явдал маш бага бөгөөд, түүнийг барьцаагаар суллаж, батлан даалтад өгөх арга хэмжээг түлхүү авч байгаа байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шоронжуулах бус илүүтэйгээр нийгэмшүүлэх зорилго агуулж байна гэж дүгнэхээр байна. Монгол Улсын ЭХХШТХ-д уг сайн туршлагыг нэвтрүүлснээр цагдан хорих ТСАХ-г хавтгайруулан хэрэглэж, хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх сайн талтай гэж үзэж байна.

Санал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.5-д зааснаар гэмт хэргийг хөнгөн ба хүнд гэж ангилдаг. Хөнгөн гэмт хэрэг гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг 5 жил түүнээс доош эсвэл хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэргийг хэлдэг. Хөнгөн гэмт хэрэг нь нийгмийн хор аюулаар бага мөн оногдуулж болох ял нь хорихоос өөр төрлийн ял оногдуулж болох тул хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх нь зөв гэж үзэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
2. Америкийн Нэгдсэн Улсын Эрүүгийн процессын тухай хууль.
3. Бүгд Найрамдах Чех Улсын Эрүүгийн процессын тухай хууль.

Гадаад хэл дээрх эх сурвалж:

4. У.Бернам "Правовая система США". 2006 год.
5. К.Н.Гученко "Основы уголовного процесса МША". 1993 год.
6. Л.В.Майорова "Уголовно - процессуальное законодательство Чешской республики: учебно - методическое пособие". 1999.
7. А.Г.Тузов "Введение в Уголовный процесс Чехий". 2005.

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗАРИМ УЛСЫН ХУУЛИУДАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

A COMPARISON ANALYSIS OF THE USE OF CUSTODIAL LIMITATIONS AND DETENTION WITH COUNTRIES' LEGAL SYSTEMS

Э.Хишигбайгаль

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг Оросын Холбооны Улс, Бүгд найрамдах Хятад ард Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад хэрхэн хуульчлан тогтоож өгсөн болон мөрдөн шалгах ажиллагааны туршлагыг харьцуулан судлахыг зорьсон болно.

Abstract: Our study aims to intended to compare between the practice of investigation and how custodial measures are legislated in the Criminal Procedure Laws of the Russian Federation and the Republic of China.

Түлхүүр үгс: Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хорих хугацаа, эрүүгийн байцаан шийтгэх хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

Keywords: Detention, restraining order, detention period, criminal procedure law, criminal procedure law.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЭХХШТХ” гэх), тогтоомжийг төгөлдөржүүлэхийн тулд гадаад улсуудын гэмт хэрэгтэй тэмцэх болон мөрдөн шалгах ажиллагаа (цаашид “МША” гэх)-ны туршлагыг судлах нь эргэлзээгүй чухал бөгөөд, сонирхол төрүүлж байна. Энэ талаар эрдэмтэн М.Ансель “Гадаад улсын туршлагыг судлах явдал нь хуульч, судлаачдад шинэ, далайцтай мэдлэг олгохоос гадна, өөрийн улсын эрх зүйн талаар гүнзгий мэдлэг эзэмших үүд хаалгыг нээдэг. Хуулийн өвөрмөц онцлог нь бусад системтэй харьцуулсан шинжилгээний үр дүнд илэрдэг. Харьцуулсан судалгаа нь хуульчийг зөвхөн өөрийн улсын эрх зүйн тогтолцоог сайн судалснаар олж авах боломжгүй тэр үзэл санаа болон аргументаар зэвсэглэх хүчтэй”¹¹⁷ гэж оновчтой тодорхойлсон.

Хамгийн шилдэг гэх эрүүгийн процессын тогтолцоо байна уу? байсан уу? байж болох уу? гэдэг талаар цөхрөлтгүй эрэл, хайгуул хийх, улмаар тийм тогтолцоог нутагшуулан, цогцлоох нь төр улсын төдийгүй, хуульч бүрийн эрхэм зорилго, түүгээр үйлчлүүлж, амар тайван хамгаалуулан аж төрөх нь иргэн бүрийн нандин хүсэл болох нь ойлгомжтой¹¹⁸. Иймд хөрш орнууд болох Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх) -ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (цаашид “ЭБШХ” гэх) дахь цагдан хорих Таслан сэргийлэх арга хэмжээ (Цаашид ТСАХ гэнэ)-ний ойлголт, үндэслэл, зохицуулалтын талаар дэс дараатай харьцуулалт хийх нь чухал гэж үзлээ.

Оросын эрүүгийн процесс нь кодификацчилал болон эрх зүйн эх сурвалж талаас нь авч үзвэл, эх газрын системийн хүрээнд хамаарагддаг боловч, эрүүгийн процессын суурь зарчим, субъектийн болон чиг үүргийн хуваарилалт, агуулга, мөн чанарын хувьд Франц, Герман, Итали, Испани зэрэг Европын орнуудын нийтлэг загвараас илт ялгагддаг талаар судлаач Д.Баярсайхан цохон тэмдэглэсэн байна¹¹⁹.

¹¹⁷ Ансель М. Методологические проблемы сравнительного права // Очерки сравнительного права : сб. М., 1981. С. 38.

¹¹⁸ Эрхэсхулан Ж. Монголын эрүүгийн процессын тогтолцооны онцлог, сорилт, бэрхшээл // Монгол Улсын процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудал. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2023. 15 дахь тал.

¹¹⁹ Баярсайхан Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. Анхны хэвлэл. Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль. УБ. 2015. 100 дахь тал.

Хамгийн гол нь прокурорын хяналтын онцгой чиг үүргээс гадна шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгах ажиллагааны субъектийн харьяалал, статус болон нотлох ажиллагааны процедур, шүүх хуралдааны үйл явц, баривчлах, цагдан хорих хугацаа болон албадлагын арга хэмжээ авах процедур зэргээрээ зарчмын ялгаатай гэж үзэж болно.

Эрүүгийн процессын харилцаанд холбогдох зарим хуульчилсан акт эрх зүйн эх сурвалж болно. Тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, Дээд Шүүхийн Бүгд Хурлын тогтоол, Ерөнхий прокурор, Дотоод хэргийн сайдын тушаал, түүгээр батлагдсан журам, дүрэм, заавар гэх мэт. Оросын эрүүгийн процесст Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа (Цаашид ЭБША гэнэ)-ны нэгдмэл нэг хууль үйлчилдгээс гадна, шүүхийн прецедент болон түүнтэй адилтгах шүүхийн практик, зарчим зэрэг нь эрх зүйн эх сурвалж болдоггүй. ОХУ-ын эрүүгийн процесс нь ОХУ-ын Үндсэн хуульд заасан хүний эрхийн суурь зарчмуудыг удирдлага болгодог. Үндсэн хуульд Шүүх эрх мэдлийн зарчмуудыг тогтоосон нь эрүүгийн процесст ихээхэн хамааралтай. ОХУ-ын Үндсэн хуулийн холбогдох заалт, хэм хэмжээнүүд нь эрүүгийн процесст хүний эрхийг хангуулах, ЭБША-ны зорилго, зорилтыг хангахад эрх зүйн баталгаа болдгоороо ач холбогдолтой. Эрүүгийн процесст шууд хамааралтай Үндсэн хуулийн заалтуудын заримаас дурдвал:

➤ Хэн боловч хувийн эрх чөлөө, халдашгүй эрх эдэлнэ. (ҮХ-ийн 22 дугаар зүйлийн 1);

➤ Хэнийг ч шүүхийн шийдвэргүйгээр баривчлах буюу цагдан хорьж болохгүй. (ҮХ-ийн 22 дугаар зүйлийн 2);

➤ Шүүн таслах ажиллагаа зөвхөн хуулийн дагуу явагдана. (ҮХ-ийн 118 дугаар зүйлийн 1);

➤ Шүүгч нар хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль болон хуульд захирагдана. (ҮХ-ийн 120 дугаар зүйлийн 1).

Цагдан хорих нь хамгийн хүнд хэлбэрийн ТСАХ боловч түүний практикт хэрэглэгдэх байдал түгээмэл болохыг ОХУ-ын зарим судлаачид тэмдэглэсэн байна. Тодруулбал, Р.Р.Гашимов өгүүлэлдээ “Цагдан хорих нь хамгийн хүнд хэлбэрийн ТСАХ боловч практикт хамгийн ихээр авагддаг ТСАХ болж байна. ОХУ-ын Дээд Шүүхийн дэргэдэх Шүүхийн департаментийн статистик судалгаанаас үзэхэд, 2018 онд дүүргүүдийн шүүхэд цагдан хорих ТСАХ авах тухай мөрдөн байцаагчийн ирүүлсэн 58309 хүсэлтийн 52089-г зөвшөөрөн шийдвэрлэсэн байна. Гэтэл энэ цаг хугацаанд дүүргүүдийн шүүхэд сэжигтэн, яллагдагчид гэрийн хорионд оруулах ТСАХ авах тухай мөрдөн байцаагчийн нийт гаргасан 3768 хүсэлтийн 3334-г зөвшөөрөн шийдвэрлэж, барьцаа авах ТСАХ авах тухай мөрдөн байцаагчийн нийт гаргасан 76 хүсэлтийн 70-г зөвшөөрөн шийдвэрлэсэн тоон мэдээтэй байна”¹²⁰ гэж тэмдэглэсэн байна. Эндээс ОХУ-ын мөрдөн байцаагчдын зүгээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цагдан хорих ТСАХ авах саналыг шүүхэд түлхүү ирүүлдэг бөгөөд, шүүхээс ихэвчлэн зөвшөөрөн шийдвэрлэдэг болох нь харагдаж байна.

ОХУ-ын эрүүгийн процессын шинжлэх ухаанд ТСАХ-ний зорилгыг “сэжигтэн, яллагдагчийн зүй ёсны зан байдлыг хангах замаар байцаан шийтгэх ажиллагааг явуулахад таатай нөхцөл бүрдүүлэх, чухам сэжигтэн, яллагдагч мөрдөн байцаалт, шүүхээс болон ял эдлэхээс зайлсхийх явдлыг таслан зогсоох, гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг хязгаарлах, хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах оролдлогыг үгүй хийхэд оршино”¹²¹ гэж тодорхойлсон байдаг. А.Д.Бойков “Цагдан хорих нь гэмт хэргийг таслан зогсоож, гэмт хэрэгтэн болон гэмт бүлэглэлийг ёс

¹²⁰ Гашимов Р.Р. Проблемные вопросы применения меры пресечения в виде заключения под стражу // Образование и право. 2019. №10. С. 165.

¹²¹ <https://cyberleninka.ru/article/n/ponyatie-i-znachenie-mery-presecheniya-v-vide-zaklyucheniya-pod-strazhu-v-ugolovnom-sudoproizvodstve/viewer>.

суртахуунжуулах ажиллагаа”¹²² гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, уг ТСАХ нь гэмт этгээдийг тусгаарлах замаар сэтгэл зүйн дарамт үзүүлэх хэрэгсэл болж таарч байна. Зарим эрдэмтэд цагдан хорих ТСАХ-ний зорилгыг “аюултай этгээдүүдээс нийгмийг тусгаарлах хэрэгсэл”¹²³ гэж тодорхойлсон нь маргаан ба шүүмжлэлийг дагуулжээ. Хэдийгээр уг зорилго нь хуулийн үзэл баримтлалтай харшилж байгаа боловч, зарим талаараа дээр дурдсан ТСАХ-ны зорилготой нийцэж (...гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг хязгаарлах, хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах оролдлогыг үгүй хийх...) байгааг тодотгох нь зүйтэй. Тэр ч бүү хэл, зарим улсын хуульд уг үзэл баримтлалыг хэрэглэдэг. Жишээлбэл, АНУ-ын хуульд “Хэрэв яллагдагч орчин тойрондоо аюул, заналхийлэл үүсгэж байгаа тохиолдолд түүнийг баривчилна”¹²⁴ гэж заасан байна.

В.М.Корнуков., О.И.Цоколова нар “Цагдан хорих ТСАХ-ний чухал онцлог нь бусад төрлийн ТСАХ-г бодвол хатуу, чангын дээд түвшин юм. Үүнийг батлах баримт нь ялын хүнд хэлбэр болох хорих ялтай адил шинжтэйд оршино”¹²⁵ гэж оновчтой тодорхойлжээ. Үнэхээр цагдан хорих ТСАХ нь хорих ялтай олон шинжээрээ ижил болох нь ойлгомжтой юм.

Цагдан хорих нь ТСАХ-ний нэг төрөл болохын хувьд тодорхой шаардлага хангасан байх ёстой. Үүнд:

1. Эрүүгийн хэрэг үүсгэсэн байх;
2. Эрх бүхий субъект гүйцэтгэсэн байх;
3. Яллагдагчид (онцгой тохиолдолд сэжигтэнд) авагдсан байх;
4. ЭПХ-д заасан үндэслэлтэй тохиолдолд авагддаг байх гэх мэт¹²⁶.

Тус улсын Эрүүгийн процессын хууль (Цаашид ЭПХ гэнэ)-иар албадлагын арга хэмжээг дараах гурван үндсэн төрөлд ангилан авч үздэг. Үүнд:

- 1) Сэжигтнийг баривчлах (ЭПХ-ийн 91-96 зүйл);
- 2) ТСАХ (ЭПХ-ийн 97-110 зүйл);
- 3) Албадлагын бусад арга хэмжээ (ЭПХ-ийн 111-118 зүйл).

ЭПХ-ийн 97 дугаар зүйлд ТСАХ авах нийтлэг үндэслэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 1) Мөрдөн байцаалт болон шүүхээс оргон зугтах;
- 2) Үргэлжлүүлэн гэмт хэрэг үйлдэж болзошгүй;
- 3) Гэрч болон бусад оролцогчдыг заналхийлж болзошгүй, нотлох баримт устгаж болзошгүй, эсхүл ЭХХША-нд бусад байдлаар саад учруулж болзошгүй. Эдгээр үндэслэлээс аль нэг нь байгаа тохиолдолд, дор дурдсан ТСАХ-ний аль тохирохыг хэрэглэх боломжтой бөгөөд, сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамаарч ТСАХ авагддаг байна.

Хүснэгт 1. ОХУ-ын ЭПХ-д заасан ТСАХ-ны төрөл

№	ОХУ-ын ЭПХ-ийн 98 дугаар зүйл
1	Оршин суугаа газраасаа зөвшөөрөлгүйгээр гадагш явахгүй тухай баталгаа авхуулах
2	Батлан даалт

¹²² Бойков А.Д. Новый УПК Российской Федерации, его правовая и криминологическая характеристика // Научно-практическая конференция «Правовая и криминологическая оценка нового УПК РФ» // Государство и право. 2002. №9.

¹²³ Коврига З.Ю. Уголовно-процессуальное принуждение. Воронеж. 1975. С. 104.

¹²⁴ П. “b” ч. 4 120.80 Уголовно-процессуального кодекса штата Нью-Йорк (Criminal Procedure Law of the state of New York).

¹²⁵ Корнуков В.М. Указ. Соч. С. 9. Цоколова О.И. О понятии и сущности заключения под стражу // Российский следователь. 2005. №3. С. 11.

¹²⁶ Хапаев И.М. Понятие и значение меры пресечения в виде заключения под стражу в уголовном судопроизводстве. // Северо-Кавказский юридический вестник. 2014. №1. С. 126.

3	Цэргийн анги, нэгтгэлийн хяналтад байлгах
4	Насанд хүрээгүй яллагдагчийг хянан харгалзах
5	Тодорхой үйлдэл хийхийг хориглох
6	Барьцаа авах
7	Гэрийн хорионд байлгах
8	Цагдан хорих

ТСАХ авах үндэслэлүүд дундаас цагдан хорих нь бусад төрлийн ТСАХ-ээс ялгагдах нэг онцлог нь цагдан хорих нэмэгдэл нөхцөлийг заасан бөгөөд, ЭПХ-ийн 108 дугаар зүйлд дараах байдлаар хуульчлагдсан.

Хүснэгт 2. ОХУ-ын ЭПХ-д заасан цагдан хорих ТСАХ хэрэглэх үндэслэл, журам

№	ОХУ-ын ЭПХ-ийн 108 дугаар зүйл
1	Илүү хөнгөн хэлбэрийн ТСАХ авах боломжгүй тохиолдолд, эрүүгийн хуульд гурваас дээш жилээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид шүүхийн шийдвэрээр цагдан хорих ТСАХ авна. Шүүгч тодорхой баримттай нөхцөл байдалд үндэслэн цагдан хорих ТСАХ авч, энэ талаараа захирамжид дурдана. Шүүх хуралдааны үеэр шалгагдаагүй, тодруулбал, энэ хуулийн 89 дүгээр зүйлд заасан шаардлагыг зөрчсөн гүйцэтгэх ажлын шугамаар олсон баримт зэрэг нь үндэслэл бүхий нөхцөл байдал болохгүй. Дараах нөхцөл байдлуудын аль нэг нь тогтоогдвол, онцгой тохиолдолд, гурав хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид энэхүү ТСАХ-г хэрэглэж болно.
-	Үүнд:
1)	сэжигтэн, яллагдагч нь ОХУ-ын нутаг дэвсгэрт байнгын оршин суух хаяггүй;
2)	сэжигтэн, яллагдагчийн хувийн байдал тодорхойгүй;
3)	урьд нь авсан ТСАХ-г зөрчсөн;
4)	сэжигтэн, яллагдагч урьдчилсан мөрдөн байцаалт болон шүүхээс оргон зайлсан ¹²⁷ .

“Илүү хөнгөн хэлбэрийн ТСАХ авах боломжгүй тохиолдолд” гэж заасан нь цагдан хорих ТСАХ-г эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг зорьсон утга, агуулгыг илэрхийлж байна. Мөн зөвхөн Эрүүгийн хуульд гурваас дээш жилээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих ТСАХ авахаар хуульчилснаас гадна, дээр дурдсан дөрвөн төрлийн нөхцөл байдалд (онцгой тохиолдолд) гурав хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих ТСАХ хэрэглэхээр заасан зэрэг онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, дээрх дөрвөн нөхцөл байдал тогтоогдоогүй бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэгт цагдан хорих ТСАХ хэрэглэдэггүй болж таарч байна.

Хүснэгт 3. ОХУ-ын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангилал¹²⁸

№	ОХУ-ын Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйл (Категории преступлений)
---	---

¹²⁷ ОХУ-ын хуулийн албан ёсны сайт.
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/4fef595255a2cca594fdc917279f0914e00ac194/
¹²⁸ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/a0182fc43a8bbf8974658cda72c860ddfb210c52/.

1	Гурваас дээшгүй жилийн хугацаатай хорих ял шийтгэхээр заасан, санаатай ба болгоомжгүй гэмт хэргийг хөнгөн гэнэ
2	Таваас дээшгүй жилийн хугацаатай хорих ял шийтгэхээр заасан санаатай, арваас дээшгүй жилээр хорих ял шийтгэхээр заасан болгоомжгүй гэмт хэргийг хүндэвтэр гэнэ
3	Арваас дээшгүй жилийн хугацаатай хорих ял шийтгэхээр заасан санаатай, арван таваас дээшгүй жилийн хугацаатай хорих ял шийтгэхээр заасан болгоомжгүй гэмт хэргийг хүнд гэнэ
4	Арваас дээш жилийн хугацаатай хорих ял болон илүү хүнд ял шийтгэхээр заасан санаатай гэмт хэргийг онц хүнд гэнэ

Хэрэв сэжигтэн, яллагдагчийн үйлдэлд ЭПХ-ийн 108 дугаар зүйлд заасан дөрвөн төрлийн нөхцөл байдал тогтоогтоогүй бол уг ангилалд заасан хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цагдан хорих ТСАХ авахыг урьтал болгохгүй байхаар заажээ. Гурав хүртэлх жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих ТСАХ авахдаа сэжигтэн, яллагдагчийн хувийн байдал болон байнгын оршин суух хаягтай эсэхийг харгалзахаас гадна, урьд нь авсан ТСАХ-г зөрчсөн болон оргон зайлсан тохиолдол бүрд үйлдэгдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс үл шалтгаалан цагдан хорих ТСАХ авдаг онцлогтой. Энэ нь сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, хэр хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр цагдан хорих ТСАХ авах эсэхийг шийдвэрлэж байгаа хэлбэр юм. Гэтэл манай улсын Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт хүртэл цагдан хорих ТСАХ авч байгаа нь хэр зэрэг оновчтой эсэх асуудал эргэлзээтэй. Бидний үзэж байгаагаар, ОХУ-ын жишгийг үндэслэн, Эрүүгийн хуульд хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт цагдан хорих ТСАХ авахыг хориглох нь зүйтэй юм.

БНХАУ нь хууль цаазын эртний уламжлалтай орнуудын нэг. Түүхэн эх сурвалжуудаас үзэхэд эртнээс иргэн ба эрүүгийн түүнчлэн эрүүгийн заргын хуулиудыг нэг төрөлжсөн хуульд хамтатган тогтоож байсан. Тэгэхдээ эрүүгийн гол болгож зарим иргэний хэрэг заргыг эрүү шийтгэлийн арга хэлбэрээр шийдвэрлэдэг, түүнчлэн эрүүгийн ба эрүүгийн заргын хуулийн хувьд авч үзвэл эрүүгийн хуулийг онцгойлон авч үздэг. Харин эрүүгийн зарга хэрхэн явуулах журмыг хуульчлах асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй байжээ. БНХАУ нь хэдийгээр социалист дэглэмтэй ардчилсан бус орон боловч, ЭБША-нд инквизицийн мөрдөн шалгах уламжлалыг аккаусацийн мэтгэлцүүлэн шүүх зарчимтай маш өвөрмөц аргаар хослуулж, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны хаалттай нөхцөлийг улс орны онцлогт нийцсэн байдлаар зохицуулж иржээ. Шинэ үеийн онцлогийг тусгасан ЭПХ-ийг 1979 онд баталж, 1980 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн боловч, 1990-ээд онд Зөвлөлт Холбоот Улс задарснаас үүдэн оросын школ бүхий уламжлалаас татгалзаж, шүүхийн шатанд Англи-Америкийн бүлийн яллах, өмгөөлөх талын оролцооны мэтгэлцэх хэлбэрийг тусгаж, зохицуулснаас гадна шүүхийн өмнөх шатанд уламжлалт болон Баруун Европын загварыг нэмж тусгах замаар өөрчлөлт шинэчлэлийг хийжээ.

Одоо үйлчилж буй ЭПХ-ийг Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их хурлын 1996 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаар баталсан ба уг хуулийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. ЭБША-г хэрэгжүүлэхэд Цагдаа, Дотоодын аюулаас хамгаалахын ажилтан, Прокурор, Шүүх голлон тус тусын эрх хэмжээний хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлдэг. Ингэхдээ тэдгээрийн эрх хэмжээ нь хуулиар болон тусгайлсан дүрмүүдээр нарийвчлан зааглагдсан байна.

Хятадын ЭПХ-д цагдаагийн болон прокурорын мөрдөн байцаалт явуулах, тэрчлэн албадан саатуулах, байцаалт явуулж, мөрдөн мөшгөх, зэрэг бүрэн эрх

ялгаатай байхаар зохицуулсан байдаг¹²⁹. Гэмт хэргийг илрүүлж, гэмт этгээдийг олж тогтооход чиглэгдсэн цагдаагийн процессын ажиллагаа нэлээд өвөрмөц юм. Юуны өмнө газар дээрээ баригдсан, ил тодорхой мэдээллээр шалгагдаж нотлогдсон этгээдийг цагдаа нь цагдаагийн газрын саатуулах төвд ирүүлж, 12 цагийн дотор мэдүүлгэн маягтыг бөглүүлж, шуурхай байцаалтыг явуулна. Цагдаа нь өөрийн эрх хэмжээнд тухайн этгээдийг 24 цаг хүртэл саатуулж, шуурхай ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд, шаардлагатай бол 3-30 хоног хүртэл сунгаж, мөрдөн мөшгөх ажиллагааг бие даан явуулж болно. Энэ тохиолдолд 3-30 хоног албадан саатуулах замаар түр цагдан хорьж болно гэсэн үг юм.

Прокурорын хувьд (Ардын прокурорын байгууллага) гол нь шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтад хяналт тавих, зарим онц хүнд хэргийг мөрдөн мөшгөх ажиллагааг биечлэн хэрэгжүүлэх, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох үүрэг хүлээнэ. Прокурор нь өөрийн зөвшөөрөл, эрх мэдлийн хүрээнд 2 сар хүртэл хугацаанд яллагдагчийг баривчлан саатуулах эрхтэй ба дахин нэг сараар сунгаж болно.¹³⁰ Хятадын эрүүгийн процесст баривчлагдсан буюу албадан саатуулагдсан этгээдийг сэжигтэн гэж тооцдог ба сэжигтэн, яллагдагч нь мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхгүйн дээр баривчлагдсан үеэс шууд өмгөөлөгч авах боломжгүй.

2012 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн их хурлаас баталсан БНХАУ-ын ЭПХ-ийн нэмэлт нь 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Энэхүү өөрчлөлтөөр албадлагын арга хэмжээ авах нөхцөл, журмын талаарх хоорондоо зөрчилтэй зарим заалтыг засч, өмгөөлөгч авахтай холбогдсон зохицуулалтыг нэмж оруулсан байна. Цагдан хорих, баривчлах үндэслэл, нөхцөлийг нарийвчлан зохицуулснаас гадна, гэр бүлийн гишүүдэд 24 цагийн дотор мэдэгдэх ёстой боловч, мэдэгдлийг хүргүүлэх боломжгүй гэсэн нөхцөлд “Үндэсний аюулгүй байдалд аюул учруулах” болон “терроризм” зэргийг оруулжээ. Үүнээс гадна, МША-нд саад учруулж байгаа нөхцөл байдал арилсан тохиолдолд, гэр бүлийнхэнд даруй мэдэгдэнэ. Нэмэлт, өөрчлөлт оруулсан 33 дугаар зүйлд: “...Эрүүгийн хэргийн сэжигтэн нь мөрдөн байцаах байгууллагын байцаалтад анх удаа орсон буюу албадлагын арга хэмжээ авагдсан өдрийн байдлаар өмгөөлөгч авах эрхтэй байна. Мөрдөн шалгах байгууллага нь эрүүгийн сэжигтнийг анх удаа байцаах буюу албадлагын арга хэмжээ авахдаа өмгөөлөгч авах эрхийг мэдэгдэх үүрэгтэй” гэжээ. Харин нэмэлт, өөрчлөлт оруулахдаа цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагчтай уулзах хүсэлт гаргаснаас хойш 48 цагийн дотор уулзалтыг зохион байгуулахаар заасан.

БНХАУ-д 1980-аад оны дунд үеэс эрүүгийн шүүхийн тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарсантай холбоотойгоор ЭБША-ны үе шат болон албадлагын арга хэмжээний нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлж өөрчлөн, шинэчилсэн байдаг. 1996, 2012 оны шинэ ЭБШХ-иар процессын албадлагын арга хэмжээг шүүхийн бодлого, эрх мэдлийн хүрээнд шинэчлэн тогтоосон. Ялангуяа баривчлах арга хэмжээг шүүхийн өмнөх шатан дахь цагдан хорих тогтолцоотой уялдуулж, дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Цагдаагийн бүрэн эрхийн дагуу гүйцэтгэх ажиллагааны баривчлах арга хэмжээ /24 цаг/;

2. Цагдаагийн бүрэн эрхийн дагуу мөрдөн мөшгөх ажиллагааны баривчлах арга хэмжээ /72 цаг буюу нэмж 30 хоног хүртэл сунгах эрхтэй/;

Дээр дурдсан баривчлах арга хэмжээний эхнийх нь зөвхөн цагдаагийн бүрэн эрхийн хүрээнд хийгдэх баривчилгаа бөгөөд, хоёр дахь нь прокурорт мэдэгдэх замаар хэрэгждэг.

3. Прокурорын бүрэн эрхийн дагуу цагдан хорих арга хэмжээ. Энэ нь үндсэн хугацааны хувьд 2 сар байх бөгөөд, дахин хоёр удаа 30 хоногоор сунгаж болохоос гадна онц хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, сар хүртэл хугацаагаар сунгана.

¹²⁹ Зууннасан Э. Монгол улс, Бүгд найрамдах хятад ард улсын Эрүүгийн шүүн таслах ажиллагааны харьцуулсан судалгаа /докторын диссертаци/. УБ. 2010. 88 дахь тал.

¹³⁰ Criminal procedure A worldwide study. Ed. C.M. Bradley.CA., 2007.p 100.

ЭБШХ-ийн 58 дугаар зүйлд зааснаар ердийн журмаар цагдан хорих арга хэмжээний дээд хугацаа 12 сараас хэтэрч болохгүй. Энэхүү арга хэмжээ нь шүүхийн хяналт зөвшөөрлийн дагуу хэрэгжинэ. Ингэхдээ шийдвэрлэх эрхтэй байна.

4. ТСАХ-ний хүрээнд баривчлах, цагдан хорихоос гадна албадан ирүүлэх, эд хөрөнгө барьцаалах, батлан даалтад гаргах зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд, энэ бүхэн нь прокурорын зөвшөөрөлтэйгөөр хийгддэг. Сүүлийн жилүүдэд БНХАУ-д онц хүнд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийг цагдан хорих тохиолдол тогтвортой буурахгүй байгаагийн дээр энэ талаар НҮБ-ын Хүний эрхийн хороо болон Эрүү шүүлтийн эсрэг хорооноос удаа дараа зөвлөмж, шаардлага хүргүүлсээр иржээ¹³¹.

Үүнээс үзэхэд, шүүхийн өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих, түүнчлэн байцаалт авах, нэгжлэг хийх зэрэг хойшлуулшгүй болон албадлагын арга хэмжээг хэрэглэх явцад НҮБ-ын олон улсын гэрээ, конвенцод заасан хүний эрхийн дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл ихээр гардаг гэж дүгнэхээр байна. Цагдаа нь өөрийн эрх хэмжээний хүрээнд хүнийг 24 цаг хүртэл саатуулж, шаардлагатай тохиолдолд, 3-30 хоног хүртэл сунгаж, мөрдөн мөшгөх ажиллагааг бие даан явуулж, цагдан хорьж байгаа явдал нь хүний эрх, эрх чөлөөг цагдан хорих замаар хязгаарлахдаа хөндлөнгийн ямар нэгэн байгууллагын хараа хяналтгүй, шүүх байгууллагын албан ёсны захирамж шийдвэргүй явагддаг байдал нь хүний эрхийг ноцтой зөрчдөг байж болзошгүй гэх хардлага төрүүлэхүйц байна.

Дүгнэлт

1. ОХУ-ын ЭПХ-д заасан ТСАХ-г хэрэглэх хүрээг хумьж, онц хүнд болон хүнд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчийн хувийн байдал, хэргийн онцлог болон ЭБША-нд илэрхий саад хийсэн буюу нотлох баримтыг устгасан тохиолдолд авч хэрэглэх шинэ журмыг тогтоосон нь өмнөх үеийн тогтолцоотой адил албадлагын үүрэг хэрэгжүүлэхээс аль болох зайлсхийж, зөвхөн онц хүнд болон хүнд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчид онцгой тохиолдолд буюу зөвхөн хуульд заасан нөхцөл байдал илэрч, нотлогдсон үед авч хэрэгжүүлж байгаа байдлаараа илүү дэвшилттэй байна.

2. Монгол Улсын ЭХХШТХ-д заасан ТСАХ-тэй харьцуулахад, ОХУ-ын ЭПХ-д заасан ТСАХ-ний тоо, хүртээмж харьцангуй их байна. Өөрөөр хэлбэл, цагдан хорих ТСАХ авахаас аль болох зайлсхийх зорилгоор, хянан харгалзах чиглэлийг баримталж байгаа төдийгүй, цагдан хорихтой зарим нэг шинжээрээ төстэй боловч, харьцангуй хөнгөн (гэрийн хорио, насанд хүрээгүй яллагдагчийг хянан харгалзах г.м) хэлбэрийн ТСАХ-г үр ашигтай хэрэглэхээр заасан нь дэвшилттэй байна. Үүнээс гадна, цагдан хорих ТСАХ авах зайлшгүй нөхцөл байдал буюу “Илүү хөнгөн хэлбэрийн ТСАХ авах боломжгүй тохиолдолд” цагдан хорих ТСАХ-г хэрэглэж байгаа явдал нь цагдан хорихыг хамгийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг зорьж, үүнийг ЭПХ-даа хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай.

3. Хэдийгээр БНХАУ нь газар нутгийн байршлын хувьд Монгол Улстай хөрш зэргэлдээ орших боловч, энэ улсын талаарх судалгаа, шинжилгээний ажил маш бага ажээ. Тэр тусмаа, цагдан хорих ТСАХ-тэй холбоотой судалгааны ажил тун дутмаг байна.

4. БНХАУ-ын ЭПХ-д заасан цагдан хорих ТСАХ нь бусад орнуудын нэгэн адил хамгийн хүнд хэлбэрийн ТСАХ юм. Харамсалтай нь энэ хүнд хэлбэрийн ТСАХ-г авахад шүүхийн хяналт тогтоодоггүй байдал нь сэжигтэн, яллагдагчийг үндэслэлгүйгээр цагдан хорих боломж нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хүний эрхийг хангах чиглэлээр ардчилсан орнуудаас хоцорч яваа гэж дүгнэхээр байна. БНХАУ-ын судлаач Юань И докторын диссертацидаа “Сэжигтэн, яллагдагчид цагдан хорих ТСАХ-г зөвхөн Ардын шүүхийн захирамжаар Нийгмийг аюулаас хамгаалах байгууллага авна”¹³² гэж

¹³¹ НҮБ-ын ажлын хэсгийн дүгнэлт №15 /2011.03.02. 20 дахь хэсэг/, англи хэл дээр.

¹³² Юань И. Меры процессуального принуждения по УПК КНР. Хууль зүйн докторын (Ph.D) диссертацийн хураангуй. URL: <http://lawtheses.com/mery-protsessualnogo-prinuzhdeniya-po-upk-krn>.

өөрчлөлт оруулах санал гаргасан нь цагдан хорих ТСАХ шүүхийн хяналтаас гадуур явагдаж буйг илтгэж байна.

5. Үйлдэл дээрээ баригдсан, ил тодорхой мэдээллээр шалгагдаж, нотлогдсон этгээдийг цагдаагийн албан хаагч өөрийн эрх хэмжээнд 24 цаг хүртэл саатуулж, шаардлагатай бол 3-30 хоног хүртэл сунгаж, МША-г бие даан явуулан, 3-30 хоног албадан саатуулах замаар түр цагдан хорих эрхтэй байгаа явдал нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлаж, хэргийг түргэн хугацаанд шийдвэрлэх зорилго агуулж байгаа ч, нөгөө талаас ямар нэгэн үндэслэл, журам, шүүгчийн захирамжгүйгээр бусдыг удаан хугацаагаар цагдан хорьж байгаа явдал бөгөөд, энэ нь хүний эрхийг ноцтой зөрчихийн эхлэл болно гэж үзэхээр байна. Монгол Улсын ЭХХШТХ-ийн үзэл баримтлал нь хүний эрхийг аль болох зөрчихгүй байхад чиглэдэг бөгөөд, БНХАУ-ын процессын хуулийн баримталж буй зарчимтай харшилдах шинжтэй болох нь харагдаж байна.

Санал

Цагдан хорих ТСАХ нь хүний эрхийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл хязгаарлаж, түүний цаашдын байдал, амьдралын хэв маяг болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээний үр дагавартай байдлыг харгалзан үзэж, ОХУ-ын хууль тогтоогчид ЭПХ-ийн 108 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...өөр бусад, хавьгүй хөнгөн төрлийн ТСАХ-г хэрэглэх боломжгүй тохиолдолд..." гэж цагдан хорихыг хамгийн эцсийн арга хэмжээ болгон тогтоосон нь сайшаалтай бөгөөд, манай орны ЭХХШТХ-д "цагдан хорих ТСАХ-г эцсийн арга хэмжээ болгон хэрэглэнэ" гэх заалтыг оруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Зууннасан Э. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн шүүн таслах ажиллагааны харьцуулсан судалгаа /докторын диссертаци/. УБ. 2010.
2. Эрхэсхулан Ж. Монголын эрүүгийн процессын тогтолцооны онцлог, сорилт, бэрхшээл //Монгол Улсын процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудал. эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2023.
3. Баярсайхан Д. Гадаад орнуудын эрүүгийн процесс. Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль. УБ. 2015.
4. Амаржаргал Г. Эрүүгийн процессын албадлага. Гарын авлага. Эрүүгийн процессын албадлагын ойлголт, түүнийг хэрэглэх үндэслэл, журам. УБ. 2013.
5. Бат-Эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги. УБ. 2004.
6. Баярсайхан Б., Батбаяр Б., Лхагважав Б. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт). УБ. 2010.
7. Баярсайхан Б., Дашням Ч. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ. 2012.
8. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" дүгнэлт. №10. УБ.
9. Нарангэрэл С. Эрх зүйн их толь бичиг. 2 дахь хэвлэл. УБ. 2008.
10. Өнөөдөр сонин. 2003.03.06. №052.
11. Совд Г. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ. 1999.
12. Хууль зүйн яам. Монгол Улсын Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбарууд. УБ. 1995.
13. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл. УБ. 2002.
14. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ. 2023.

- 15.Цогтсайхан Д. Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ. Шүүх эрх мэдэл 1. 2014.
- 16.Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 2021.
- 17.Ширэндэв Д. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Магистрын дипломын ажил. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.
- 18.Ансель М. Методологические проблемы сравнительного права // Очерки сравнительного права : сб. М., 1981.
- 19.Гашимов Р.Р. Проблемные вопросы применения меры пресечения в виде заключения под стражу // Образование и право. 2019. №10.
- 20.Бойков А.Д. Новый УПК Российской Федерации, его правовая и криминологическая характеристика // Научно-практическая конференция «Правовая и криминологическая оценка нового УПК РФ» // Государство и право. 2002. №9.

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН ХӨГЖИЛ

MEASURES TO AVOID POLICE IMPRISONMENT HISTORICAL DEVELOPMENT IN CONCEPTION AND LEGISLATION

Б.Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Монгол Улсын үе үеийн эрүүгийн байцаан шийтгэх хуульд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар тусгаж ирсэн түүхэн хөгжлийг судалж, онцлогийг тодорхойлохыг зорилгоо.

Abstract: It is intended to determine the historical development, types, experience of foreign countries and future trends of Detention Preventive Measures in force in Mongolia.

Түлхүүр үгс: Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хорих хугацаа, сэжигтэн, яллагдагч.

Keywords: Detention, restraining order, detention period, suspect, accused.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ”¹³³ гэж заасан. Тэгэхээр, халдашгүй чөлөөтэй байх эрх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан, ямар ч албан тушаалтан, эрх ямбатан дур мэдэж, хувийн эрх ашгийн төлөө халдаж үл болох шинжээрээ туйлын эрхтэй ижил хэмжээнд авч үзэхүйц чухал зүйл юм. Төрөөс хүний Үндсэн хуульд заасан эрхийг хуулийн дагуу хумьж, дур зоргоороо, чөлөөтэй зорчих болон бусадтай харилцах эрх, эрх чөлөөг нь бүр мөсөн хязгаарлаж, тодорхой үндэслэл, журмын дагуу тусгай байгууллагад хугацаатай хорьдог, албадлагын шинжтэй арга хэмжээ бий. Үүнийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ (Цаашид – ТСАХ гэх) гэх бөгөөд, хүнийг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоох зорилготой мөрдөн шалгах ажиллагаа (Цаашид – МША гэх)-ны явцад, яллагдагчид хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэдэг, ТСАХ-ний хамгийн хүнд хэлбэр юм.

“Цагдан хорих” гэх ойлголтыг тодорхойлохын тулд түүний мөн чанар, ач холбогдол болон зорилгын талаар судлах нь зүйтэй. Цагдан хорихын мөн чанар нь яллагдагчийн гэм бурууг шүүхээс тогтоож, шийтгэх тогтоол гаргах хүртэл түүнийг тусгай байгууллагад хорих замаар, нийгмээс тодорхой хугацаанд тусгаарлахад чиглэгддэг. Цагдан хорихын ач холбогдол нь МША хэвийн явагдах, шүүхийн тогтоол гаргах болон түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах байдлаар илэрнэ. Харин цагдан хорихын зорилго нь Эрүүгийн хуульд заасан ялын төрөл болох хорих ялын зорилготой ижил юм. Тодруулбал, өргөн утгаараа, байцаан шийтгэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд цагдан хорихын зорилго оршино. Хорих ялын тухайд бол “манай түүхэнд ч тэр, XIX зууныг хүртэл Европ болон Америкийн Нэгдсэн Улс (Цаашид – АНУ гэх)-д гэмт хэргийн шийтгэл болгож шоронг ашиглах нь нэн ховор байв. Ихэнх хотуудад ихэвчлэн жижиг, нэг дор хоёр, гурваас илүүгүй хүн хорих өөрийн шоронтой байсан. Эдгээрийг шөнө архи чдыг ухаан оруулах,

¹³³ Совд Г. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ. 1999. 51 дэх тал.

заримдаа ялтан шүүгдэхийг хүлээх хүртэл ашигладаг байжээ”¹³⁴ гэж судлаачид тэмдэглэсэн байна.

Судалж буй ТСАХ нь “цагдах” ба “хорих” гэсэн хоёр үгнээс бүтэж байна. Цагдах гэх үгийг Я.Цэвэлийн толь бичигт “манах, сэргийлэх, манаж цагдах, чандлан цагдах, хориглож цагдах”¹³⁵ гэж, харин “хорих” гэх үгийг “хориглох, зогсоох, болиулах, бурууг хорьж, бузрыг ариулах, хөл хорих, хааж хадгалах”¹³⁶ гэж тайлбарлажээ. Толь бичигт дурдсанаас дүгнэхэд, “цагдах” гэдэг нь аливаа үйл хийхээс сэргийлэх, хориглохоос гадна, тодорхой газарт харгалзаж, манах, харин “хорих” гэдэг нь албадан хязгаарлах утга агуулж байна. Өөрөөр хэлбэл, “цагдах” нь хориглон харгалзаж хязгаарлахыг, “хорих” нь үйл гүйцэлдүүлэхийг таслан зогсоох утгатай байна. Эндээс “цагдах” гэх үг нь “хорих” гэх үгийн утгыг өөртөө давхар агуулж байгаа болохыг мөн харж болохоор байна.

Цагдан хорих ТСАХ-г Академич С.Нарангэрэл “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа (Цаашид – ЭБША гэх)-нд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах ТСАХ-ний нэг”¹³⁷ хэмээн тайлбарласан бол доктор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”¹³⁸ гэж, Д.Цогтсайхан “...цагдан хорих арга хэмжээ гэдэг бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зугтаалгахгүй, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, ЭБША-г хуулийн дагуу явуулахад саад хийлгэхгүй, цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх бололцоо олгохгүй байх зорилгоор тэдний хувийн эрх, эрх чөлөөг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Цаашид – ЭБШХ гэх)-д тусгайлан тогтоосон албадлагын арга хэрэгсэл”¹³⁹ гэж, Д.Ширэндэв “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд, мөрдөгч, прокурорын санал болгосноор шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд, нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ юм”¹⁴⁰ гэж, Г.Амаржаргал “Хэргийн бодит байдлыг тал бүрээс нь, бүрэн бодитой тогтоох, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас оргон зугтаалгахгүй байх, ЭБША-г хуулийн дагуу явуулахад саад хийлгэхгүй, цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх бололцоо олгохгүй байх зорилгоор тэдний хууль бус үйлдэл, зан үйлтэй тэмцэхэд чиглэсэн хувийн эрх, эрх чөлөөг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах байдлаар хэрэгжүүлж байгаа хуулиар тусгайлан тогтоосон албадлагын арга хэрэгслийн цогц бүрдлийг ТСАХ гэнэ”¹⁴¹ гэж тус тус тодорхойлжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Цаашид – ЭХХШТХ гэх) “цагдан хорих” гэх нэр томъёог тайлбарлаагүйгээс үүдэлтэй, эрдэмтэн, судлаачдын шинж тэмдгээр нь сурвалжилж тайлбарлах явдал ихээр гарч байна.

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд шинэчлэн батлагдсанаас хойш эрүүгийн процессын шинжлэх ухааны албадлагын арга хэмжээний нэг төрөл болох цагдан хорих ТСАХ авах үндэслэл хүний эрх суурьтай буюу дэлхий нийтийн эрх зүйн соёл, чиг хандлага, Монгол Улсын Олон Улсын гэрээ, конвенцод нийцүүлэх, дэлхийн хөгжилтэй

¹³⁴ Баярсайхан Б., Батбаяр Б., Лхагважав Б. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт). УБ. 2010. 16 дахь тал.

¹³⁵ Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 2021. 1127 дахь тал.

¹³⁶ Мөн тэнд. 1006 дахь тал.

¹³⁷ Нарангэрэл С. Эрх зүйн их толь бичиг. 2 дахь хэвлэл. УБ. 2008. 552 дахь тал.

¹³⁸ Бат-Эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги. УБ. 2004. 265 дахь тал.

¹³⁹ Цогтсайхан Д. Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ. Шүүх эрх мэдэл 1. 2014. 40-45 дахь тал.

¹⁴⁰ Ширэндэв Д. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Магистрын дипломын ажил. 20 дахь тал.

¹⁴¹ Амаржаргал Г. Эрүүгийн процессын албадлага. Гарын авлага. Эрүүгийн процессын албадлагын ойлголт, түүнийг хэрэглэх үндэслэл, журам. УБ. 2013. 13 дахь тал.

орнуудын ололтыг нутагшуулах зэргээр шинэчилсэн агуулгаар баяжиж, боловсронгуй болж ирсэн. Гэхдээ энэ үйл явц тийм ч богино хугацаанд явагдаагүйн зэрэгцээ түүхийн олон мөчлөгийг давж, өнөөгийн түвшинд хүрчээ.

Цагдан хорих ТСАХ-тэй холбоотой түүхийн зарим эх сурвалжийг дурдвал, 1926 оны Монгол Улсын Шүүн таслах газраас баталсан “Аливаа хэргийг байцаах ба шийтгэх тухай хууль”-д уг арга хэмжээ анхлан тусгагджээ. 1935 онд батлагдсан Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 22 дугаар зүйлд дараах байдлаар заасан байна. Уг хуулийн 22 дугаар зүйлд:

Аливаа байцаагдан байгаа хүмүүсийг оргон зайлахгүй болгохын тулд хэрэглэх аргуудын тухай:

1. Хэрэгтэн хүмүүсээс мөрдөн байцаалтын газар хүрэлцэн ирэх буюу шүүх таслах газар биеэр хүрэлцэн ирэх ба хэрэв оршин суугаа газраасаа шилжвэл тэр тухайгаа мэдэгдэж байна гэж гарын үсэг зурсан хуудсыг гаргуулах;

2. Оршин суугаа орон нутгаасаа ахин гарахгүй гэж мөн гарын үсэг зурсан хуудсыг гаргуулах;

3. Бусад итгэмжтэй хүмүүс хоёроос доош бусаар буюу хөрөнгөөр даалгах;

4. Хөрөнгө хогшлыг барьцаалуулах;

5. Хорих.

Мөн тус хуулийн 23 дугаар зүйлд “Дээр дурдсан эдгээр аргуудын дотроос чухам ямар арга хэрэглэвэл зохихыг тухайн байцаагчаас тогтооход хэрэг дутам түүний хүнд, хөнгөн ба хэрэгтэн хүний урьд, одоогийн зан байдал хийгээд, уул хэргийн байдал нь ард олонд ямар холбогдолтой болох, үйлдсэн гэмт хэргийн баримт юу болох, хэргийн үнэн магадыг илрүүлэхэд саад боогдол гарах эсэхийг, байцаагдах явдлаас зайлсхийх зэргийг тус тус хянан үзэж, шийдвэрлэн тогтоовол зохино” гэж заасан бөгөөд, тайлбар хэсэгт “Хорих аргыг хэрэглэхдээ гагцхүү уул хүнийг сул байлгавал хэргийг байцаан, үнэн магадыг илрүүлэхэд саад, тогтор гарах буюу оргон зайлахыг сэрэмжлэх, эсхүл ард олонд онц аюултай болбол шууд барьж, хорьж болно”¹⁴² гэж цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг нэг өгүүлбэрт багтаан тайлбарласан байна. Эндээс үзэхэд, аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль нь хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болзошгүй, оргон зайлж болзошгүй, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн гэх үндэслэлийг тогтоож, зөвхөн эдгээр үндэслэлээр хүнийг цагдан хорьдог байсан бөгөөд, цагдан хорих ТСАХ-г эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг зорьсон зүйл, заалт байгааг тодотгох нь зүйтэй. Тодруулбал, ТСАХ-г сонгон хэрэглэхдээ тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнийг харгалзахаас гадна хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үздэг байжээ.

1949 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ЭБШХ-ийн 187 дугаар зүйлд “Цагдан хорих явдлыг ТСАХ болгох нь гагцхүү шүүхээс 1 жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял ногдох гэмт хэргийн талаар гүйцэтгэгдэж болох бөгөөд, түүнд яллагдагч этгээд нь мөрдөн байцаалт ба шүүхээс нуугдан зайлах буюу, эсхүл түүний биеийг сул байлгавал үнэнийг илрүүлэхэд саад болох буюу нийгэмд аюултай гэж үзэх гүйцэт үндэс бүхий байх тухайд тийнхүү цагдан хорих арга хэмжээ авна”¹⁴³ гэж тусгажээ. Тодруулбал, яллагдагч мөрдөн байцаалтын болон шүүхийн шатнаас оргон зайлж болзошгүй, яллагдагч нь хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулж болзошгүй, эсхүл тухайн этгээд нийгэмд аюултай байж болзошгүй үндэслэлүүд тогтоогдвол, яллагдагчийг цагдан хорихоор байна. Тэгэхээр 1 жилээс дээш хугацаагаар хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон, яллагдагчийн статустай хүнд цагдан хорих ТСАХ авах боломж нээгддэг байна. Өөрөөр хэлбэл, аливаа хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх сэжиглэлээр шалгах үедээ (сэжигтэнд) цагдан хорих ТСАХ авдаггүй байснаас гадна ялын бодлоготой уялдуулдаг (1 жилээс

¹⁴² Баярсайхан Б., Дашням Ч. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ. 2012. 114 дэх тал.

¹⁴³ Мөн тэнд. 153 дахь тал.

доош хугацаанд хорих ял онохоор заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд цагдан хорих ТСАХ авдаггүй) байсан нь харагдаж байна. Эдгээр үндэслэл нь 1935 оны “Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай” хуульд заасантай зарим байдлаараа ижил боловч, (1 жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял ногдох гэмт хэрэгт) гэмт хэргийн ялын хүнд, хөнгөнөөс хамаарч цагдан хорих ТСАХ авах заалтыг илүү тодорхой тусгаснаас гадна, цагдан хорихдоо, гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг харгалзан үзсэн байдлаараа ялгаатай.

Тэгвэл 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ЭБШХ-д цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг ерөнхий байдлаар тусгасан. Энэ хуулийн 94 дүгээр зүйлд “Цагдан хорих явдлыг ТСАХ болгож, хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэргүүд, түүнчлэн аюултай буюу онц аюултай гэмт хэргүүдэд гагцхүү хэргийн аюултай байдлыг харгалзан, энэ хуулийн 12 дугаар зүйлийн шаардлагын дагуу хэрэглэж болно”¹⁴⁴ гэж заажээ. Өөрөөр хэлбэл, хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэргүүд болон аюултай ба онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хорих бөгөөд, бусад этгээдэд уг ТСАХ-ээс бусад (оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах; хүмүүс буюу олон нийтийн байгууллагын даалтад өгөх гэх мэт) арга хэмжээний аль нэгийг сонгон хэрэглэх боломжийг олгожээ.

1963 оны ЭБШХ-иар байцаан шийтгэх ажиллагаа нь хэв маягын хувьд мөрдөн шүүх буюу мөрдөн шалгах шинжтэй байхаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд, 2002 оны ЭБШХ нь дээрх хэв маягийн шинжтэй ЭБША Монгол Улсад явагдахыг хуульчилж өгсөн. Тухайлбал, уг хуулийн 6 дугаар зүйлд ЭБША-ны зорилтыг тодорхойлохдоо “...аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, явдлыг хангахад оршино”¹⁴⁵ гэжээ.

1963 оны ЭБШХ-ийн 94 дүгээр зүйл (Цагдан хорих)-д “Онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл удаа дараа ял шийтгэгдэж байсан буюу онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн мөрдөн байцаалтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох хангалттай үндэслэл байвал уг этгээдэд цагдан хорих ТСАХ-г энэ хуулийн 12 дугаар зүйлийн шаардлагын дагуу хэрэглэж болно.

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлийн аль нэг нь байвал жирэмсэн эмэгтэйчүүдийг эмнэлгийн байгууллагын хяналтан дор цагдан хорьж болно.

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн буюу хүнд өвчтэй этгээд, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих ТСАХ-г хэрэглэхийг хориглоно”¹⁴⁶ гэж заасан.

1963 оны ЭБШХ-д зааснаар, цагдан хорих нь ТСАХ-ний дотроос хамгийн хүнд нь бөгөөд, хоригдож буй этгээдийн эрх зүйн байдлаас хамааруулж, сэжигтнээр цагдан хорих, яллагдагчаар цагдан хорих гэж хоёр ангилж байжээ. Энэ хуулийн 88 дугаар зүйлд зааснаар, онцгой тохиолдолд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдэд ял сонсгохын өмнө ТСАХ авч болох ба уг арга хэмжээг авснаас хойш 14 хоногийн дотор ял сонсгох, хэрэв ял сонсгоогүй бол уул арга хэмжээгээ хүчингүй болгох ёстой. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын практикаас үзэхэд, цагдаагийн ажилтнууд болон прокурорууд нэгдүгээрт, энэхүү 88 дугаар зүйлийн “онцгой тохиолдол” гэдгийг онцлон анхаарч үздэггүй, хоёрдугаарт, таслан сэргийлэх өөр арга хэмжээг хэрэглэх боломжтой байхад зөвхөн цагдан хорихыг урьтал болгодог байна. Үүний үр дүнд хүний эрх зөрчигдөх явдал түгээмэл гарах сөрөг талтай байдаг. Энэ талаар Хүний эрхийн үндэсний комисс (Цаашид – ХЭҮК гэх)-оос жил бүрийн тайландаа тусгаж, анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудын тэргүүн эгнээнд тооцсоор өдийг хүрчээ.

¹⁴⁴ Мөн тэнд. 219 дэх тал.

¹⁴⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” дүгнэлт. №10. УБ.

¹⁴⁶ Хууль зүйн яам. Монгол Улсын Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбарууд. УБ. 1995. 160 дахь тал.

Жишээлбэл, 2002 онд ХЭҮК-оос “Тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шалгаагүй, ер нь хэрэг гарсан эсэх, хэрэв гарсан бол уг хэрэгт энэ хүн холбоотой эсэх, ямар зүйл ангиар буруутгагдах эсэх нь тодорхойгүй байхад сэжигтнээр тооцож, улмаар цагдан хорих гэж улайран хөөцөлдөж, хорьж буй нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (Цаашид – ИБҮТЭТОУП гэх)-ын 9 дүгээр зүйлийн “Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д заасан “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч баривчлах, хорихыг хориглоно” гэсэн заалтуудтай шууд зөрчилдөж байна”¹⁴⁷ гэсэн дүгнэлт гаргасан байдаг.

Анхаарал татах өөр нэг онцгой асуудал бол цагдан хорих үндэслэл юм. 1963 оны ЭБШХ-д заасан цагдан хорих үндэслэлүүд нь хэт өргөн, яаж ч тайлбарлаж, хэрэглэж болохоор, хэнийг ч, хэзээ ч хорьж, эрх чөлөөг нь хязгаарлаж болохоор, дур зоргын хэрэгсэл болгох өргөн боломжтой байдлаар тусгагдсан гэхэд болно. Тодруулбал, энэ хуулийн 94 дүгээр зүйлд “Онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл удаа дараа ял шийтгэгдэж байсан буюу онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн мөрдөн байцаалтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох үндэслэл байна гэж үзвэл цагдан хорьж болно”¹⁴⁸ гэж заасан байна. ХЭҮК-ын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай (2002)” илтгэлд “Хүчин төгөлдөр Эрүүгийн хууль (1993) нь нийтдээ 301 зүйлтэй бөгөөд 446 үйлдэлд ял халдааж болохоор байгаагийн 34 нь онц хүнд, 124 нь хүнд гэмт хэрэгт, 153 нь хүндэвтэр, 135 нь хөнгөн гэмт хэрэгт хамрагдаж байна. Үүнээс үзэхэд, гэмт хэрэгт холбогдогчдын дийлэнхийг зөвхөн холбогдсон хэргийнх нь ангиллаар цагдан хорьж болохоор байна. Ер нь ч амьдрал дээр ингэж хорьдог. Онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах үйлдэл нь гэмт хэрэгт тооцогддог нийт үйлдлийн 70 орчим хувийг эзэлж байна. Түүгээр ч барахгүй, хөнгөн гэмт хэрэгт холбогдогчдийг “... дахин гэмт хэрэг үйлдэх буюу оргон зайлсхийж болох хангалттай үндэслэл байвал...” хүнд өвчтэй, хөхүүл, жирэмсэн байсан ч хорьж болохоор байна”¹⁴⁹ гэж шүүмжилсэн байна.

Тэгэхээр 1963 оны ЭБШХ-д заасан цагдан хорих үндэслэл нь хэт өргөн, хэт явцуугаас гадна хууль сахиулах байгууллагуудын (Цагдаагийн байгууллага, Прокурорын байгууллага, Шүүх байгууллага) ээлж дараалсан шүүлтүүрээр ордоггүй, эрх бүхий албан тушаалтнуудын үзэмжээр шийдэгдэх боломжтой, хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн шинжтэй хуульчлагдсан гэж дүгнэх үндэслэлтэй байна.

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн ЭБШХ-р баривчлах, цагдан хориход олгох зөвшөөрлийг зөвхөн шүүх гаргах болсон нь хүний эрхийг баталгаажуулахад чиглэсэн чухал алхам болсон. Бусдын эрх чөлөөнд халдах зөвшөөрлийг гэмт хэргийг илрүүлэх үүрэг хүлээсэн субъект (прокурор) захиргааны журмаар бус, харин шүүх яллагч болон өмгөөлөгч талын байр суурь, хэргийн талаарх зарим мэдээ, баримтыг харьцуулан авч үзэж, ямар нэг хэмжээгээр мэтгэлцээний үр дүнг харгалзан олгох болсон байна. Үүний үр дүнд 2003 оны эхний улиралд хоригдсон хүний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад албадан саатуулагдаж байсан хүн 81.2 хувиар, сэжигтнээр хоригдогсод 27.4 хувиар, яллагдагчаар цагдан хоригдогсод 26.3 хувиар тус тус цөөрсөн тухай Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөний илтгэлд дурджээ¹⁵⁰.

Уг хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан

¹⁴⁷ Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл. УБ. 2002. 13 дахь тал.

¹⁴⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ. 1963. 94 дүгээр зүйл.

¹⁴⁹ Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл. УБ. 2002. 15 дахь тал.

¹⁵⁰ Өнөөдөр сонин. 2003.03.06. №052.

хорьж болно”¹⁵¹ хэмээн нийтлэг үндэслэлийг тусгасан. Мөн энэ хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “өмнө нь авсан ТСАХ-г зөрчсөн; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн” гэх үндэслэлээр цагдан хорих ТСАХ авахаар заасан байна. Энэ мэтээр, өмнөх ЭБШХ-иудад яллагдагчийн үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс хамаарч цагдан хорих ТСАХ авдаг байсан жишиг 2002 оны ЭБШХ-иас ч арилаагүй юм¹⁵². Хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорих ТСАХ авах боломж олгосон нь хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг баттай нотлоогүй, бүрэн тогтоогоогүй атлаа цагдан хорьж, эрх, эрх чөлөөг нь хязгаарлах боломж бүрдүүлснээрээ учир дутагдалтай юм. Уг нийтлэг үндэслэлээр гэмт хэрэгт бусдыг сэжиглэж, өөрөөр хэлбэл, үндэслэлгүйгээр цагдан хорих явдлыг дэмжих шинжтэй заалт болсон гэхэд болно. Үе үеийн ЭБШХ-дад заасан цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд нь өөр өөрийн онцлогтой байдлаар хуульчлагдсан мэт боловч, залгамж чанартай байх бөгөөд, гэмт этгээдийн үйлдсэн хэргийн бодит байдлыг тал бүрээс нь тогтоох, мөрдөн шалгах (байцаан шийтгэх) ажиллагааг хэвийн явуулахад учирч болзошгүй бэрхшээлээс урьдчилан сэргийлэх шинжийг агуулж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих хэмжээний үндэслэлүүд хэрэгжиж байсан явдал нь сэжигтэн, яллагдагчийн эрх, эрх чөлөөг хангахаасаа илүүтэйгээр, ЭБШХ-ийн зорилтыг хангахад түлхүү чиглэгдэж байжээ гэж дүгнэхэд хүргэх бөгөөд, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нотолж байгаад хорих бус, нотлохын тулд хорьдог, эрүүдэн шүүх хэлбэрийг ханхалуулсан тогтолцоо зонхилох үндэс болжээ. Тиймээс цаашид иргэдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, энэ төрлийн харилцааг хууль тогтоомжийн хүрээнд, нарийвчлан зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Манай улс 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн, ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд анхаарал хандуулахыг зорьж, Эрүүгийн хууль болон ЭБШХ-ийн зарчимд хүний эрхийг хамгаалах чиглэлийн үзэл баримтлалыг ихээр шингээж, бүтэц, тогтолцоонд аажмаар өөрчлөлт оруулсан бөгөөд хүний эрхийн олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орж, соёрхон батлах, тэдгээрт өөрийн улсын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг хурдацтай явуулах болсон. Үүний үр дүнд 2015 онд шинэ ЭХХШТХ баталж, мөрдөөд багагүй хугацаа өнгөрөөд байна. Тус хуульд цагдан хорих ТСАХ-ний талаар 2002 оны ЭБШХ-тай харьцуулахад, хүний эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтууд шинээр туссан. Тухайлбал, цагдан хорих үндэслэлийг нарийвчлан тогтоосон, яллагдагчийг цагдан хорих нийт хугацааг 18 сар болгож багасгасан, цагдан хорих ТСАХ авах, өөрчлөх, хугацаа сунгах асуудлыг шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэх, өмгөөлөгчийн оролцоог хангаж мэтгэлцэх зарчмыг бэхжүүлсэн, уг арга хэмжээг эцсийн арга хэмжээ болгож хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн зэргийг дурдаж болно¹⁵³. Мөн өмнөх ЭБШХ-иудад байсан, сэжигтнийг цагдан хорих явдлыг үгүй хийж, зөвхөн яллагдагчид цагдан хорих ТСАХ авах болсон явдал нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн чухал алхам болсон юм. Сайны хажуугаар саар гэгчээр, хэрэгжиж буй ЭХХШТХ-д сайшаалтай боловч шүүмжлэлтэй хандахаар зүйлс багагүй байна.

Дүгнэлт

1. Цагдан хорих ТСАХ гэдэг нь гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд, яллагдагч (шүүгдэгч) нь гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоож, ЭХХША-г хуулийн дагуу явуулах, мөрдөн байцаалт болон шүүхээс оргон зугтаалгахгүй байх,

¹⁵¹ Эрүүгийн байцаан шийтгэх хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. <https://legalinfo.mn/mn/detail/59>-аас үзэв.

¹⁵² 2002 оны Эрүүгийн хуулийн 17.2, 17.3, 17.4, 17.5 дугаар зүйлд тус тус гэмт хэргийн ангилал бүрийн оногдуулах ялын хэмжээг тусгасан. Гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилах гол шалгуур нь оногдуулах ялын хэмжээ юм.

¹⁵³ Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ. 2023. 37 дахь тал.

цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх боломж олгохгүй байх, ЭХХША-нд оролцогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор, мөрдөгч, прокурорын үндэслэл бүхий саналыг харгалзан, шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд, тусгай байгууллагад нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан хувийн эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ юм.

2. 1935 оны “Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль”-д цагдан хорих ТСАХ-г сонгон авч, хэрэглэхийн өмнө үүнийг эцсийн арга хэмжээ болгож хэрэглэхийг зорьсон үзэл санаа ажиглагдаж байна. Тодруулбал, ТСАХ-ний төрлүүдийг сонгохдоо тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, хувийн байдал, нийгмийн аюулын шинж (уул хэргийн байдал нь ард олонд ямар холбогдолтой болох), нотлох баримт зэргийг харгалзахаас гадна хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах болон МША-аас зайлсхийх боломжит нөхцөлийг урьдчилан судалж, олон талаас нь хянан, магадалсны үндсэн дээр, ямар төрлийн ТСАХ-г сонгохыг шийдвэрлэдэг байжээ.

3. 1963 оны ЭБШХ-д заасан цагдан хорих ТСАХ-г хэрэглэх үндэслэл, журамд заасан, анхаарвал зохих хэд хэдэн зүйл, заалт нь хүний эрхийг ноцтой зөрчих шинжтэй байдлаар хуульчлагдсан байжээ. Тодруулбал, тухайн хэрэгт нотолбол зохих ажиллагааг бүрэн дүүрэн хийгээгүй, тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн болохыг хангалттай нотлоогүй атлаа шууд цагдан хорихоор улайран зүтгэх, цагдан хорих ТСАХ авах үндэслэлүүд нь ч нийтлэг, ерөнхий шинжтэй байсан нь хэнийг ч, хэзээ ч, яаж ч цагдан хорих боломжтой байсныг ХЭҮК-оос 2002 оны тайландаа шүүмжилсэн нь цагдан хорих ТСАХ авах үндэслэлийг эргэн харж, өөрчлөлт оруулах цаг болсныг сануулах мэт болжээ.

4. 2002 оны ЭБШХ-иар баривчлах, цагдан хориход олгох зөвшөөрлийг зөвхөн шүүх гаргах болсон нь хүний эрхийг хамгаалахад чиглэсэн нэн чухал алхам болсон бөгөөд, өнөөгийн хууль тогтоомжийн механизм энэ чиглэлээр ажиллаж байна. Шүүхийн шийдвэрээр цагдан хорих ТСАХ авдаг болсон нь сайшаалтай боловч, өмнөх хуулиудад байсан мөрдөн шалгах (байцаан шийтгэх) ажиллагааг хэвийн явуулахад учирч болзошгүй бэрхшээлээс урьдчилан сэргийлэх шинжийг агуулж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих хэмжээний үндэслэлүүд хэрэгжиж байсан явдал нь сэжигтэн, яллагдагчийн эрх, эрх чөлөөг хангахаасаа илүүтэйгээр, ЭБШХ-ийн зорилтыг хангахад түлхүү чиглэгдэж байсныг харуулж байна.

Ашигласан материал

1. Амаржаргал Г. Эрүүгийн процессын албадлага. Гарын авлага. Эрүүгийн процессын албадлагын ойлголт, түүнийг хэрэглэх үндэслэл, журам. УБ. 2013.

2. Бат-Эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги. УБ. 2004.

3. Баярсайхан Б., Батбаяр Б., Лхагважав Б. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн дүн шинжилгээ (Улаан хацарт). УБ. 2010.

4. Баярсайхан Б., Дашням Ч. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ. 2012.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” дүгнэлт. №10. УБ.

6. Нарангэрэл С. Эрх зүйн их толь бичиг. 2 дахь хэвлэл. УБ. 2008.

7. Өнөөдөр сонин. 2003.03.06. №052.

8. Совд Г. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ. 1999.

9. Хууль зүйн яам. Монгол Улсын Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбарууд. УБ. 1995.

10. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл. УБ. 2002.

11. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. УБ. 2023.
12. Цогтсайхан Д. Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ. Шүүх эрх мэдэл 1. 2014.
13. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 2021.
14. Ширэндэв Д. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Магистрын дипломын ажил.
15. Эрүүгийн байцаан шийтгэх хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. <https://legalinfo.mn/mn/detail/59-аас> үзэв.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ХАНГАХАД АНХААРАХ АСУУДАЛ

ISSUES TO BE CONSIDERED IN ENSURING PRISONERS' RIGHT TO EMPLOYMENT

*Л.Даваасүрэн
ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч*

Товч агуулга: Хорих ял эдлэгсдийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, хөдөлмөр зохион байгуулалтын эрх зүйн орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд гарч буй эрсдэлийг судлаж шалтгаан нөхцөлийг тодорхойлон сайжруулах, боловсронгуй болгох арга замыгэрэлхийлэхэд оршино.

Abstract: It is to study the risks arising in the implementation of the right to work, the legal environment of labor organization, safety and hygiene activities, and to identify the causes and seek ways to improve and refine them.

Түлхүүр үгс: Хүний эрх, хөдөлмөрлөх эрх, хорих байгууллага, хоригдол, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт, бүтэц, зохион байгуулалт, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн эрүүл ахуй.

Keywords: Human rights, labor rights, prisons, prisoners, labor safety, employment, structure, organization, safety, industrial accidents, occupational hygiene.

Хоригдлын хөдөлмөрийг зөвхөн төрөөс баталсан хуульд заасан чиглэл, нөхцөлд захируулан зохион байгуулах явдал Засан хүмүүжүүлэх байгууллагын нэг чухал үүрэг байлаа. Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хуульд (1931он) “Хоригдогсдын дотроос ажил үйлдвэрийг хийж чадахыг нь эрх биш бүгдийг нь ажилд хэрэглэх бөгөөд уул хоригдогсдоос хэн аль нь ямар ажилд авьяастай, мэдэх чадах нь юу болох, тэдгээрээс урьд хийж байсан ажил ба биеийн эрүүл мэнд ямар болохыг хянан үзэж харгалзан гүйцэтгэвээс зохимой” хэмээн заажээ. Харин 1966, 1993 оны хуулиудад хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх, 1981 оны хуульд хоригдол заавал хөдөлмөрлөх, 1966, 2002 оны хуульд ял эдлүүлэх байгууллага хоригдлыг хөдөлмөрөөр хангах үүрэгтэйг онцлон заасан байна.

Хорих ял эдлүүлэх байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, хоригдлыг ажлаар хангахад төрөөс зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргасан баримт бичгийн агуулгаас тодорхой харагдаж байна. Эдгээрийн дотор түүхэн томоохон байр суурь эзлэх шийдвэр бол 1929 оны 6 дугаар сарын 14-нд Засгийн газрын есдүгээр хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар батлагдсан “Аливаа хэрэгтэн, ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм”¹⁵⁴ юм.

Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэл нь 1950-иад оны эхэн үе хүртэл гар урлал, мал аж ахуй, газар тариалан эрхлэх, барилга барих, барилгын модон материал бэлдэх, тоосго үйлдвэрлэх зэрэг чиглэлээр хөгжиж ирсэн байна. Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх, гар ажиллагааг механикжуулах, хоригдолд хөдөлмөрийн дадал олгох, мэргэжил эзэмшүүлэх ажил 1960-аад оноос нилээд эрчимжсэний нэг жишээ бол БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс

¹⁵⁴ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл, 1930, №49, 53-63 дахь тал.

1960 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс “Засан хүмүүжүүлэхбайгууллагын үйлдвэрлэлийн чиглэлийн тухай” 86 дугаар тогтоол гарсан явдал юм.

Сайд нарын зөвлөлөөс 1967 оны 4 дүгээр сарын 12-нд “Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлын талаар авах арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол гаргаж засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэлийг

1. Уул уурхай;
2. Шохойн чулуу олборлох, боловсруулах;
3. Тоосго;
4. Мод бэлтгэлийн аж ахуй;
5. Модны үйлдвэр;
6. Зоорийн барилга гэсэн чиглэлүүдээр хөгжүүлбэл зохихыг заажээ.

Улсын болон ард олны захиалга, хэрэгцээг харгалзан засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэл, хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтын чиглэл баяжин өөрчлөгдөж ирсэн байна. Хорих анги байгууллагуудын үйлдвэрлэл эрхэлж буй чиглэлийг хүснэгтээр оруулав.


Хүснэгт 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорих ангиудын, үйлдвэрлэл эрхэлж буй чиглэл

№	Нээлттэй, хаалттай хорих ангийн нэр, нутаг дэвсгэрийн байршил	Хорих ял эдлүүлэх дэглэм	Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл
1	407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Нээлттэй, хаалттай	Төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл, эсгий болон гар урлал
2	Улаанбаатар хотын Баянзүрэх дүүрэгт байрлах 409 дүгээр хаалттай хорих анги	Хаалттай	Гутлын болон оёдлын үйлдвэрлэл, ноолууран эдлэлийн оёдол, гар урлал
3	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа дахь 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Хаалттай	Төмс, хүнсний ногоо, тариалалт, мод бэлтгэл болон боловсруулах үйлдвэрлэл, мужаан сийлбэр, суран эдлэл үйлдвэрлэл
4	Төв аймгийн Баян суманд байрлах Мааньт дахь 415 дугаар хаалттай хорих анги	Хаалттай	Шохойн чулуу олборлолт, шохой үйлдвэрлэх, оёдол, чулуун гар урлал, сийлбэр
5	Төв аймгийн Мөнгөнморьт суманд байрлах 417 дугаар нээлттэй хорих анги	Нээлттэй	Ойжуулалт, мод үржүүлэг, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэл, гар урлал,
6	Хэнтий аймгийн Чингис хотод байрлах 419 дүгээр нээлттэй хорих анги	Нээлттэй	Барилгын тоосго, блок, явган хүний зиг заг үйлдвэрлэл
7	Амгалан дахь 421 дүгээр нээлттэй хорих анги	Нээлттэй	Гэрээт хэсэг буюу төмрийн үйлдвэр
8	Өвөрхангай аймгийн Хархорин суманд байрлах 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Нээлттэй, хаалттай	Үр тарианы үйлдвэрлэл, мод бэлтгэл, гар урлал, мужаан сийлбэр
9	Говьсүмбэр аймгийн Чойрт байрлах 425 дугаар нээлттэй хорих анги	Нээлттэй	Эсгий, эсгий гутал, ясны гурилын үйлдвэрлэл, гар урлал
10	Төв аймгийн Баяндэлгэр сум, Улаанбаатарын Багануур дахь	Хаалттай	Төмс, хүнсний ногоо тариалалт, барилгын материалын үйлдвэрлэл,

	427 дугаар хаалттай хорих анги		тоосго хийх, хадлан бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэл
11	433 дугаар хаалттай хорих анги	Хаалттай	Төмс, хүнсний ногоо тариалалт, хадлан бэлтгэл, мод бэлтгэл, төмөр болон модон эдлэл үйлдвэрлэх, гар урлал, сур эдлэл,
12	Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах 435 дугаар хаалттай хорих анги	Хаалттай	Дархан нэхий эдлэлийн үйлдвэрлэл
13	Булган аймгийн Булган суманд байрлах 439 дүгээр хаалттай хорих анги	Хаалттай	Шохойн олборлолт, шохой үйлдвэрлэл, замасканы үйлдвэрлэл, чулуун хийцийн үйлдвэрлэл
14	Дарь эх дахь 441 нээлттэй хорих анги	Нээлттэй	Төмөр хийцийн үйлдвэрлэл
15	Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах 445 дугаар нээлттэй хорих анги	Нээлттэй	Эсгий болон гар урлал
16	Ховд аймагт байрлах 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Нээлттэй, хаалттай	Төмс, хүнсний ногоо тариалалт, гутал оёдол

Монгол улсад нийт төвлөрсөн 20 хорих анги байгаагаас 15 нь үйлдвэрлэл эрхэлж байна. Хорих ангиуд нь төрийн бус байгууллагуудтай хамтарч хоригдлуудыг чадавхжуулж мэргэжлийн үнэмлэх олгодог. Сүүлийн 2 жилийн статистикийг харахад мэргэжлийн үнэмлэхтэй болсон хоригдлын тоо өссөн байгаа нь ажиглагдаж байна.

График 1. Мэргэжлийн үнэмлэх олгосон хоригдлын тоон үзүүлэлт



Үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа бүхий л газарт байх шаардлагатай зүйл бол хөдөлмөрийн аюулгүй байдал юм. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг олон жилийн өмнөөс анхааран засан сайжруулж ирсэний заримаас дурьдвал:


Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 257 дугаар тогтоолоор анхны (1997-2000 он), 2001 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан хоёрдох хөтөлбөр (2001-2004), “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр” чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улс 2005 онд олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай” 155 дугаар конвенцэд нэгдэн орсон бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарттай холбоотой бүлгийг уг конвенцийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, олон улсын стандартын дагуу явагдах болсон юм.

Өнөө үед техникийн шинжлэх ухааны хөгжил нь нийгмийн харилцааны хөгжлийг хурдасгах ба хөгжил дэвшил дээд түвшинд хүрсэн тохиолдолд хүний боловсролын түвшин өндөрсөж боловсрол сайтай ажилтан ажлын талбарт осолдох нь бага байх магадлалтай.¹⁵⁵

Хоригдол, яллагдагч нас барсан талаарх тоон судалгааг өмнөх онуудтай харьцуулан графикаар харуулбал:

График 2. Хорих анги, цагдан хорих байранд нас барсан хоригдол, яллагдагчийн судалгаа



2013 онд нийт 20 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 16, амиа хорлосон 1, хөдөлмөр хамгааллын ослын улмаас 1, гэмт хэргийн улмаас 2; 2014 онд нийт 28 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 21, амиа хорлосон 6, хөдөлмөр хамгааллын ослын улмаас 1; 2015 онд нийт 15 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 12, амиа хорлосон 1, гэмт хэргийн улмаас 2; 2016 онд нийт 17 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 14, амиа хорлосон 1, хөдөлмөр хамгааллын ослын улмаас 1, гэмт хэргийн улмаас 1; 2017 онд нийт 10 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 9, гэмт хэргийн улмаас 1; 2018 онд нийт 14 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 12, амиа хорлосон 2; 2019 онд нийт 13 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 10, амиа хорлосон 3; 2020 онд нийт 13 хоригдол, яллагдагч

¹⁵⁵ Авдай, Ч. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. -УБ., 2006. 14 дэх тал.

нас барснаас, өвчний учир 11, амиа хорлосон 2; 2021 онд иийт 18 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 14, амиа хорлосон 4; 2022 онд нийт 14 хоригдол, яллагдагч нас барснаас, өвчний учир 9, амиа хорлосон 4, хөдөлмөр хамгааллын 1 хоригдол тус тус нас барсан байна.

Сүүлийн 10 жилийн хоригдлуудын нас баралтын үзүүлэлтийг харахад хөдөлмөр хамгааллын ослоор нас барсан хоригдол харьцангуй бага буюу зарим жилүүдэд 0 байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг чандлан мөрдөж байгаа нь ажиглагдаж байна.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

1. Үйлдвэр албан газруудад хөдөлмөр хамгааллын ажлыг зохион байгуулан удирдах, төлөвлөх, хөдөлмөр хамгаалалд зориулсан төсвийг бий болгон зарцуулах;
2. Ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга, техникт сургах;
3. Үйлдвэрлэлийн осол, золгүй явдлыг гаргахгүй байх гарсан ослыг шалган бүртгэж дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
4. Үйлдвэрийн осол, золгүй явдлаас урьчилан сэргийлэх, эмнэлгийн үзлэгийг явуулах;
5. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр хангах үйл ажиллагаанууд багтдаг байна.

Аюулгүй ажиллах арга техник, үйлдвэрийн эрүүл ахуйн зааварчилгаа гэдэг нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга техник, эрүүл ахуйн дүрэм, журмуудыг судлуулан ажлын арга барилыг ажилтнуудад мэдүүлж үйлдвэрийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чадварыг эзэмшүүлж байгаа захиргааны үйл ажиллагаа мөн. Энэхүү зааварчилгаа нь урьдчилсан, ажлын байрны, давтан өгөх зааварчилгаа, сургалт гэсэн төрөл, хэлбэртэй байна. Ажлын байрны зааварчилгааг хоригдлуудын хийж гүйцэтгэх ажилтай нь шууд холбогдсон арга барилыг эзэмшүүлэх зорилгоор өгөх бөгөөд уг зааварчилгааны агуулга нь ажлын байранд хоригдлуудын гүйцэтгэх үүрэг, түүний хэрэгжүүлэх журам, багаж, төхөөрөмжийн байршилт, ажиллуулах журам, ажлын үед гарч болзошгүй осол, гэмтэл, түүнийг зайлуулах арга зам, ажлын байранд тээврийн хэрэгслүүдийн ажиллах журмыг танилцуулах үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Хүнээс ерөнхий болон тусгай мэргэжил шаардахуйц орчин үеийн механикжсан, техникжсэн үйлдвэр цехэд хоригдлыг ажиллуулах нь тэднийг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой бөгөөд мэргэжлийн түвшинг ахиулах, өөрийн ажлыг хангалттай биелүүлсэн хоригдлыг сэтгэл зүйн хувьд урамшуулах хэлбэрийг ашиглаж ирсэн уламжлалыг шинэ нөхцөл байдлаар баяжуулан хэрэглэж болох талтай. Хорих байгуулага дахь хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт нь ял эдлүүлэх дэглэм, зэрэглэлийн онцлогт тохирсон өөрийн өвөрмөц хэлбэртэй ч нийтлэг зарчимд тулгуурлагдсан байна.

Хорих ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн чиглэлийг Засгийн газар тогтоодог ба улс орны тухайн цаг үеэс шалтгаалан янз бүрээр өөрчлөгдөж иржээ.

Хорих байгууллагын хоригдлын хөдөлмөрийн нөхцөлд дараах зарчмууд байна. Үүнд:

1. Хоригдлын хөдөлмөрийг уламжлалт зах зээлийн харилцаанд нийцүүлэн зохион байгуулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Хоригдлыг хэдийгээр албадан хөдөлмөрлүүлэх боловч тэдэнд эрхэлж буй үйлдвэрийн чиглэлээр хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх;
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан орчинд ажиллуулах, тэдний амьдрах эрүүл ахуйн нөхцлөөр хангах;
4. Хуулийн дагуу хөдөлмөрийн хөлс олгох;
5. Хорих ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн ажиллагаа улсын болон хувийн хэвшлийн үйлдвэрүүдийнхээс зарчмын хувьд ялгаагүй боловч, өөрийн байгууллагын гол зорилт болсон хоригдлыг нийгмийн хүмүүжүүлэх болон хорих дэглэмийн шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажиллагаанаас үндэслэн зарим онцлогтой байдаг.

Хорих ангид хоригдлын өдөр тутмын хөдөлмөрийн үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба хаагч ангийн даргын шууд удирдлагаар арга хэмжээг авч хэрэгжүүлэн, шаардлагатай шийдвэрлэх саналыг өгч ажиллаж байгаа ба төсвийн байгууллагууд батлагдсан төсвийн 0.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулах эрх зүйн орчинтой юм. Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дараах хууль, журам, стандартуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухайхууль;
4. Хорих ангийн дотоод журам;
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн журам;
6. Холбогдох стандарт нийт /Монгол улсын хэмжээнд нийт 120 стандарт/;
7. Барилгын норм ба дүрм /БНБД/;
8. Өргөх, зөөвөрлөх механизмын аюулгүй ажиллагааны дүрэм;
9. Эрчим хүчний тухай, Эрчим хүчний тоног төхөөрөмжийн тусгай ажиллагааны дүрэм;
10. Хүнд машин механизмын аюулгүй ажиллагааны дүрэм;
11. Бага хүчин чадлын зуух ашиглах дүрэм, стандартууд болон холбогдох бусад бичиг, баримтуудын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 216 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглоно.

1. Харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй;
2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам биелэгдээгүй, эсхүл энэ талаар зааварчилга өгөгдөөгүй;

3. Эмч болон сэтгэл зүйч хоригдлын биеийн эрүүл мэндийн байдал дордсон, сэтгэл санаа тогтворгүй байгаа тухай тодорхойлолт гаргасан;¹⁵⁶ гэж заасан байна.

Өнөөдрийн байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэхдээ дээрх хууль, журам, стандартуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа боловч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зөрчигдөж ажлын байранд бэртэл, гэмтэл гарсаар байна.

2023 он гарсаар хорих анги байгууллагуудын хэмжээнд үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан нэр бүхий 2 хоригдол хүнд хэлбэрийн бэртэл авсан байх ба осол гарсан шалтгаан нөхцөлийг судлахад хариуцсан алба хаагчийн хариуцлага, хяналт алдсан байдал мөн мэргэжлийн дадлага, сургалт зохион байгуулаагүй зэргээс гарсан болох нь тогтоогдсон байна¹⁵⁷.

Өнөөгийн нөхцөлд нээлттэй, хаалттай хорих анги, шийдвэр гүйцэтгэх газруудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа нь үндсэн 2 хэлбэрээр зохион байгуулагдаж байна.


1. Хоригдол хорих ангийн үйлдвэрийн бүсэд хөдөлмөрлөх үед хорих анги хариуцах;

2. Гэрээгээр ажиллах тохиолдолд тухайн аж ахуй нэгж байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж байна.

График 3. ШШГЕГ-ын харъяа хорих ангиудын хоригдлуудад нарийн мэргэжлийн эмч нарын хийсэн урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо мэдээ

¹⁵⁶ Төрийн мэдээлэл. -УБ. 2017. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.

¹⁵⁷ 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 04 дүгээр улирлын тайлан.



Нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан аливаа байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг ойлголтод “Хөдөлмөрийн эрүүл ахуй”-н тухай асуудал чухлаар яригдах болжээ. 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүн 2022 онд нийт хорих ангиудад давхардсан тоогоор 4270 хоригдолд нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн байна.

Дээрх судалгаатай уялдуулан хөдөлмөрийн хүнд нөхцөл буюу шохойн чулуу боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг 415 дугаар хаалттай хорих ангиас 2022 онд нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нэр бүхий 264 (давхардсан тоогоор) хоригдлын өвчлөлд дүн шинжилгээ хийхэд 114 буюу нийт өвчлөлийн 43%-ийг дотрын тэр дундаа уушгины өвчлөл эзэлж байх нь хоригдлуудын эрхэлж буй хөдөлмөрөөс шалтгаалан эрүүл мэндэд шууд бус замаар буюу урт хугацааны явцад сөрөг байдал илэрч болзошгүй байх тул үүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч ажиллах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд, хоригдлын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, эрх зүйн зохицуулалт, хууль, стандартуудыг нэр мөр хангахгүй байгаагаас шалтгаалан эрсдэл гарсаар байна.

Хорих ангиуд болон хоригдлоор хөдөлмөр эрхлүүлж буй газрууд тэдний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах чиглэлд хангалт, хувцас, хэрэглэлийг хангалттай хүрэлцэхүйц байдлаар зохион байгуулаагүй.

Хоригдлын хөдөлмөрийг өдөр тутам мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй алба хаагч нарын мэдлэг, чадвар дутмаг мэргэжлийн бус алба хаагч нар томилогдон ажилладаг.

Шохойн чулуу олборлодог, боловсруулдаг үйлдвэрт ажилладаг хоригдлуудад үзүүлэх эрүүл мэндийг үзлэг, оношлогоог шинэ түвшинд гаргаж ирэх энэ зүйл дээр удирдлагын зүгээс онцгой анхаарах шаардлага байна.

Санал

Судалгааны ажлын явцад дараах санал, анхаарах асуудлыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хамгааллын талаар сургалтыг алба хаагч нарт явуулж хэрэгжилтэнд хяналт тавих;

2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар бүр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбогдуулан тодорхой төсөв бүрдүүлэнүйлдвэрлэлийн осол, золгүй явдлаас урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол үр дүнтэйгээр явуулж хэвших;

3. Аюулгүй ажиллагаа, эрүүл мэндтэй холбогдсон бүхий л эрсдэлийг төрөлжүүлэн (жишээ нь: үйлдвэрт ажилладаг ажилчдын хувьд чих-сонсголын эрүүл ахуй гэх мэт төрөлжүүлэн тогтоох) ажилтан бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангажтухайн хорих ангийн үйлдвэрлэлд тохирсон төхөөрөмж, хувцсыг зохион бүтээх, үйлдвэрлэх, нийлүүлэх, хэрэглэх, шалгах;

4. Ажлын нөхцөлийн улмаас үүсэх бие болон сэтгэцийн дарамт ачааллаас урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Ашигласан материал

1. БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл, 1930, №49.
2. Авдай, Ч. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. -Уб., 2006.
3. Төрийн мэдээлэл. -Уб. 2017. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.
4. 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 04 дүгээр улирлын тайлан.

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТ

EXERCISE OF THE RIGHTS AND OBLIGATIONS OF THE PAYER, RELEVANT REGULATIONS

Б.Халиун
ДХИС-ийн магистрант, дэслэгч

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо ихэсч, гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийн хувь буурч, ажиллагаа удаашрах хандлагатай байгаа бөгөөд төлбөр төлөгчийн зүгээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийх, ажиллагаанд саад учруулах явдал ихээр гарах болсон. Иймд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч тал болох төлбөр төлөгчийн эрх, үүргийн зохицуулалт оновчтой эсэх, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар боловсронгуй болгох саналыг дэвшүүлэхийг зорилго.

Abstract: In recent years, the number of applications and complaints related to the execution of judgments has increased, the percentage of execution of execution documents has decreased, the process has tended to slow down, and the payer deliberately avoids the execution of court decisions and obstructs the process. Therefore, we aim to put forward proposals for improvement by analyzing whether the regulation of the rights and obligations of the payer, who is a stakeholder in the civil decision enforcement process, is optimal, and the implementation of criminal liability in case of avoiding the execution of the court decision.

Түлхүүр үгс: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрх, эрх чөлөөг хангах, албадлагын арга хэмжээ, төлбөр төлөгч, үүрэг, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх, хариуцлага.

Keywords: Enforcement, enforcement of rights and freedoms, coercive measures, payers, obligations, avoidance of court orders, liability.

Оршил

Дэлхийн улс гүрнүүдийн эрх зүйн зохицуулалтын нэг нийтлэг зорилго бол хуулиар олгогдсон иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах явдал бөгөөд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд түүнийг түргэн, шуурхай, цаг хугацаанд нь асуудлыг шийддэг арга механизмыг процессын хуулиудаараа зохицуулж өгсөн байдаг¹⁵⁸.

Иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, эрүүгийн хэргийн хохироос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг шийдвэр гүйцэтгэгчид хэрэгжүүлж байна.

Нийгэм эдийн засгийн харилцаа өргөжин тэлэхийн хэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ тэлж, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүн, биелүүлэх шийдвэрийн төрөл нэмэгдэж байгаа өнөө үед шүүхийн шийдвэрийг шуурхай, үр дүнтэй гүйцэтгэх нь шийдвэр гүйцэтгэгчээс ихээхэн ур чадвар, хичээл зүтгэл, тэвчээр хатуужлыг шаардаж байна.

Үндсэн хэсэг

Иргэний хэргийн талаар гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журам эрхийн актын хүрээнд хэрэгжүүлж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх


¹⁵⁸ Саяболд Б. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь гуравдагч этгээдийн оролцоо, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2020. 1 дэх тал.

баримт бичгийн төрлөөс шалтгаалан үүссэн, процессын шинжтэй шүүх эрх мэдлийн төрийн үйл ажиллагааны нэгэн хэлбэр мөн¹⁵⁹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь төрийн төлөөлөгч болохынхоо хувьд холбогдох хууль тогтоомж болон ёс зүйг чанд сахиж, түүнийг үлгэрлэн биелүүлж байхын зэрэгцээ ард түмэнд үйлчлэгч байх ёстой. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу тодорхой үүргээ биелүүлээгүйн улмаас бусдын эдийн засгийн болон бусад эрхэд хор уршиг учруулсан этгээдийн эд хөрөнгийн болон бусад эрхэнд нь хуульд заасан журмаар халдах буюу хөндөж байдаг төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Нөгөө талаас дээрх албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирсон этгээдийн эрх, ашиг сонирхлыг сэргээж байгаа Үндсэн хуульд тусгалаа олсон эрх чөлөөг хангах хамгаалах төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нэг хэлбэр болдог.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2021 онд 8483 гүйцэтгэх баримт бичиг, 2022 онд 14000 гүйцэтгэх баримт бичиг, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 11423 гүйцэтгэх баримт бичиг ирсэн¹⁶⁰ нь жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

График 1. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн гүйцэтгэх баримт бичгийн тоо /2021-2023 оны 3 дугаар улирлын байдлаар/



Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тодорхой эрх, эрх чөлөө нь хуулийн хүрээнд хөндөгдөж, нөгөөтэйгүүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэж байдаг субъектууд бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болох төлбөр төлөгч, төлбөр авагч нар юм.

Төлбөр авагч гэж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.¹⁶¹

Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.¹⁶²

Төлбөр төлөгч, төлбөр авагч талууд нь шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны оролцогч талуудын хувьд хуульд заасан эрх, үүргийг хүрээнд шийдвэр гүйцэтгэх байгууллагатай шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болох хүртэл харилцдаг¹⁶³.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад байлцах,

¹⁵⁹ Дашзэвэг Б. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. УБ. 2003. 135 дахь тал.

¹⁶⁰ Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтэс.

¹⁶¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 32 дугаар зүйл.

¹⁶² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 32 дугаар зүйл.

¹⁶³ Дашзэвэг Б. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. УБ. 2003. 150 дахь тал.

холбогдох баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, санал, хүсэлт гаргах, шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах гэх зэрэг эрхтэйгээр оролцдог.

Бусдын хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээд болох төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тодорхой үйлдэл хийх, эсхүл түүнээс татгалзах, шүүхийн шийдвэрт заагдсан эд хөрөнгө, мөнгийг шилжүүлэх, оршин суугаа /оршин байгаа/ газрын хаягийг өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх, хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйгээр ажиллагаанд оролцож байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгчийн хүлээх үүргийг дээрх байдлаар хуульчилсан нь тодорхой бус, нийтлэг байдлаар тусгасан гэж үзэж байгаа бөгөөд дээрх нөхцөл байдлаас үүдэн төлбөр төлөгч шүүхийн шийдвэр болон шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл тоодог, биелүүлдэггүй, дүр эсгэж биелүүлдэг, ажиллагаанд санаатайгаар саад учруулж, удаашруулдаг, шийдвэр гүйцэтгэгчид ажлын ачаалал бий болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Төлбөр төлөгч нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх шатанд хариуцагчаар оролцдог бөгөөд хэргийн оролцогчдийн эдлэх эрх, хүлээх үүргийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан байдаг.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатанд хариуцагчийг нотлох баримт, холбогдох баримт бичгийг цуглуулж, гаргаж өгөх, шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, шүүхийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх зэргээр үүрэгжүүлж хуулиар зохицуулсан хэдий ч шүүхийн шийдвэр гарсны дараах буюу шүүхийн шийдвэрийг биелүүлэх шатанд төлбөр төлөгчийн хүлээх үүрэгт дээрх үүргүүдийг тусгаж өгөөгүй ба "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй"¹⁶⁴ гэсэн заалтад нийтлэг байдлаар хавтгайруулан тусгасан гэж үзэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шийдвэр, мэдэгдэл, мэдэгдэх хуудсыг талуудад танилцуулах, гардуулан өгөх, гарын үсэг зуруулах үүрэгтэйгээр хуульчилсан боловч төлбөр төлөгчид тэрхүү шийдвэр, мэдэгдлийг гардаж авах үүргийг хуульчилж өгөөгүй нь шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцлийг нэгээхэн хэсэг гэж үзэж болох юм.

Учир нь шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн аваад нэн тэргүүнд төлбөр төлөгчийг дуудан ирүүлэх, хуульд заасан эрх, үүргийг танилцуулах, хөрөнгө орлогын мэдүүлэг авах, шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдэл гардуулах ажиллагааг хийж гүйцэтгэдэг. Төлбөр төлөгчийн оршин суугаа хаяг, холбогдох утасны дугаар тодорхойгүй, бүртгэлтэй хаягт оршин суудаггүй, шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр оршин суугаа хаяг, холбогдох утасны дугаараа солих, шийдвэр гүйцэтгэгчийн дуудсан цагт болон зарлан дуудах мэдэгдэлд заасан хугацаанд ирдэггүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдэгдлийг хүрэлцэн ирж гардан авдаггүй, мэдэгдэлд дурдсан үүргийг тогтоосон хугацаанд биелүүлдэггүй, төлбөр төлөгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгч нар хуулийн зохицуулалт дутмаг байдлыг ашиглан төлбөр төлөгчийг хуульд тусгайлан хугацаа заасан мэдэгдлийг хүлээн авахаас зайлсхийхийг зөвлөх, зугтаалгах зэрэг үйлдэлтэй шийдвэр гүйцэтгэгчид өдөр тутамдаа тулгардаг. Дээрх тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдэгдэл, шийдвэрийг төлбөр төлөгчид биечлэн гардуулж чадаагүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлд холбогдох тэмдэглэлийг тусгаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичгийг тогтоосон хугацааны сүүлийн өдрийн 24 цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг хугацаанд нь хүргүүлсэнд тооцно"¹⁶⁵ гэх заалтыг баримтлан шүүхийн шийдвэрт заагдсан болон сүүлд бүртгэл хийлгэсэн хаягийн дагуу баталгаат шуудангаар

¹⁶⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 9 дүгээр зүйл.

¹⁶⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24. 15 дугаар зүйл.

хүргүүлэн ажиллаж байна. Төлбөр төлөгчийн зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдэгдэл, шийдвэрийг гардаж аваагүй, мэдээгүй гэх шалтгаанаар шүүхэд болон ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэн өөрт ашигтай байдлаар хугацаа хожих явдал гарсаар байна.

2023 оны байдлаар Нийслэлийн хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.1 дахь заалтын дагуу талуудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шүүхэд хандан гаргасан 43.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 151 гүйцэтгэх баримт бичиг, 27.2.5 дахь заалтын дагуу буюу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд эсхүл дээд шатны байгууллагад гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор 40.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 113 гүйцэтгэх баримт бичигт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн байна¹⁶⁶.

Аливаа харилцаанд эрх, үүргийн талаар дурдаж байгаа бол түүнийг дагаад хариуцлагын асуудлыг орхигдуулж болохгүй юм. Төлбөр төлөгчийн шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, дүр эсгэж биелүүлсэн, эд хөрөнгөө нуун далдалсан, бусдад шилжүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд Эрүүгийн хуульд заасан "хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх", шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, саад учруулсан, шийдвэр гүйцэтгэгчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол Зөрчлийн тухай хуульд заасан "хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох" хариуцлага оногдуулах зохицуулалттай.

Судлаачийн зүгээс төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг биелүлдэггүй, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүлдэггүй, өөрийн эд хөрөнгийг бусдын эзэмшилд, өмчлөлд бүртгүлдэг, нийгмийн даатгалын шимтгэл төлөлгүй хөдөлмөр эрхэлж орлогоо нуун дарагдуулах зэргээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулж, шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжтой хэдий ч санаатайгаар зайлсхийсээр байгаа нь хуулинд төлбөр төлөгчийг үүрэгжүүлээгүй, хариуцлага оногдуулах хуулийн зохицуулалт төдийлөн сайн хэрэгжихгүй, үр нөлөөгүй байгаатай холбон үзэж байна.

Гадаад орнуудад төлбөр төлөгчид оногдуулах хариуцлагын зохицуулалт, хэрэгжилт өндөр түвшинд байгаа бөгөөд оногдуулж буй ялын хэмжээ нь өндөр байна. Жишээлбэл, Холбооны Бүгд Найрамдах Герман улсад "шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд саад учруулбал 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ", Бүгд Найрамдах Болгар улсад "шүүхийн шийдвэрээр бусдад төлөх ёстой мөнгөн төлбөрийг төлөх бололцоотой боловч 1 жилийн дотор санаатай төлөөгүй бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"¹⁶⁷, Бүгд Найрамдах Солонгос улсад "шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийх тохиолдолд 5 сая вонноор торгох, 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"¹⁶⁸ хэмээн тус тус хуульчилсан байна.

Улсын хэмжээнд 2002-2023 оны хооронд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага оногдуулсан нийт 13 тохиолдол байгаа¹⁶⁹ бөгөөд энэхүү тоо баримт нь Эрүүгийн хуулийн 21.7 д заасан зохицуулалт үр нөлөөгүй байгаа болохыг харуулж байна. Мөн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн 99 төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх саналыг Цагдаагийн

¹⁶⁶ Шийдвэр гүйцэтгэх алба. Мэдээлэл лавлагаа, дүн шинжилгээний хэлтэс.

¹⁶⁷ Зая А. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага: Эрх зүйн зохицуулалт, практик. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2016. 35 дахь тал.


¹⁶⁸ Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл. УБ. 2020. 250 дахь тал.

¹⁶⁹ Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. (2023.09.27-ны өдрийн байдлаар)

байгууллагад хүргүүлсэнээс 53 төлбөр төлөгчид холбогдуулан хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан, 14 төлбөр төлөгчид холбогдуулан хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн боловч татгалзсан, 29 төлбөр төлөгчид холбогдуулан хэрэг бүртгэлийн хэрэг нээн шалгаж байгаа, 3 төлбөр төлөгч Цагдаагийн байгууллагад шалгагдаж байх явцад төлбөрөө бүрэн төлсөн үзүүлэлттэй байна¹⁷⁰.

График 2. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Цагдаагийн байгууллагад хүргүүлсэн саналын шийдвэрлэлт.

- **хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан 53**
- **хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн боловч татгалзсан 14**
- **хэрэг бүртгэлийн хэрэг нээн шалгаж байгаа 29**
- **шалгах явцад төлбөрөө бүрэн төлсөн 3**



Цагдаагийн байгууллагаас шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзсан тохиолдлуудын 90-95 хувь нь гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр татгалзсан нь энэхүү гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хэрхэн тодорхойлох талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна.


Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Банкны төлбөр барагдуулах газрын нийт 20 шийдвэр гүйцэтгэгчээс түүврийн аргаар судалгаа авсан бөгөөд дараах үр дүнг үзүүлсэн. Үүнд:

1. "Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хуульд заасан үүргээ биелүүлдэг эсэх" гэсэн асуултад нийт оролцогчдын 69.2 хувь нь "Үгүй" гэсэн хариултыг, 30.8 хувь нь "Тийм" гэсэн хариултыг сонгосон байна.


2. "Та ШШГТХ-д ИШГА талуудын эрх, үүргийн зохицуулалтыг ямар хэмжээнд тусгасан гэж бодож байна вэ?" гэсэн асуултад нийт оролцогчдын 80 хувь нь "Хангалтгүй" гэсэн хариултыг, 20 хувь нь "Хангалттай" гэсэн хариултыг өгсөн байна.

График 3. Шийдвэр гүйцэтгэгчдээс авсан судалгааны үр дүн

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хуульд заасан үүргээ биелүүлдэг эсэх



Та ШШГТХ-д ИШГА талуудын эрх, үүргийн зохицуулалтыг ямар хэмжээнд тусгасан гэж бодож байна вэ?



¹⁷⁰ Нийслэлийн шүүхийн шийдвэрийн газрын Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтэс.

3. "Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцлийг таны хувьд юу гэж үзэж байна вэ?" гэсэн нээлттэй асуултад нийт оролцогчдын 65 хувь нь "төлбөр төлөгчид ногдуулах хариуцлага сул, үүрэг тодорхойгүй, хууль зөөлөн" гэх хариултыг, 35 хувь "төлбөр төлөгчийн төлбөрийн чадамж чадамжгүй, хөрөнгө орлогогүй, ажлын ачаалал их тул бүх материалд хүрч чадахгүй" гэх зэргээр хариулсан байна.

4. "Гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлага ямар байгаагаас үл хамааран талуудын эрх, үүрэг тодорхой бус, нийтлэг байдлаар тусгасан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ?" гэсэн асуултад "шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулдаг, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэхгүй байх нөхцөл болдог, талуудаас гомдол гаргах нөхцөл болдог" зэрээр хариулсан байна.

5. "ИШГА талуудын эрх, үүргийг шинэчлэн хүлээх үүргийг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байгаа эсэх" гэсэн асуултад оролцогчдын 92.3 хувь нь "Шаардлагатай", 7.7 хувь "Шаардлагагүй" гэсэн хариултыг өгсөн байна.

6. "Таны бодлоор ИШГА талуудын эрх, үүрэгт хуульд нэмэлтээр ямар үүргийг нэмж тусгах шаардлагатай вэ?" гэсэн нээлттэй асуултад оролцогчдын илгээсэн хариултын 60 орчим хувь нь нийтлэг байдлаар "Хариуцлага оногдуулах, албадлага хэрэглэх зохицуулалтыг сайжруулах" гэсэн хариултыг өгсөн ба үлдсэн 40 хувь нь "Сард 1 удаа хяналтад орж, уулзаж байх", "Холбогдох утасны дугаарыг өөрчлөхдөө урьдчилан мэдэгдэх", "Нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй ажил эрхлэлтийг мэдээллэх" гэх зэрэг хариултуудыг өгсөн байна.

Дүгнэлт

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрх, үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хангалтгүй, нийтлэг байдлаар тусгаснаас шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах, төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчийг үл тоох, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийх зэрэг үйлдэл гарсаар байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт буурах, шийдвэр ажиллагаа удааширч, төлбөр авагчийн эрх зөрчигдөж, тэдний зүгээс гаргасан гомдлын тоо сүүлийн жилүүдэд өссөн хандлагатай байна.

Мөн төлбөр төлөгчид оногдуулах хариуцлагын механизмийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд хэдийгээр шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуулийн хүрээнд тайлбарлаж, танилцуулж байгаа хэдий ч уг зохицуулалт нь хэрэгжихгүй, үр нөлөөгүй байгаа нь төлбөр төлөгчийн хуулиас эмээх, хуульд захирагдах байдлыг үгүй болгж байна.

Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн, шуурхай зохион байгуулахад талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын зохицуулалтыг сайжруулах, шинэчлэх хэрэгцээ шаардлага нэгэнтээ бий болжээ.

Санал

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалтыг сайжруулахад дараах саналыг дэвшүүлж байна.

1. Төлбөр төлөгчийн үүргийг тодорхой хуульчилж "Төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдон гарсан хуульд тусгайлан хугацаа заасан шийдвэр, мэдэгдлийг биечлэн гардаж авна. Хуульд заасан хугацаанд гардаж аваагүй тохиолдолд хүлээн зөвшөөрсөнд тооцно.", "Төлбөр төлөгч холбогдох утасны дугаар болон оршин суугаа хаягаа өөрчилсөн тохиолдолд даруй шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх", "Төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх", "Төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шаардлагатай баримт, материалыг шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд бүрдүүлж өгөх" зэргээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулан төлбөр төлөгчийг үүрэгжүүлэх;

2. Шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн төлбөр төлөгчид оногдуулах хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүгийн хуулийн 21.7 дахь хэсэгт "хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ...шүүхийн шийдвэрийг биелүүлэх бололцоотой атал биелүүлээгүй...." гэх үндэслэлийг нэмж оруулах;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлон зааж, зарим тайлбарыг нэг мөр хэрэглэх боломжийг үүсгэх зэрэг саналтай байна.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Зөрчлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24.
 2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2002. №8.
 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №24.
 4. Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.
- Ном, сурах бичиг:
5. Батболд Б нар. Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл. УБ. 2020.
 6. Дашзэвэг Б. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. УБ. 2003.
 7. Өнөрцэцэг Ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. УБ. 2022.
 8. Зая А. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага: Эрх зүйн зохицуулалт, практик. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2016.
 9. Саяболд Б. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь гуравдагч этгээдийн оролцоо, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2020.
- Цахим эх сурвалж:
10. <https://shuukh.mn/>.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ, ХИМИЙН БОЛОН АЮУЛТАЙ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ДАГУУ АЖИЛЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

ACCORDING TO POLICE DEPARTMENT CALLS RELATING TO EXPLOSIONS,
CHEMICAL OR HAZARDOUS SUBSTANCES SOME PROBLEMS TO CONSIDER IN
OPERATION

Б.Баянмөнх
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай бодисын осол нь химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн болон аюултай бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ноцтой аюул учирдаг үзэгдэл юм.

Энэхүү өгүүлэлд тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодисын тухай ойлголт, түүний илрэх шинж, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтаас үүдэлтэй гарч болох дэлбэрэлт, түүний хор уршиг, цагдаагийн алба хаагчаас химийн хорт болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээллийн дагуу авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар товч авч үзсэн болно.

Abstract: Explosive, chemical and hazardous substance accidents are phenomena in which chemical and hazardous substances are lost due to damage during the storage, transportation, and use of hazardous chemical substances in production, as well as violations of technological procedures, which pose a serious threat to the environment and human health.

In this article, the concept of exploding, toxic and dangerous chemicals, their manifestations, explosions that may occur due to the storage and protection of toxic and dangerous chemicals, their consequences, the actions taken by police officers in response to calls related to toxic and dangerous chemicals, measures are briefly discussed.

Түлхүүр үгс: Химийн бодис, аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэрэлт, хор уршиг, цагдаагийн алба хаагч, ослын дуудлага мэдээлэл

Keywords: Chemicals, dangerous substance, explosives, explosion, damage, police officers and emergency call information

Дарь, тэсрэх бодис нь маш богино хугацаанд асар их хор хохирол учруулах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул тарих, аюулын өндөр эрсдэл бүхий химийн хорт бодисын нэгдэл учир хүн бүрээс хатуу чанд сахилга бат, өндөр хариуцлага, дэлхий нийтийн жишигт дүйцэхүйц дүрэм, стандарт, хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаарддаг.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹⁷¹, Байгаль орчныг хамгаалах тухай хууль¹⁷², Зөвшөөрлийн тухай¹⁷³, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль¹⁷⁴, Хог хаягдлын тухай

¹⁷¹ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1992. №1.

¹⁷² Байгаль орчныг хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1995. №5-6.

¹⁷³ Зөвшөөрлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2022. №38.

¹⁷⁴ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2012. №22.

хууль¹⁷⁵, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль¹⁷⁶, Гамшгаас хамгаалах тухай хууль¹⁷⁷, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрддэг.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1-д химийн аюултай бодистой холбоотой нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

- “химийн хорт бодис” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “химийн аюултай бодис” гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “хориглосон химийн бодис” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглэхийг хориглосон химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “хязгаарласан химийн бодис” гэж зөвхөн зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэхийг зөвшөөрсөн химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “пестицид” гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг¹⁷⁸ хэмээн тодорхойлжээ.

Харин Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлд “тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг¹⁷⁹ хэмээн тодорхойлжээ.

ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-д тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт бодис, цацрагт идэвхт бодисын хөнөөл, химийн осол гэсэн нэр томъёонуудыг тодорхойлжээ. Тухайлбал:

- “Тэсэрч дэлбэрэх бодис” - тэсрэлтийн хүчийг ашиглах зориулалттай гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольцыг;

- “Химийн хорт бодис” - хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

- “Цацраг идэвхт бодис” - ураны хүдрээс илүү хүчтэй туяа цацруулдаг, химийн элементийн “Радий”-ийн төрлийн бодисуудыг;

- “Цацраг идэвхт бодисын хөнөөл” - цөмийн төхөөрөмжийн технологийн аюулгүй байдал алдагдсаны улмаас гамма ба бета төрлийн цацраг идэвхт бодисууд хий, шингэн, аэрозоль хэлбэрээр алдагдан гадаад орчинд /хүрээлэн буй орчинд/ цацагдахыг цацрагийн хөнөөлийг;

- “Химийн осол” - химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулах үзэгдлийг¹⁸⁰ хэмээн тус тус тодорхойлжээ.

¹⁷⁵ Хог хаягдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017 №21.

¹⁷⁶ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

¹⁷⁷ Гамшгаас хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017. №7.

¹⁷⁸ Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2006. №25.

¹⁷⁹ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

¹⁸⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 419 дэх тал

Гэвч дээрхи хууль, эрх зүйн актуудад аюултай бодис гэж юуг ойлгох талаар нарийвчлан тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолт байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь 1. хортой; 2. аюултай гэж тус тус ангилна.

Өнөөдөр террорист байгууллага, хувь хүмүүс нь олон нийтийг айдаст автуулсан мэдээлэл цацах, мэдээлэл технологийн сүлжээнд халдах /хакер/, хүн, объект, тээврийн хэрэгсэл барьцаалах, хууль бус жагсаал цуглаан зохион байгуулж, үймээн самуун бий болгох, тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай бодис, тэсрэх бөмбөгийг олон нийтийн газар болон онц чухал объектод тавих зэрэг олон нийтийг айдас хүчирхийлэлд оруулах маш олон арга хэрэгсэл ашиглаж байна.

Тэсрэх бодис, тэсрэх бөмбөг аюулгүй болгох нь ажиллагаа нь тусгай зориулалтын техник хэрэгсэл болох робот, хувцас, дуулга, соронзонгүй багаж, уураг, зөөврийн рентген төхөөрөмж, үйлдвэрийн зориулалттай тэсрэх цэнэг зэргийг бэлтгэсэн байхын зэрэгцээ тусгай мэдлэг эзэмшсэн, техник хэрэгслийг ажиллуулж чадах мэргэжлийн тусгай мэдлэгтэй, мэргэшсэн алба хаагч хэрэгтэй болно.

Хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж, үйлдвэрийн барилга, байгууламжийг эвдэх, тоног төхөөрөмж, механизм, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг гэмтээх устгах, үйл ажиллагааны хэвийн хэмжээг алдагдуулж, хүрээлэн буй орчинд хохирол учруулах, аюул үүсгэж болзошгүй үйлдвэр, тээвэр, холбоо, нийгэм, эрчим хүчний сүлжээ, зам тээврийн харилцаанд гарсан аюултай нөхцөл байдлыг үйлдвэрийн осол гэнэ.

Тэсрэх бодис химийн урвалд орж асар их хурдтай нэг байдлаас нөгөө төлөвт шилжихэд их хэмжээний хий, уур үүсч, дулаан ялгаран түүний потенциал энерги нь хүрээлэн буй орчныг бутлах, механик ажилд шилжих процессыг тэсрэлт гэнэ. Тэсрэлт нь дараах орчинд явагдаж болно. Тухайлбал: а)Газар доорхи; б)Газар дээрхи; в)Агаарт; г)Өндөрт; д)Усан доорхи; е)Усан дээрхи зэрэг болно.

Тэсрэх бодисын тэсрэлтийн үед их хэмжээний (300-1000 л/кг) хий уур үүсч, асар их дулаан (600-1700 ккал/кг) ялгаран гарах ба тэсрэлтийн температур 1500-4100 С хүрч, 8000 м/с түүнээс их хурдтай химийн урвал явагдан түүнийг дагалдан их дуу чимээ гардаг.

Тэсрэлтийг шинж чанараар нь физикийн, химийн, цөмийн гэж ангилдаг. Физикийн шинжтэй тэсрэлтийн үед бодист зөвхөн физик өөрчлөлт /цахилгаан цэнэг мөргөлдөн тэсрэх гэх мэт/ явагддаг. Химийн шинжтэй тэсрэлтийн үед химийн урвал явагдан эгшин зуурын хугацаанд хий уур үүсгэн дулаан ялгаруулна. Цөмийн болон халуун цөмийн шинжтэй тэсрэлтийн үед цөмийн хуваагдлаар шинэ элемент үүсэн цөмийн гинжин урвал явагдах ба энэ нь хамгийн хүчтэй тэсрэлт юм.¹⁸¹

Тэсрэлтийн үйлчлэлийн бүсийг детонцын долгионы, бүтээгдэхүүний тэсрэлтийн, агаарын цохилтын үйлчлэлийн бүс гэж гурав хуваадаг. Тэсрэлт нь доорхи гурван үндсэн нөхцөл бүрдсэн үед үүсдэг. Үүнд:

1. Агаар;
2. Шатах хий болон шатамхай тоос;
3. Хангалттай дөллөн асах эх үүсвэр;

Шатамхай хий нь агаартай нэгдэхэд тэсрэх аюултай холимог үүсдэг ба энэ холимог нь хангалттай дөллөн асаах эх үүсвэрийн улмаас (гал, дөл, дулаан, оч, цахилгаан тоног төхөөрөмжөөс үүсэх оч, тэнцэл цахилгаанаас үүсэх оч, халсан болон улайссан гадаргуу гэх мэт) тэсрэлт үүсдэг.

Тэсрэх аюултай объект гэдэг нь тэсрэх аюултай бодисыг хадгалах, хэрэглэх, ашиглах, зөөвөрлөх, тээвэрлэх зэрэг технологи ажиллагаа явуулдаг объектыг хэлнэ. Тэсрэх аюултай объектын орчныг Бүс-0, Бүс-1, Бүс-2 гэж гурав ангилдаг байна.

¹⁸¹ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -УБ., 2018. 250-251 дэх тал.

- Бүс-0 тоног төхөөрөмжийн ашиглалтын үед тэсрэх аюултай хийн хольц байнга буюу удаан хугацаагаар ялгарч байдаг

- Бүс-1 тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн ажиллагааны үед тэсрэх аюултай хийн хольц нь ялгарч байдаг тоног төхөөрөмж бүхий газар

- Бүс-2 тоног төхөөрөмжийн ашиглалтын хэвийн ажиллагааны үед тэсрэх аюултай хийн хольц нь ялгарч болзошгүй буюу хийн хольц хоромхон хугацаанд ялгарч байдаг.

Тэсрэх аюултай бүс гэдэг нь тэсрэх аюултай холимогтой буюу тэсрэх аюултай холимог бүрдэж буй өрөө, тасалгаа болон хязгаарлагдмал орчин, гадаа орших тоног төхөөрөмжийг хэлнэ.¹⁸²

Химийн, хийн, нефтийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд төрөл бүрийн шатах шингэн /бензин, техникийн масло, спирт/, хий /аммиак, устөрөгч, ацетилен, пропан/, хатуу материал /нүүрс, хүхэр, фосфор/-ыг өргөнөөр хэрэглэдэг. Мөн өндөр температур, даралттай холбоотой технологи үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүх технологи үйл ажиллагаа нь гал болон тэсрэх аюултай нөхцлийг бүрдүүлдэг. Түүнчлэн хий, шингэн нь химийн аюултай бодисоос бүрдэж байдаг учраас тэсрэх аюулыг бүрдүүлнэ. Уг тэсрэлтээс үүдэлтэй гал гарах аюул улам нэмэгддэг.

Гал нь шатах материал болон бодис, дулааны эх үүсвэр (шүдэнз, лаа, цахилгаан, химийн урвал гэх мэт), хүчилтөрөгч (агаар) гурвын харилцан үйлчлэлээр бий болдог, гэрэл, дулаан ялгаруулдаг физик, химийн үзэгдэл юм.¹⁸³

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь аюулгүй байдлын судлагдахууны хувьд эрсдэлтэй хүчин зүйлд тооцогддог байна. Өнөөдөр цэргийн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа тэсрэх бодис, ахуйн хэрэглээнд ашиглаж байгаа хийний эрсдэлийн үнэлгээг гаргах нь чухал юм.

Өнөөдөр цагдаагийн алба хаагчид тэсрэх бодис болон химийн хорт бодисын урвалаас үүсэх тэсрэлтийн талаар нэлээн өргөн мэдлэгтэй байж, эрсдлийн үнэлгээ хийж чаддаг байх нь болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Эрсдлийн үнэлгээ гэж “химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн нэгдэлтэй харьцах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг судлан тогтоож, үнэлгээ өгөх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар авах арга хэмжээг тодорхойлохыг”¹⁸⁴ ойлгоно. Эрсдэлийн үнэлгээ нь дараах үйл ажиллагаануудын нийлбэр цогц юм. Үүнд:

- Аюулыг таних;
- Холбоотой эрсдлийг шинжлэн үнэлэх;
- Аюулыг арилгах эсхүл хянах тохиромжтой хэлбэрийг сонгох;

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодистой холбоотой мэдээлэл хүлээн аваад дээр дурдсан үйл ажиллагаануудыг системтэйгээр зөв авч хэрэгжүүлж чадсанаар учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх, уг аюулыг хянах арга хэмжээ нь тохиромжтой эсэхийг тодорхойлох, сэжиг бүхий нуугдмал аюулыг илрүүлэх, олон нийтийг эрсдэлд өртөх боломжийг тодорхойлох, аюул болон хяналтын арга хэмжээний дарааллыг тодорхойлох зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагч ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-ийн 211.4.1-д заасны дагуу дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулжээ. Үүнд:

¹⁸² “Тэсрэх дэлбэрэх бодисын хэрэглээ, түүнд тавигдах шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл. -УБ., 2014. 50 дахь тал

¹⁸³ Байгалмаа, П. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье. -УБ., 2011. 4-5 дахь тал.

¹⁸⁴ Төрийн мэдээлэл. 2013. №8. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль.

- а/ тэсэрч дэлбэрэх зүйл, химийн бодис болон цацраг идэвхт байж болзошгүй зүйлд өөрөө болон бусдыг хүргэхгүй байх;
- б/ дэлбэрэлтийн бүсийн эргэн тойронд 200 метр, химийн осол болон цацраг идэвхт бодисын хөнөөлийн үед 300-500 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүс тогтоож, иргэдийг бүсээс гаргаж, бүслэн хамгаалах;
- в/ тухайн зүйлийн байршил, орчин, хэмжээ, хэлбэр, төрөл, өнгө, үнэр зэрэг гадаад шинж тэмдэг, учирсан болон болзошгүй хор уршиг, аюулын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шуурхай удирдлагын штабт мэдэгдэх;
- г/ тухайн газраас 300 алхмын дотор радио долгионы хэрэгсэл ашиглахгүй байх;
- д/ ойролцоо газар, тухайн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис байгаа эсэхийг шалгах¹⁸⁵.

Цагдаагийн алба хаагч нь Зэвсэгт хүчин, Эмнэлгийн яаралтай тусламж, Онцгой байдлын алба зэрэг ажил үүргийнхээ дагуу хамгаалалтын бүсэд нэвтрэх шаардлагатайгаас бусад байгууллага, албаны хүнийг тухайн бүсэд нэвтрүүлэхийг хориглоно. Цагдаагийн алба хаагч нь тэсэрч дэлбэрэх зүйл, химийн хорт болон цацраг идэвхт бодистой холбоотой мэдээллийн дагуу очихдоо “Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам” /код 918/-д заасны дагуу хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэнэ.

Цагдаагийн алба хаагч тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой үүсч буй аюулыг таньж илрүүлэхийн тулд уг аюулын илрэх хэлбэр, онцлог шинжийн талаар мэдлэгтэй байх, уг бодистой харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөхөөс гадна биечлэн аюулгүй болгох арга хэмжээ авч болохгүйг онцгой анхаарна.

Цагдаагийн алба хаагч химийн осол болон цацраг идэвхт бодисын хөнөөлийн үед ажиллахдаа “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/-ийн 211.5-д заасныг баримтлан мэргэжлийн байгууллагаар тухайн бодисын алдагдсан болон тархалтын хэмжээ, сөрөг нөлөөг тогтоолгосны дараа өөрсдийгөө болон оршин суугчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

а/мэргэжлийн байгууллагын өгсөн зааврын дагуу ажиллах;

б/хамгаалалтын бүсэд голомтод ажиллах мэргэжлийн байгууллагынхаас өөр гадны хүнийг нэвтрүүлэхгүй байх;

в/хамгаалах хувцас өмсөх, газ эсэргүүцэгч, хүчилтөрөгчийн баг хэрэглэх, хэрэв баг байхгүй тохиолдолд нойтон алчуураар ам, хамраа дарах;

г/хордсон болон гэмтсэн иргэдэд тусламж үзүүлэх; д/оршин суугчдыг нүүлгэн шилжүүлж эхлэх хэрэв сайн дураараа нүүхгүй бол албадан нүүлгэх.¹⁸⁶

Тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагч дор дурьдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Дэлбэрэлт болсон газрын байршил, хор уршгийн тархалт, хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээ, бэртэж, гэмтсэн иргэдийн тоо, эвдэрч гэмтсэн барилга байгууламжийн ерөнхий байдал, бусад нөхцөл байдлын талаарх мэдээллийг Шуурхай удирдлагын албанд эргэж мэдэгдэн нэмэлт тусламж хүсэх;

- Тэсэрч дэлбэрэх бодис, занга тавьсан байж болзошгүйг анхаарч, сэжигтэй зүйл илэрвэл түүнд хүрэхгүй, орчны хүмүүсийг нэн даруй холдуулж, шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай удирдлагын албанд яаралтай мэдэгдэх;

- Дэлбэрэлт болсон газар луу өөрөө болон бусад иргэдийг ойртуулахгүй байх арга хэмжээ авч, дэлбэрэлт болсон газрыг бүхэлд нь буюу төв цэгээс 50-200 метрийн тойрогт хамгаалалтын бүс байгуулж, нэмэлт хүч иртэл иргэдийг аюулгүй газар гаргах ажлыг зохион байгуулах;

- Дэлбэрэлтийн улмаас бэртэж, гэмтсэн, хордсон иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

¹⁸⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 420 дахь тал.

¹⁸⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2022. 420 дахь тал.

- Хэргийн газрын үзлэгийн багийг хүрэлцэн иртэл цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан устаж, баларч болох ул мөрийг хамгаалах арга хэмжээ авах;
- Хамгаалалтын нэмэлт хүч иртэл дэлбэрэлт болсон газрын ойролцоох аж ахуйн нэгж, байгууллагын харуул, жижүүр, хамгаалалтын ажилтнуудыг хамгаалалтанд татан оролцуулах;
- Зэвсэгт хүчин, Эмнэлгийн яаралтай тусламж, Онцгой байдлын алба зэрэг ажил үүргийнхээ дагуу хамгаалалтын бүсэд нэвтрэх шаардлагатайгаас бусад байгууллага, иргэнийг хамгаалалтын бүс рүү нэвтрүүлэхгүй байх;
- Дэлбэрэлт болсон газраас 300 алхмын дотор радио долгионы хэрэгсэл ашиглахгүй байхыг анхаарч ажиллах;
- Дэлбэрэлт болсон газрын ойролцоо нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис ашигладаг, хэрэглэдэг, хадгалдаг байгууллага, аж ахуйн нэгж байгаа эсэхийг тодруулж, сэрэмжлүүлэх;
- Дэлбэрэлтийг үйлдсэн байж болох сэжигтэй этгээд болон анхлан харсан гэрчийг олох зорилгоор биечилсэн судалгаа явуулах;¹⁸⁷

Химийн осол гарсан үед авах арга хэмжээ

Химийн ослын аюул нь хүн ба амьтанд организмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, удах тусам бие махбодийн генетик бүтцэд сөргөөр нөлөөлдөг, харин химийн аюултай бодис организмд амьсгалын замаар, арьсаар, салст бүрхүүлээр болон хоол хүнстэй хамт орсон үедээ үхэлд хүргэх аюултай байдаг.

Химийн осол гэдэг нь химийн аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэх явцад гэмтэл гарах, технологийн горим зөрчигдөх зэргийн улмаас химийн бодис алдагдаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулах үзэгдэл юм.¹⁸⁸

Хлор, аммиак, фосген, цианы хүчил, хүхэрт ангидрид зэрэг химийн аюултай бодисыг ихэвчлэн химийн, ислэг-цаасны, боловсруулах, эрдэс бордооны, хар болон өнгөт металлург, хөргөх, пивоны, чихрийн үйлдвэр, ус дамжуулах станц зэрэгт түгээмэл хэрэглэнэ.

Ажлын байрандаа ажиллаж байсан цагдаагийн алба хаагчид химийн ослын тухай “Бүгд анхаар” дохионы үед химийн ослын талаар илүү их мэдээ, мэдээлэл хүлээн авч байх үүднээс телевизор, радио асаалттай байлгах шаардлагатай.

Харин химийн аюултай бодис алдагдсан тухай анхны мэдээллийг хүлээж авсан цагдаагийн алба хаагч нэн даруй ослын газар очин тухайн орчинд ажиллаж амьдарч байгаа иргэдэд яаралтай мэдэгдэж, яарч сандралгүйгээр химийн аюултай бодис алдагдсан голомтын бүсээс салхины чиглэлд перпендикуляраар¹⁸⁹ гарч, уг голомтын төв цэгээс 1.5 км-ээс багагүй зайтай аюулгүй газарт хүргэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч химийн ослын газарт очихдоо амьсгалын эрхтэнээ хамгаалах үүднээс хорт хийнээс хамгаалах баг ашиглах бөгөөд байхгүй тохиолдолд хөвөн маарлан боолт юм уу ямар нэгэн даавуу 2-5 процентийн нимбэгний болон цууны хүнсний содын уусмалаар /хлороос хамгаалахад/ норгох, 2-5 процентийн нимбэгний болон цууны хүчлийн уусмалаар /аммиакаас хамгаалахад/ норгож хэрэглэнэ.

Цагдаагийн алба хаагч ослын бүсэд ажиллаж байгаад бүсээс гарах боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд хаалга, цонх, агааржуулах хоолой, яндан зэрэг агаар нэвтрэх боломжтой сувгуудыг сайтар хааж, ямарваа зай завсрыг цаас болон скочоор бөглөх шаардлагатай.

Төмөр зам, авто зам дээр химийн аюултай бодисын тээвэрлэлтэд осол тохиолдсон үед аюултай бүсийг осол болсон газар буюу голомтын төв цэгээс 200

¹⁸⁷ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -Уб., 2018. 250-255 дахь тал.

¹⁸⁸ Баттогтох, П., Баяржаргал, Б. Гамшиг, ослоос хамгаалах тухай гарын авлага. -Уб., 2006. 40 дэх тал.

¹⁸⁹ Энэ нь салхины дагуух чиглэлийн хөндлөн зүгт гарахыг ойлгоно.

метрийн радиустайгаар тогтоож, нийтэд илт мэдэгдэхээр таних тэмдэг тавьж сэрэмжлүүлэх шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч химийн аюултай бодист хүрсэн байж болох сэжиг илэрсэн тохиолдолд их хэмжээний шингэн /цай, сүү/ ууж, нэн даруй ойролцоох эмнэлгийн байгууллагад очих хэрэгтэй.¹⁹⁰

Дүгнэлт

Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээлэл харьцангуй бага ирдэг боловч хэрэв гэнэт ирвэл хэрхэн биеэ бэлтгэж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх вэ гэсэн асуудалд анхаарлаа хандуулах цаг болжээ.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлагаас тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс жил бүр онцгой байдлын мэргэжлийн байгууллага, алба хаагчдаар сургалт зохион байгуулж явуулах, алба хаагчдаа чадавхижуулах, арга зүйг тогтмол зааж сургаж байх шаардлага бий болжээ.

Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага мэдээлэл харьцангуй бага ирдэг, нөгөө талаараа бодистой холбоотой харилцаа нь олон хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдаж байгаа нь цагдаагийн алба хаагчдын эрх зүйн мэдлэг, бодистой харьцах арга зүйн туршлага дутах нөхцлийг бүрдүүлж байна.

Санал

Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ЦЕГ-ын даргын баталсан “Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллах журам” /код 211/-д “Аюултай бодис” хэмээх нэр томъёоны тодорхойлолтыг шинээр боловсруулж, оруулах;

2. Тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллах цагдаагийн алба хаагчийн эрх зүйн мэдлэг, арга зүйн чадварын түвшинг тогтоох шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа авч цаашид явуулах сургалтынхаа чиглэлийг тодорхой болгох;

3. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагчдад тэсэрч дэлбэрэх, химийн хортой болон аюултай бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу ажиллахад шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, арга зүйн чадвар суулгах практик сургалтыг онцгой байдлын албатай хамтран жил бүр зохион байгуулж явуулах.

Ашигласан материал

Хууль, эрх зүйн баримт бичиг:

1. Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1992. №1.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1995. №5-6.
3. Зөвшөөрлийн тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2022. №38.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2012. №22.
5. Хог хаягдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017 №21.
6. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.
7. Гамшгаас хамгаалах тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2017. №7.
8. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2006. №25.

¹⁹⁰ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -Уб., 2018. 257 дахь тал.

9. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 2013. №8.

Ном, сурах бичиг:

10.Баттогтох, П., Баяржаргал, Б. Гамшиг, ослоос хамгаалах тухай гарын авлага. -Уб., 2006.

11.Байгалмаа, П. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье. -Уб., 2011

12.Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. -Уб., 2018.

13.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -Уб., 2022.